



# ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН СЭЛЭНГЭ АЙМГИЙН НЭГДСЭН ДҮН



ᠬᠤᠨ ᠠᠮ, ᠣᠷᠤᠨ ᠰᠤᠤᠴᠨᠢ 2020 ᠣᠨᠢ  
ᠤᠯᠤᠰᠤᠨ ᠡᠭᠡᠯᠵᠢᠲ ᠲᠣᠣᠯᠯᠣᠭᠢᠨ  
ᠰᠡᠯᠡᠨᠭᠡ ᠠᠶᠢᠮᠭᠢᠶᠢᠨ ᠨᠡᠭᠳᠦᠰᠢᠨ ᠳᠤᠨ

СҮХБААТАР ХОТ  
2020 ОН



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ  
2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГО

# НЭГДЭСЭН ДҮН

## НЭГДСЭН ДҮН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

### НЭГ. УДИРДСАН

#### **Довдоннямын Гүндэгмаа**

Хэрэглээний статистикч

Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтсийн дарга

### ХОЁР. БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

#### **Хүрэлбаатар Батбаатар**

Нягтлан бодогч

Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

#### **Чулууны Цэнд- Аюуш**

Нягтлан бодогч

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

#### **Бүрэнжаргалын Хулан**

Эдийн Засагч-математик загварчлал

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

#### **Лхагвасүрэнгийн Мөнхсолонго**

Эдийн засагч-бизнесийн удирдлага

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

#### **Батбаярын Энх-Учрал**

Эдийн Засагч

Статистикийн хэлтсийн зохион байгуулагч

#### **Нацагдоржийн Оюунаа**

Барилгын инженер

Статистикийн хэлтсийн ХАОСТ-ын гэрээт ажилтан

### ГУРАВ. АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГЧ, ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

#### **Авирмэдийн Амарбал**

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга

#### **Ням-Очирын Должинсүрэн**

ҮСХ-ны Нийгмийн статистикийн албаны ахлах статистикч

#### **Машбатын Мишээл**

ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны мэргэжилтэн

## АГУУЛГА

<b>ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД</b> .....	2
<b>ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ</b> .....	4
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b> .....	8
<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР</b> .....	10
<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	11
<b>ТОВЧ ДҮГНЭЛТ</b> .....	13
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ</b>	
ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ОНЦЛОГ, УДИРДЛАГА .....	24
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ</b>	
ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ .....	35
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ</b>	
УЛСЫН ХАРЬЯАЛАЛ, ҮНДЭС, УГСАА, ШАШИН .....	43
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ</b>	
ХҮН АМЫН СУУРЬШИЛ, ХОТЖИЛТ.....	50
<b>ТАВДУГААР БҮЛЭГ</b>	
ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН .....	55
<b>ЗУРГААДУГААР БҮЛЭГ</b>	
БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ .....	66
<b>ДОЛООДУГААР БҮЛЭГ</b>	
ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ .....	75
<b>НАЙМДУГААР БҮЛЭГ</b>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ .....	82
<b>ЕСДҮГЭЭР БҮЛЭГ</b>	
ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИД .....	86
<b>АРАВДУГААР БҮЛЭГ</b>	
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ .....	91
<b>АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ</b>	
ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД .....	108
<b>АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ</b>	
ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ .....	115
ХАВСРАЛТ .....	128

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 2.1. Хүн амын тоо, тооллого явагдсан оноор, хүйсээр
- Хүснэгт 2.2. Хүн амын ердийн хөдөлгөөний үзүүлэлт, 2010-2020 он
- Хүснэгт 2.3. Сумын хүн амын өсөлт, хувиар, 2000-2020 он
- Хүснэгт 2.4. Хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хүйсийн харьцаагаар, 2010, 2020 он
- Хүснэгт 2.5. Хүн амын хүйсийн харьцаа, сумаар, 2010, 2020 он
- Хүснэгт 2.6. Хот, хөдөөгийн хүн амын тоо, хүйсээр, хүйсийн харьцаа, 2010, 2020 он
- Хүснэгт 2.7. Хүн амын насны бүтцийн үзүүлэлт, 2000, 2010, 2020 он
- Хүснэгт 3.1. Сэлэнгэ аймгийн хүн ам, гадаадын харьяат иргэдийн нас, хүйсийн бүтэц, хувиар, 2020 он
- Хүснэгт 3.2. Сэлэнгэ аймгийн харьяат иргэдийн тоо, үндэс угсаа, хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 3.3. Хүн амын тоо, үндэс угсаа, насны бүлэг, хувиар, 2020 он
- Хүснэгт 3.4. Хүн амын тархан суурьшилт, сум, үндэс, угсаа, хувиар, 2020 он
- Хүснэгт 3.5. Арван тав, түүнээс дээш насны хүн амын шашин шүтлэгийн байдал, хүйс, дүнд эзлэх хувиар, 2020 он
- Хүснэгт 3.6. Арван тав, түүнээс дээш насны хүн амын шашин шүтлэгийн байдал, шашны төрөл, хүйс, хувиар, 2020 он
- Хүснэгт 3.7. Арван тав, түүнээс дээш насны шашин шүтлэг хүн ам, насны бүлэг, шашны төрөл, хувиар, 2020 он
- Хүснэгт 4.1. Хүн амын тоо, хот, хөдөө, хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 4.2. Сумын хүн амын тоо, хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 4.3. Хүн амын тоо, бүс нутаг, өсөлт, хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 4.4. Хүн амын тоо, сум, өсөлт, хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 4.5. Хүн амын тоо, хот, хөдөө, хувиар, 1969, 1979, 1989, 2000, 2010, 2020 он
- Хүснэгт 4.6. Хүн амын тоо, нягтрал, хувиар, бүсээр, 2020 он
- Хүснэгт 4.7. Хүн амын тоо, нягтрал, хувиар, сумаар, 2010, 2020 он

**НЭГДСЭН ДҮН**

---

- Хүснэгт 5.1. Төрснөөс хойших шилжих хөдөлгөөн оролцогчид хувиар, хүйсээр, 2010, 2020 он
- Хүснэгт 5.2. Төрснөөс хойших шилжих хөдөлгөөн оролцогчид хувиар, хүйсээр, 2020 он
- Хүснэгт 5.3. Шилжих хөдөлгөөнд орсон иргэд, аймаг, нийслэлээр, хүйсээр, хувиар, 2020 он
- Хүснэгт 5.4. Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнд оролцогчид хувиар, төрсөн бүс нутгаар, 2010, 2020 он
- Хүснэгт 5.5. Шилжин ирсэн иргэд, оршин суугаа хугацаа, насны бүлэг, хувиар, 2020 он
- Хүснэгт 5.6. Таван жилийн өмнө шилжих хөдөлгөөнд оролцсон тав, түүнээс дээш насны хүн амын тоо, хүйсээр, 2020 он
- Хүснэгт 5.7. Нэг жилийн өмнө шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо, хүйсээр, 2010 он, 2020 он
- Хүснэгт 5.8. Сүүлийн нэг жилд ирэгчид, насны бүлэг, хүйсээр, 2010, 2020 он
- Хүснэгт 6.1. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хүйс, хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 6.2. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хот, хөдөө, хувиар, 2020 он
- Хүснэгт 6.3. Арав, түүнээс дээш насны хүн амын тоо, насны бүлэг, боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 6.4. Арав, түүнээс дээш насны хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг, хот, хөдөө, хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 6.5. Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт, нас, хүйс, хувиар, 2020 он
- Хүснэгт 6.6. Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт, хот, хөдөө, хүйс, хувиар, 2020 он
- Хүснэгт 6.7. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт, нас, хүйс, хувиар, 2020 он
- Хүснэгт 7.1. Өрхийн тоо, хот, хөдөө, хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 7.2. Өрхийн тоо, хот, хөдөө, өрхийн хэлбэр, хувиар, 2020 он
- Хүснэгт 7.3. Өрхийн тоо, хот, хөдөө, ам бүлийн тоо, хувиар, 2020 он
- Хүснэгт 7.4. Өрхийн тоо, сум, ам бүлийн тоо, хувиар, 2020 он
- Хүснэгт 7.5. Өрхийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөө, хувиар, 2020 он

**НЭГДСЭН ДҮН**

---

- Хүснэгт 7.6. Арван тав, түүнээс дээш насны хүн амын тоо, гэр бүлийн байдал, хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 7.7. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэр бүлийн байдал, хүйс, хувиар, 2020 он
- Хүснэгт 7.8. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, насны бүлэг, хүйс, хувиар, 2020 он
- Хүснэгт 8.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар, 2020 он
- Хүснэгт 8.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, сум, хүйс, хувиар, 2020 он
- Хүснэгт 8.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, төрөл, хэлбэрээр, хувиар, 2020 он
- Хүснэгт 10.1. Ажиллах хүчний оролцооны түвшин, хот, хөдөө, хувиар, 2020 он
- Хүснэгт 10.2. Арван тав, түүнээс дээш насны хүн амын тоо, хөдөлмөр эрхлэлтийн байдал, насны бүлэг хүйс, хувиар, 2020 он
- Хүснэгт 10.3. Хөдөлмөр эрхэлдэг хүн амын тоо, хүйс, хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 10.4. Арван тав, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн амын тоо, хүйс, хот, хөдөө, хувиар, 2020 он
- Хүснэгт 10.5. Арван тав, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2010, 2020 он
- Хүснэгт 10.6. Арван тав, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн ам, ажил мэргэжлийн ангилал, хүйс, хувиар, 2020 он
- Хүснэгт 10.7. Арван тав, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн ам, ажил мэргэжилийн ангилал хүйс хувиар 2020 он
- Хүснэгт 10.8. Арван тав, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хувиар, 2020 он
- Хүснэгт 10.9. Арван тав, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны салбар хувиар, 2020 он
- Хүснэгт 10.10. Арван тав, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хот, хөдөө, хувиар, 2020 он
- Хүснэгт 10.11. Хөдөлмөр эрхэлдэг хүн амын ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, хувиар, 2010 он , 2020 он
- Хүснэгт 10.12. Ажилгүйдлийн түвшин, хүйс, хот, хөдөөгөөр 2020 он

**НЭГДСЭН ДҮН**

---

- Хүснэгт 10.13. Арван тав, түүнээс дээш насны ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо ажил эрхлээгүй байгаа шалтгаан, хүйсээр, 2020 он
- Хүснэгт 10.14. Арван тав, түүнээс дээш, эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, насны бүлэг, хөдөлмөр эрхлээгүй шалтгаанаар, 2020 он
- Хүснэгт 11.1. Гадаадад оршин суугаа монгол улсын иргэдийн тоо, насны бүлэг, хүйсээр, 2020 он
- Хүснэгт 11.2. Гадаадад оршин суугаа сэлэнгэ аймгийн иргэд, байнга сууж байсан сумаар, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он
- Хүснэгт 11.3. Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, оршин суугаа улс, оршин суугаа хугацаа, дүнд эзлэх хувиар, 2020 он
- Хүснэгт 11.4. Гадаадад оршин суугаа иргэд, оршин суугаа улс, тооллогын үед сууж байгаа зорилго, дүнд эзлэх хувиар, 2020 он
- Хүснэгт 11.5. Гадаадад оршин суугаа иргэд, тооллогын үед сууж байгаа зорилго, насны бүлэг, дүнд эзлэх хувиар, 2020 он
- Хүснэгт 12.1. Өрхийн тоо, сууцны төрөл хот, хөдөө, хувиар, 2020 он
- Хүснэгт 12.2. Өрхийн тоо, сууцны төрөл, хувиар 2010, 2020 он
- Хүснэгт 12.3. Өрхийн тоо, сууцны төрөл, сууцны өмчийн хэлбэр, хувиар, 2020 он
- Хүснэгт 12.4. Өрхийн тоо, сууцны өмчийн хэлбэр, хот, хөдөө хувиар, 2020 он
- Хүснэгт 12.5. Өрхийн тоо, сууцны эзэмшлийн хэлбэр, хот, хөдөө, хувиар, 2020 он
- Хүснэгт 12.6. Өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, хот, хөдөө, хувиар, 2020 он
- Хүснэгт 12.7. Гэрт амьдардаг өрхийн тоо, ам бүлийн тоо, гэрийн ханын тоо, хувиар, 2020 он
- Хүснэгт 12.8. Гэрт амьдардаг өрхийн тоо, ахуйн нөхцөлийн зарим үзүүлэлт, хот, хөдөө, хувиар, 2020 он
- Хүснэгт 12.9. Байшинд амьдардаг өрхийн тоо, ам бүлийн тоо, сууцны талбайн хэмжээ, хувиар, 2020 он
- Хүснэгт 12.10. Байшинд амьдардаг өрхийн тоо, ам бүлийн тоо, өрөөний тоо, хувиар, 2020 он
- Хүснэгт 12.11. Байшинд амьдардаг өрхийн тоо, халаалтын төрөл, хот, хөдөө, хувиар, 2020 он
- Хүснэгт 12.12. Байшинд амьдардаг өрхийн усан хангамжийн төрөл, хот, хөдөө, 2020 он
- Хүснэгт 12.13. Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн зарим үзүүлэлт, хот, хөдөө, хувиар, 2020

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын удирдлага, зохион байгуулалтын бүтэц
- Зураг 2.1. Хүн амын тоо, 2020 он
- Зураг 2.2. Хүн амын 1959 - 2020 оны тооллого хоорондын жилийн дундаж өсөлт, хувиар
- Зураг 2.3. Хүн амын нас, хүйсийн суварга, 2010, 2020 он
- Зураг 2.4. Хүн амын насны бүтэц, хувиар, 2000, 2010, 2020 он
- Зураг 3.1. Хүн амын тоо, иргэний харьяаллаар, 2020 он
- Зураг 3.2. Сэлэнгэ аймагт оршин суугаа гадаадын харьяат иргэд, улсаар, хувиар, 2010, 2020 он
- Зураг 3.3. Хүн ам, үндэс угсаа, хувиар, 2020 он
- Зураг 3.4. Казах угсаатны бүлгийн тархалт, сумдаар, 2020 он
- Зураг 3.5. Дөрвөд угсаатны бүлгийн тархалт, сумдаар, 2020 он
- Зураг 3.6. Арван тав, түүнээс дээш насны шашинтнууд, шашны төрөл, хувиар, 2020 он
- Зураг 4.1. Хүн амын нягтрал, сумаар, 2020 он
- Зураг 5.1. Шилжигчдийн тоо, хугацаа, нутаг дэвсгэрээр, 2010, 2020 он
- Зураг 5.2. Хүн амын шилжилт хөдөлгөөнд оролцсон байдал, насны бүлэг, хувиар, 2020 он
- Зураг 5.3. Сүүлийн нэг жилд шилжин ирэгчид, насны бүлэг, хүйсээр, 2020 он
- Зураг 6.1. Дээд боловсролтой хүн ам, насны бүлэг, хүйс, хувиар, 2020 он
- Зураг 6.2. Хүн амын тоо, боловсрол, бичиг үсгийн мэдлэгээр, 2020 он
- Зураг 6.3. Арван тав, түүнээс дээш насны хүн амд бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь, насны бүлгээр, 2020 он
- Зураг 6.4. Сургуульд суралцагчдын хүйсийн харьцаа, насны бүлгээр, 2020 он
- Зураг 7.1. Өрх, Өрхөд хамааралгүй тоологдсон хүн амын тоо, 2020 он
- Зураг 7.2. Өрхийн тоо, хэлбэрээр, 2020 он
- Зураг 7.3. Анхны гэрлэлтийн дундаж нас, 2000, 2010, 2020 он

- Зураг 8.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын нас, хүйсийн суварга, тоогоор, 2020 он
- Зураг 8.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, төрөл, хэлбэрээр, хувиар, 2020 он
- Зураг 9.1. Зургаа, түүнээс дээш настай суурин хүн амд гар утас хэрэглэгчдийн эзлэх хувь, аймаг, нийслэлээр, 2010 он 2020 он
- Зураг 9.2. Зургаа, түүнээс дээш насны хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь, сумаар 2020 он
- Зураг 9.3. Зургаа, түүнээс дээш насны хүн амын интернет хэрэглээ, 2020 он
- Зураг 9.4. Интернет хэрэглэгчийн нас, хүйсийн суврага, тоогоор, 2010, 2020 он
- Зураг 9.5. Зургаа, түүнээс дээш насны хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувь, сумаар, 2020 он
- Зураг 10.1. Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхийн талаарх бүдүүвч, 2020 он
- Зураг 10.2. Арван тав, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, хувиар, 2020 он
- Зураг 10.3. Ажиллах хүчний оролцооны түвшин, сумдаар, хувиар, 2020 он
- Зураг 10.4. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, 2020 он
- Зураг 10.5. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар, 2020 он
- Зураг 10.6. Хөдөлмөр эрхлэлтийн хуучин болон шинэ статусыг харьцуулсан байдал
- Зураг 10.7. Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр, хувиар, 2020 он
- Зураг 11.1. Гадаадад оршин суугаа иргэдийн нас, хүйсийн суварга, 2020 он
- Зураг 11.2. Гадаадад оршин суугаа монгол улсын иргэд, тооллогын үед сууж байгаа зорилго, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он
- Зураг 12.1. Хүн амьдран суух зориулалттай нийт сууц болон хүн байнга амьдардаг сууцны тоо, төрлөөр, 2020 он
- Зураг 12.2. Өрхийн тоо, сууцны төрлөөр, 2020 он
- Зураг 12.3. Гэрт амьдардаг өрхийн усан хангамж, хувиар, 2020 он
- Зураг 12.4. Байшинд амьдардаг өрхийн хатуу хог, хаягдал зайлуултын хэлбэр, хувиар, 2020 он
- Зураг 12.5. Байшинд амьдардаг өрхийн бохир ус зайлуулалтын хэлбэр, хувиар, 2020 он

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГИХАЭГ	Гадаад иргэн харьяатын асуудал эрхлэх газар
ГХБХБГ	Гадаад харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ТМС	Техник мэргэжлийн сургууль
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого

## ТАЛАРХАЛ



Уудам Монгол орныхоо хойморт тухлах Сэлэнгэ сайхан нутгийн ажилсаг хөдөлмөрч иргэдийнхээ өмнөөс энэхүү номыг дэлгэн буй та бүхний амар амгаланг эрэн мэндчилье.

Монгол Улс хүн амын тооллогыг 1918 онд анх удаа зохион байгуулсан тэр үед манай улсын хүн ам ердөө 647.5 мянга байсан бол 1956 оноос тооллогыг мэргэжлийн байгууллага зохион байгуулан явуулж аргачлал, хөтөлбөрийн хувьд нэлээд боловсронгуй болж, 1963 оны тооллогоор орон сууцны талаарх асуулт оруулж, анх удаа цахим тооцоолуур ашигласан зэргээр хүн амын тооллого улам чанаржин сайжирсаар иржээ.

Тооллогыг явуулснаар хүн амын тоо, нас хүйсийн бүтэц, суурьшил, шилжилт, хотжилт, ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, орон сууцны хангамж, нөхцөл зэрэг хүн ам, эдийн засаг, нийгмийн бусад олон шинж төрхийг агуулсан өргөн мэдээллийг цуглуулж, түүнийг Засаг захиргааны бүх нэгжээр боловсруулж гаргадгаараа хүн амын талаарх мэдээллийн бусад эх үүсвэрээс давуу талтай бөгөөд уг тоо баримт, тооцоо судалгаанд үндэслэн аймаг, орон нутгийн хэмжээний бодлого, хөтөлбөр боловсруулахад чухал ач холбогдолтой юм.

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн хүрээнд 11 дэх удаагийн тооллогыг бүртгэл болон уламжлалт аргыг хослуулан амжилттай зохион байгуулахад аймаг, сумын хэмжээнд нэгдсэн удирдлага, заавраар хангаж голлох үүргийг гүйцэтгэсэн аймаг, сумын тооллогын комисс, түр товчооны гишүүд, аймгийн Статистикийн хэлтсийн хамт олон болон нийт тоологч, шалгагч нартаа чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА Г.БЯМБАА

## ӨМНӨХ ҮГ



Өөдөө заяатай, өгөөж баян Сэлэнгэ сайхан нутгийнхаа бүрэн эрхт эзэд, энэ нутагтай ажил амьдралын холбоотой бүх хүмүүсийнхээ амар мэндийг айлтган мэндчилье.

Бүрэн эрхт Монгол Улсын түүхэн чухал үйл явцын нэг бол хүн ам, орон сууцны тооллого юм. Энэхүү тооллого нь улс үндэстний хувьд соёл иргэншилтэй нягт холбоотой үйл явц юм.

Монгол Улс хүн ам, орон сууцны 11 дэх удаагийн тооллогыг 2020 оны 1 дүгээр сарын 09-нөөс 15-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Манай аймгийн хэмжээнд 2020 оны хүн ам, орон сууцны тооллогод 68 тоологч, 19 шалгагч ажиллалаа.

Энэхүү тооллогын онцлог нь Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн хүрээнд явагдсан анхны тооллого төдийгүй бүртгэл болон уламжлалт гэсэн хосолмол аргаар явагдсанаараа онцлогтой боллоо.

Засаг захиргааны анхан шатны нэгжийн түвшинд ард түмнийхээ аж байдлыг өрх, иргэн бүрээр тодорхойлж, өнгөрсөн жилүүдийн ололт, амжилтыг дүгнэн, ирэх он жилүүдийн бодлого төлөвлөлтийг төлөвлөх суурь мэдээллийг бий болгосон энэхүү тооллогыг амжилттай зохион байгуулсан аймгийн Статистикийн хэлтсийн хамт олондоо аймгийн тооллогын комиссын нэрийн өмнөөс талархал илэрхийлье.

Хүн ам, орон сууцны 2020 оны энэхүү тооллогын үр дүнд үндэслэн аймаг, орон нутгийнхаа онцлогт тохируулан нийцүүлсэн, хөгжлийн зөв зохистой загвар, үзэл баримтлал бүхий бодлогын баримт бичгийг тодорхойлон боловсруулж, амжилт, ололтоо улам бүр бататган ажиллана.

Хийморь өөдөө, буян заяа төгс Сэлэнгэ түмний минь ажил үйлс үеийн үед өөдлөн дэвжих болтугай.

*“Хамтын зүтгэлээр эх нутгаа хөгжүүлье”*

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА,  
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮН АМ,  
ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Ш. ОРГИЛ

# ТОВЧ ДҮГНЭЛТ



<sup>1</sup>Хоорондоо хамааралтай хэд хэдэн ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг нийлэмэл өрх гэнэ.

<sup>2</sup>Ураг төрлийн хамааралтай болон хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг холимог өрх гэнэ.

## СУУРЬШИЛ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН



## АЙМАГ, НИЙСЛЭЛ ХООРОНДЫН ШИЛЖИГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ





## БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

10, түүнээс дээш настай хүн амын хувьд



## ХҮН АМЫН СУУРЬШЛЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ, СУМААР






### ҮНДЭС, УГСАА


Хаах	Казах	Дорвод
85.6%	0.9%	2.9%
Баяд	Бурнад	Бусад
3.4%	0.7%	6.5%

### БАЙШИН, ОРОН СУУЦ, ӨРХИЙН ТОО



### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

дүнд эзлэх хувиар



### ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ



## ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Монгол Улсын 2020 оны тооллогоор гарсан Сэлэнгэ аймгийн суурин хүн амын тоог 2010 оны тооллогын үр дүнтэй харьцуулахад 10.4 хувиар буюу 10171 хүнээр өсөж, 107.7 мянгад хүрлээ.

Хүн амын өсөлт жилд дунджаар 2000 оны тооллогоор 1.3, 2010 онд - 0,2 хувиар буурч байсан бол 2020 онд 1.28 хувь болж өслөө. Энэ нь хүн амын цэвэр өсөлт сүүлийн 10 жилд 1.5 пунктээр нэмэгдсэнтэй холбоотой.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш сумдын хүн амын өсөлт эрс ялгаатай байсан. Тухайлбал, 2000-2010 онд 6 сумын хүн амын тоо 102.3-127.2 хувиар өсөж бусад суманд 4.2-26.6 хувиар буурч байсан бол 2020 онд 17 сум бүгд өсөлттэй гарч байна. Тэр дунд Түшиг, Хүдэр, Цагааннуур сумын хүн ам хамгийн их буюу 20.2-30.9 хувийн өсөлттэй байгаа бол Орхонтуул, Шаамар, Ерөө, Алтанбулаг, Жавхлант, Мандал, Баянгол сумын хүн ам хамгийн бага буюу 4.2-9.4 хувийн өсөлттэй байна. Бусад сумын хувьд 10.7–18.8 хувийн өсөлттэй байна.

Нийт хүн амд 0-14 насны хүн амын эзлэх хувь 2010 онд 29.2 хувийг хүүхэд, 67.1 хувийг хөдөлмөрийн насны, 3.7 хувийг тэтгэврийн насны хүн ам эзэлж байсан бол 2020 онд 0-14 насны хүүхэд 30.4 хувь, хөдөлмөрийн насны 15-64 насны хүн 65.2, 65 ба түүнээс дээш тэтгэврийн насны хүн 4.4 хувийг эзлэх болсон байна. Хүн амд хүүхдийн эзлэх хувийн жин өсөж, хүн ам зүйн ачаалал нэмэгдэж 2020 онд 53.4 хувьд хүрсэн нь 2010 оноос даруй 4.4 пунктээр ихэссэн байна. Энэ нь хүн амын бүтэц улам залуужиж, дундаж наслалт уртсаж байгаатай холбоотой юм.

Хүйсийн харьцаа дүнгээрээ өмнөх тооллоготой ойролцоо байгаа боловч, насны бүлэг ахих тусам буурч байгаа нь эрэгтэйчүүдийн нас баралт харьцангуй илүү байгаатай холбоотой.

## УЛСЫН ХАРЬЯАЛАЛ, ҮНДЭС, УГСАА, ШАШИН

Сэлэнгэ аймагт 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадын харьяат иргэдийн тоо 2010 оныхоос 126 иргэнээр буурч 197 болжээ.

2010 оны тооллоготой харьцуулахад БНХАУ-ын иргэдийн эзлэх хувь 16.1 пунктээр буурч, ОХУ-ын иргэд 9.2 пунктээр нэмэгджээ. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Баянгол, Ерөө, Мандал, Сайхан сумдад гадаадын харьяат иргэдийн 92.4 хувь нь оршин сууж байна.

Насны бүтцийг авч үзвэл 17.3 хувийг 15-24 насны, 21.3 хувийг 25-34 насны, 14.2 хувийг 35-44 насны, 18.2 хувийг 45-54 насны иргэд, 19.3 хувийг 55-аас дээш насны иргэд эзэлж байна.

Гадаадын харьяат иргэдийн 68.0 хувийг эрэгтэйчүүд, 32.0 хувийг эмэгтэйчүүд эзэлжээ. Эндээс гадаадын харьяат иргэдийн дийлэнх нь хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд байгааг харуулж байна.

Сэлэнгэ аймгийн хүн амын 85.4 хувийг халхчууд эзэлж байгаа нь өмнөх тооллогоос 2.6 пунктээр өсжээ. Баяд, дөрвөд, урианхай, тува, захчин, дархад, торгуудын эзлэх хувь 0.1-0.6 пунктээр буурчээ.

Үндэс, угсааг байршлаар харвал баядууд Баянгол, Хушаат, Цагааннуур сумдад олноор, дөрвөдүүд Ерөө, Сайхан, Орхонтуул сумдад, урианхайчууд Ерөө, Хушаат, Орхонтуул сумдад, хотонгууд Баруунбүрэн, Цагааннуур суманд голлон суурьшжээ.

Хотон, халх, тува, казакуудын дунд 0-14 настай хүүхдийн эзлэх хувь аймгийн дунджаас өндөр байгаа нь тэдний дунд төрөлтийн түвшин өндөр байгаатай холбоотой юм. Харин буриад, дархад, урианхай, захчингуудын дунд 45-аас дээш настай хүний эзлэх хувь 30-аас илүү байна.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 54.9 хувь нь ямар нэг шашингүйчүүд, 38.4 хувь нь буюу 3.1 мянган хүн нь буддын шашинтан ажээ. Харин эрэгтэйчүүдийн шашин шүтдэггүй байдал эмэгтэйчүүдийнхээс 7.1 пунктээр илүү байна.

Шашин шүтдэг хүн амын дотор эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү олон байна. Эмэгтэйчүүдийн хувьд христийн шашин шүтэх байдал эрэгтэйчүүдтэй харьцуулахад олон байгаагийн дийлэнх нь залуучууд байна. Шашин шүтдэг хүмүүс нас ахих тутам уламжлалт буддын шашинг илүү шүтдэг байна.

## ХҮН АМЫН СУУРЬШИЛ, ХОТЖИЛТ, НЯГТРАЛ

Сэлэнгэ аймгийн хүн амын тоо өссөн тул хүн амын нягтрал мөн өсжээ. 2010 онд нэг квадрат километр нутаг дэвсгэрт 2.3 хүн ногдож байсан бол 2020 онд 2.6 болж өсөв.

Аймгийн хүн амын нягтралын өөрчлөлтөд хүн амын ердийн цэвэр өсөлт нөлөөлснөөс гадна шилжих хөдөлгөөн ихээхэн нөлөөлж байна. Сүхбаатар сумын хүн амын нягтрал 2010-2020 оны хооронд 45.6 хүнээр өссөн нь мөн л шилжих хөдөлгөөнтэй холбоотой юм.

Хүн амын нягтралыг сумаар харвал Сүхбаатар сум хүн амын нягтралаараа хамгийн өндөр байна. Өмнөх тооллогын үед тухайн сумын нэг метр квадрат нутаг дэвсгэрт 433.7 хүн ногдож байсан бол 2020 онд 479.3 болж 45.6 хүнээр өсжээ. Энэ нь хүн амын ердийн өсөлт, шилжих хөдөлгөөнтэй холбоотой юм. Сүхбаатар сум Сэлэнгэ аймгийн бүх нутаг дэвсгэрийн дөнгөж 0.11 хувийг эзэлдэг атлаа хүн амын 21.0 хувь нь оршин сууж байна. Сүхбаатар сумын хүн амын нягтрал улсын дунджаас 477.2 хүнээр, Улаанбаатар хотоос 151.7 хүнээр олон байна. Хүн ам хамгийн сийрэг суурьшилтай сумдад Түшиг (нэг километр квадрат нутаг дэвсгэрт 0.7 хүн), Ерөө (нэг километр квадрат нутаг дэвсгэрт 0.8 хүн), Хушаат (нэг километр квадрат нутаг дэвсгэрт 1.0 хүн), Хүдэр (нэг километр квадрат нутаг дэвсгэрт 1.0 хүн) сумд багтаж байна.

## ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Сэлэнгэ аймгийн суурин хүн амын 21.0 хувь нь аймгийн төвд, 13.5 хувь нь тосгонд, 65.5 хувь нь сумын төв болон хөдөөд амьдарч байна. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 27.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 20.8 пунктээр буурчээ.

Сүүлийн 5 жилд шилжилт хөдөлгөөнд оролцогчид 6704 байгаа нь 2010 оноос 49.8 хувиар буурчээ. Сүүлийн 1 жилд шилжилт хөдөлгөөнд оролцогчдын тоо 2744 бөгөөд үүнээс 1178 нь нийслэл, 1434 нь бусад аймаг хооронд шилжилт хөдөлгөөнд оролцсон байна.

Сүүлийн 1 жилийн шилжих хөдөлгөөнд оролцогч 2.7 мянган хүн байгаа нь 2010 оныхтой харьцуулахад 31.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хүн амын 27.7 хувь нь шилжин иржээ. тэдгээрийн 1.6 хувь нь нэг жил хүртэл, 5.7 хувь нь 1-3 жил, 14.5 хувь нь 4-9 жил, 78.2 хувь нь 10, түүнээс дээш жилийн өмнө шилжин ирж суурьшжээ.

Аймгийн хүн амын 72.3 хувь, үүний дотор эрэгтэйчүүдийн 74.5 хувь, эмэгтэйчүүдийн 70.2 хувь нь төрснөөсөө хойш тухайн аймагт оршин сууж байна.

Сэлэнгэ аймгаас бусад аймаг, нийслэл рүү 36.9 мянган хүн шилжин явсан байхад тухайн аймагт 29.8 мянган хүн шилжин ирсэн байна. Сэлэнгэ аймагт ирж суурьшсан хүн амын дотор эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс цөөн, тус аймагт байнга оршин сууж байгаад өөр аймаг, нийслэл рүү явж суурьшсан хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байна.

Тооллогын үед тус аймагт байнга оршин суугаа хүн амын 51.5 хувь нь Сэлэнгэ аймагт төрснөөсөө хойш оршин суугаа бол 14.5 хувь нь Улаанбаатар хотоос, 14.3 хувь нь Увс аймгаас, 7.5 хувь нь Архангай аймгаас, 0.1-7.2 хувийг нь бусад аймгаас шилжиж иржээ.

Хүн амын шилжих хөдөлгөөнд оролцсон байдлыг насны бүлгээр авч үзвэл сонирхолтой дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал 0-24 насны хүн амын дийлэнх нь тухайн аймгийн уугуул иргэд байхад 25-29 наснаас эхлэн шилжин ирэгчдийн эзлэх хувь эрс нэмэгдэж, 25-29 насныхны 26.6 хувь, 55-59 насныхны 54.1 хувь, 70-аас дээш насныхны 66.7 хувь нь нь шилжин ирэгчид болжээ.

Сүүлийн нэг жилд шилжих хөдөлгөөнд оролцсон эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 39 хувиар илүү байгаа нь эрэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд давамгайлж байгааг харуулна. Ялангуяа 20-54 насны эрэгтэйчүүд илүү байгаа юм. Ахимаг насанд эрэгтэйчүүдийн шилжих хөдөлгөөн давамгайлж байгааг тэд эхлээд зорьсон газраа ганцаараа очиж, дараа ар гэрийнхнийгээ татаж авч байгаатай холбон тайлбарлаж болно. Арван таваас доош насны хүүхдүүд, 60-аас дээш насны өндөр настнууд шилжих хөдөлгөөнд оролцсон байгаагаас үзэхэд гэр бүлээрээ шилжих явдал байгааг гэрчилнэ.

## БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Арав, түүнээс дээш настай хүн амд боловсролтой хүн амын эзлэх хувийн жин өмнөх тооллогын үеийнхээс 2.8 пунктээр нэмэгдэж, 95.7 хувь болсон байна. Боловсрол эзэмшигчийг хүйсээр ангилж үзэхэд нэлээд ялгаатай байдал ажиглагдана. Энэ удаагийн тооллогоор дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 9.1 хувиар илүү байна.

Боловсролгүй хүний эзлэх хувь хөдөөд хотоос 0.5 пунктээр их бол дээд боловсролтой хотын хүн ам хөдөөгийнхөөс 4.5 пунктээр их байна. Харин хотод бүрэн дунд боловсролтой хүн ам олон байхад хөдөөд суурь болон бага боловсролтой хүн илүү олон байна.

Хөдөөгийн дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс өндөр, суурь болон бага боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа нь хөдөөгийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсролтойг харуулжээ. Энэ байдал хот суурин газарт мөн ажиглагдаж байна. Тиймээс боловсролын энэхүү ялгаатай байдалд анхаарал хандуулах нь зүй ёсны асуудал болоод байна.

Сэлэнгэ аймгийн 15, түүнээс дээш насны хүн амын 98.6 хувь бичиг үсэг мэдэж байгаа нь улсын дунджаас 0.1 хувиар бага байна. Харин хот, хөдөөгийн оршин суугчдын хувьд 0.8 пунктээр зөрүүтэй байна. Арван тав, түүнээс дээш насны хотын хүн амын 0.9 хувь буюу 26 хүн бичиг үсэг мэдэхгүй байгаагаас үзэхэд хотынхон бараг бүхэлдээ бичигтэн болсон гэж болно.

Сургуульд хамрагдалт 11 жилийн өмнөхөөс сайжирчээ. Тухайлбал, 2010 онд 6 настай бүх хүүхдийн 94.4 хувь нь сургуульд сурч байсан бол 2020 онд 96.3 хувь болж өсжээ.

Сургуульд хамрагдалт хот, хөдөөд ойролцоо байна. Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт нийт дүнгээрээ хотод 79.1 хувь, хөдөөд 70.9 хувь байна.

Сургуульд хамрагдалтын байдал 20-24 насны хүн амд 59.3 хувь болж 2010 оноос 41.5 пунктээр өссөн нь хамгийн өндөр байна. Сургуульд хамрагдалтыг хот, хөдөөгөөр харвал 14 нас хүртэл хөдөөд өндөр байсан бол 15, түүнээс дээш насанд хотын хүн амын сургууль хамрагдалт өндөр болж байна. Энэ хандлага нь нас ахих тусам нэмэгдсээр 25-29 насанд хотын хүн амын сургуульд хамрагдалт хөдөөгийнхөөс 3.9 пунктээр өндөр байна.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нас буюу 2-оос 5 насны хүүхдийн 84.7 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байна. Сургуульд орох нас дөхөх тусам сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт нэмэгдэх ажээ. Тухайлбал, 2 настай хүүхдийн 65.0 хувь, 5 настай хүүхдүүдийнх 95.3 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна.

## ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 97.9 хувь нь 105.5 мянган хүн өрхөд, үлдсэн 2.1 хувь буюу 2.2 мянган хүн өрхөд хамаарахгүйгээр тоологджээ. Аймгийн хэмжээнд өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 7.9 хувиар нэмэгдэж, өрхөд хамаарахгүйгээр тоологдсон хүн ам 15.3 хувиар буурчээ.

Нийт өрхийн 13.4 хувь нь ганц бие, 60.0 хувь нь ам бүлээрээ байгаа, 25.3 хувь нь нийлмэл, 1.3 хувь нь холимог ам бүлтэй өрх байна. Нийт өрхийн дотор ам бүлээрээ буюу нөхөр, эхнэр, хүүхдийнхээ хамт амьдарч байгаа өрх дийлэнх хувийг эзэлж байна. Мөн нийлмэл буюу эцэг эх, ах, дүүс, садан төрлөөрөө хамт амьдарч байгаа өрх ч олон юм.

Өрхийн бүтцийг хот хөдөөгөөр авч үзэхэд ам бүлээрээ амьдарч байгаа өрх болон нийлмэл өрх дийлэнх хувийг эзэлж байна. Хот, хөдөөд ганц бие өрхийн тоо өмнөх тооллогын дүнгээс 34.9 хувиар өсөж, нийлмэл ам бүлтэй өрхийн эзлэх хувь 6.4-7.4 пунктээр буурчээ. Ганц бие өрхийн тоо өссөнийг шилжих хөдөлгөөнтэй холбон тайлбарлаж болно. Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс 5.2 пункт, байршлын хувьд хотод 6.0 пункт, хөдөөд 5.8 пунктээр тус тус нэмэгджээ. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо нэмэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

Ерөнхийдөө огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс олон байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа нөхөрт гардгийг харуулна. Эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж насыг эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад бага байдаг. Огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өмнөх тооллогын үеийнхээс 5.4 пунктээр өсжээ. Харин бэлэвсэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 4.6 дахин их байгаа нь эрэгтэйчүүдийн нас баралт их байдагтай холбоотой.

Анхны гэрлэлтийн дундаж нас 27.8 болсон бөгөөд 2010 онтой харьцуулахад 0.7 насаар хойшилсон байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа ойролцоогоор нэг насны зөрүүтэй байгаа нь сүүлийн 10 жилд гэрлэлт оройтож байгааг харуулж байна.

Нөгөө талаар 15-34 насанд нөхөрт гарсан эмэгтэйчүүд, 35-аас дээш насанд гэрлэсэн эрэгтэйчүүд олон байхад аль ч насанд бэлэвсэн эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс мэдэгдэхүйц их байна. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү урт насалдагтай холбоотойгоор тэд эрэгтэйчүүдээс эрт бэлэвсэрч байгааг илтгэнэ. Ялангуяа, 65, түүнээс дээш насанд бэлэвсэн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс 4.6 дахин их байна.

Гэр бүлээ цуцалсан хүний тоог хүйсээр ангилж үзэхэд 25-54 насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү, ялангуяа, 25-34 насанд хамгийн их зөрүүтэй (4.1 пункт), харин 35-аас дээш насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү байна.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ

Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 4416 хүн тоологдсон нь аймгийн хүн амын 4.1 хувийг эзэлж байгаа нь улсын дундажтай /улсын дундаж 4.2 хувь/ ойролцоо байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 55.6 хувь нь эрэгтэйчүүд, 44.4 нь эмэгтэйчүүд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь 35-54 насанд хамгийн их байгаа нь тэдний дийлэнх нь үйлдвэрлэл болон ахуйн ослоос хамаарч хөгжлийн олдмол бэрхшээлтэй болжээ.

Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 26.6 хувь нь Сүхбаатар хотод, 20.6 хувь нь Мандал суманд ногдож байна. Дараа нь Алтанбулаг, Ерөө, Сайхан, Цагааннуур сум оржээ. Бүх сумдад хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс 1.1-2.0 дахин өндөр, тухайлбал Сант суманд 2 дахин, Жавхлант, Түшиг сумдад 1.5 дахин их байна.

Аймгийн хэмжээнд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 3 хүн тутмын нэг нь төрөлхийн, хоёр нь олдмол бэрхшээлтэй байна. Энэ байдал хүйсийн хувьд ч ижил хандлагатай байгаа нь үйлдвэрлэлийн болон осол, хоол хүнсний зохисгүй хэрэглээ, амьдралын буруу зуршил зэргээс хамаарч хөгжлийн бэрхшээлтэй болдгийг нотолж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 22.8 хувь нь сэтгэцийн, 22.2 хувь нь хөдөлгөөний, 33.0 хувь нь бусад хэлбэрийн, үлдсэн хувь нь харааны, ярианы сонсголын хөгжлийн бэрхшээлтэй байна.

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дотор хөдөлгөөний, харааны болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь, харин олдмол бэрхшээлтэй иргэдийн дотор бусад хэлбэрийн бэрхшээл, хөдөлгөөний болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь их байгаа нь дээрх дүгнэлтийг давхар нотолно. Ялангуяа, төрөлхийн болоод сэтгэцийн бэрхшээлтэй хүн амын эзлэх хувь их байгааг удамшлын эмгэг, эх барихын болон төрөх үеийн хүндрэл зэрэг шалтгаанаар олон талаас нь нарийвчилж судлах шаардлагатай.

## ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИД

Сэлэнгэ аймгийн 6, түүнээс дээш насны хүн амын гар утасны хэрэглээг улсын дундажтай харьцуулахад 0.3 пунктээр доогуур байна. Хөдөлмөрийн нас болох 15-59 насны хүн амын 97.5 хувь нь гар утас хэрэглэж байгаагаас 35-39 насныхан хамгийн их ажээ.

Сэлэнгэ аймаг нь интернэтийн хэрэглээгээр улсын дунджаас 1.9 пунктээр доогуур байна.

Дэлхий нийтээр даяаршиж интернэтийн хэрэглээ маш хурдан өссөөр байгаа ба Монгол Улсад ч бас 3G болон 4G сүлжээ орж ирснээр гар утас болон байнга интернэт хэрэглэгчдийн тоо ихэссэн байна.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн насны буюу арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 53.9 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 3.8 пунктээр буурсан бол ажиллах хүчнээс гадуурх хүн ам (46.1%) 3.8 пунктээр өсжээ.

Хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, эмэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байна. Байршлын хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд хотынхоос өндөр байна. Ялангуяа, хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 61.1 хувь байгаа нь хотынхоос 2.5 пунктээр илүү байна.

Нийт хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 8.3 пунктээр буурсан байхад эдийн засгийн идэвхгүй хүн амын хувийн жин 3.8 пунктээр өссөн байна. Ялангуяа 20-34 насанд эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс 11.3-17.0 пунктээр их байгаа нь тухайн насны их, дээд сургуульд суралцагч эмэгтэйчүүд илүү байдагтай холбоотой.

Хүн амын ажил эрхлэлтийн байдал сүүлийн 10 жилийн хугацаанд багагүй өөрчлөгджээ. 2010 онд өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч, нийт ажиллагсдын 13.2 хувийг эзэлж байсан бол 2020 онд 2.5 хувь болтол буурсан байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хувийн жин 3.7 пунктээр, цалин хөлстэй ажиллагч 8.6 пунктээр тус тус нэмэгдсэн байхад ажил олгогчийн хувийн жин 1.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 онд 2010 оныхоос 14.1 пунктээр буурсны дотор хотод 14.5 пунктээр, хөдөөд 13.8 пунктээр тус тус буурсан байна. Ажил эрхэлдэггүй эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс их байгаатай холбоотойгоор ажилгүйдлийн түвшин ч мөн адил эрэгтэйчүүдийнх өндөр гарчээ.

Нийт ажилгүй иргэдийн дотор 25-49 насны 1.6 мянган (ажилгүй иргэдийн 77.3 хувь) хүн байгаа нь ид ажиллах насны хүмүүс ажилгүй байгаа нь ажлын байрны олдоц муу, цалин хөлсний хэмжээ доогуур байгаатай холбоотойгоор тайлбарлаж болох юм. Харин 15-24 насныхны хувьд нийт ажилгүйчүүдийн 6.7 хувийг эзэлж байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 10 хүн тутмын 4 нь эрэгтэйчүүд, 6 нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд эдийн засгийн идэвхгүй хүн ам нийтдээ 34546 байгаа нь 2010 оныхоос 20.4 хувиар, үүний дотор сургуульд суралцагчид 55.9 хувь, бусад шалтгаан 2 дахин өсжээ.

## ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 2553 иргэн тоологдож, 2010 оноос 30.3 хувиар өсжээ. Гадаадад оршин суугаа иргэдийн насны бүтцийг харвал 0-14 насны хүн ам 9.7 хувь, 15-44 насныхан 75.5 хувь, 45-64 насныхан 14.3 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 0.5 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, гадаадад удаан хугацаагаар суугаа хүн амын 10 хүн тутмын 9 нь хөдөлмөрийн насны хүн ам байна.

Зуун эмэгтэйд ногдох эрэгтэй хүн ам буюу хүйсийн харьцаа 101.3 байгаа (50.3 хувь эрэгтэй, 49.7 хувь эмэгтэйчүүд) нь гадаадад оршин суугаа эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдээсээ олон байгааг илтгэх бөгөөд хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам буурч, 35 наснаас эхлэн огцом буурчээ. 0-29 насныхны хувьд дийлэнх нь эрэгтэйчүүд байхад хөдөлмөрийн насны болон ахмад настнуудын хувьд эмэгтэйчүүд илүү байна.

Гадаадад оршин суугаа иргэдийн тоог Сэлэнгэд байнга амьдарч байсан сумаар харвал 34.2 хувь нь Сүхбаатар сумаас, 25.9 хувь нь Мандал сумаас, 9.6 хувь нь Сайхан сумаас, 6.2 хувь нь Алтанбулаг сумаас, 24.1 хувь нь бусад сумдаас гадаад улсад оршин суухаар явжээ.

Гадаадад тоологдсон иргэдийн 65.3 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт, 28.6 хувь нь Европ тивд суугаагаар тоологдсон байна.

Сэлэнгэ аймгийн иргэдийн оршин сууж байгаа улсыг авч үзвэл БНСУ (1186), Орос (185), Чех (161), Австрали (162), АНУ (145) улсуудад хамгийн ихээр сууж байна.

Энэ удаагийн тооллогын дүнгээр нийт иргэдийн 22.8 хувь нь сурах, 49.1 хувь нь хөдөлмөр эрхлэх (үүнээс 37.7 хувь нь хувиараа, 11.0 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр, 0.4 хувь нь албан томилолтоор ажиллах), 9.9 хувь нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух, 5.3 хувь нь суурьших, үлдсэн 12.8 хувь нь бусад зорилгоор эх орноосоо явжээ.

## ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ

Орон сууцны тооллогын дүнгээр аймгийн нийт өрхийн 22.7 хувь нь уламжлалт сууц гэрт, 75.9 хувь нь байшинд, 1.3 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс 1.9 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 1.3 пунктээр нэмэгджээ.

Хотод нийт өрхийн 86.8 хувь нь байшинд, 11.9 хувь нь гэрт амьдарч байгааг өмнөх тооллогын үетэй харьцуулахад хотын байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь 0.3 пунктээр нэмэгдэж, гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь 0.8 буурчээ. Энэ нь гол төлөв аймгийн төвд хөдөөгөөс шилжин ирэгчид ихэнх тохиолдолд эхлээд гэр хороололд суурьшдагтай холбоотой. Хөдөөгийн өрхийн 28.2 хувь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 8.1 пунктээр буурчээ.

Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 20.2 хувийг эзэлж, 2010 оныхоос 2.4 пунктээр нэмэгджээ. Харин сууцны тусдаа байшинд суудаг өрхийн хувийн жин 2010 оныхоос 1.6 пунктээр буурчээ. Нийт өрхийн 2.4 хувь нь бие даасан тохилог сууцанд амьдарч байгаа бол 2000 онд уг үзүүлэлтийг тусад нь тодорхойлж байгаагүй юм. Нийт өрхийн 99.4 хувь нь хувийн (98.2 хувь нь иргэний, 1.2 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) өмчийн сууцанд амьдарч байгаа нь 2010 оныхоос 0.7 пунктээр нэмэгджээ.

Аймгийн хэмжээнд нийт өрхийн 9.7 хувь буюу 2812 өрх өөрийн сууцгүй байна. Үүнээс хотод 1152 өрх, хөдөөд 1660 өрх байна. Гэрт амьдардаг өрхийн 81.2 хувь нь 5 ханатай гэрт амьдарч байна.

Бие засах тодорхой цэггүй өрх нийт өрхийн 7.6 хувийг эзэлж байгаа нь улсын дунджаас 13.4 пунктээр бага гарчээ. Энэ үзүүлэлт хотод 2.9 хувь, хөдөөд 8.6 хувь байна.

Хатуу хог хаягдлаа хаях тогтсон цэггүй өрх нийт өрхийн 38.8 хувь, бохир усаа задгай асгадаг өрх 62.2 хувийг эзэлж байна. Хотод хатуу хог хаягдлаа зайлуулах тогтсон цэггүй өрх 41.8 хувь, бохир усаа задгай асгадаг өрх 62.0 хувийг эзэлж байгаа нь суурин газар оршин суугчдын орчны эрүүл ахуйн нөхцөлд сөргөөр нөлөөлөхийг анхаарч, цаашид холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай.

Гэрт амьдардаг өрхийн 97.7 хувь нь баталгаатай эх үүсвэрээр ундны усаа авч байгаа нь улсын дундажтай харьцуулахад 32.1 пунктээр их байна. Харин 2.3 хувь нь баталгаагүй ундны ус хэрэглэж байгаагаас 0.7 хувь гол мөрөн, нуур, шанд, 0.2 хувь нь зөөврийн ус хэрэглэж байгаа нь гэрт амьдардаг өрхийн олонх нь хөдөө байдагтай холбоотой.

Байшинд амьдардаг өрхийн 28.2 хувь нь 21-40 метр квадрат талбайтай сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогынхоос 12.1 пунктээр буурчээ. Гэтэл 40-өөс дээш метр квадрат талбайтай байшинд суудаг өрхийн эзлэх хувь 65.9 болж өмнөх тооллогынхоос 21.8 пунктээр нэмэгдсэн байна. Харин 7, түүнээс ам бүлтэй өрхийн 7.4 хувь нь 40-өөс дээш метр квадрат талбайтай байранд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 40.7 пунктээр буурчээ.

Халуун, хүйтэн устай сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь 18.5 байгаа нь өмнөх тооллогоос 2.1 пунктээр өсжээ. Энэ үзүүлэлт хотод 19.5 хувь, хөдөөд 17.9 хувь байна. Байшинд амьдардаг өрхийн 70.8 хувь буюу 15596 өрх зөөврийн ус хэрэглэж байгаа нь өмнөх тооллогоос 8.5 пунктээр буурсан байна.

Байшинд амьдардаг өрхийн 16.1 хувь нь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байна. 2010 онд байшинд амьдардаг өрхийн 14.4 хувь нь хог хаягдлаа зайлуулах тодорхой цэггүй байсан бол 2020 онд 0.4 хувь болж буурчээ.

1

БҮЛЭГ

# **ЭЭЛЖИТТОЛЛОГЫН ОНЦЛОГ, УДИРДЛАГА**

## ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ОНЦЛОГ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулахдаа Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг мөрдөж тооллогын үе шат бүрд мэдээллийн технологийн ололт, дэвшлийг өргөн ашигласан төдийгүй уг хуулийн 4.1.1 болон 4.1.2 заалтуудад заасан аргуудыг хослуулан явуулсан.

Нийт өрхийн 10 хувийн мэдээллийг дэлгэрэнгүй асуулгын маягтаар сонгогдсон өрх бүрд орж (уламжлалт арга), үлдсэн 90 хувийн мэдээллийг богино асуулга буюу Хүн ам, өрхийн мэдээллийн сан болон төрийн байгууллагуудын мэдээллийн санд тулгуурлан бүртгэлд суурилан цуглуулсан.

Монгол Улсад статистикийн байгууллагын үндэс суурь тавигдсан 1924 оноос хойш 1935, 1944, 1956, 1963 онуудад хүн амын тооллого хийсэн бол улс хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллогыг 1969 онд явуулсан байдаг. Олон улсын нийтлэг аргачлалын дагуу хүн ам болон орон сууцны тооллогыг нэгтгэн 1969 оноос хойш 10 жилийн давтамжтайгаар хийх болж 1979, 1989, 2000, 2010, 2020 онуудад явуулсан бол Байшин, орон сууцны тооллогыг 2019 онд тусад нь зохион байгууллаа.

Байшин, орон сууцны тооллогоор хүн амьдран суух зориулалттай бүх байшин, орон сууцны сан хөмрөгийг бүрэн тодорхойлж, орон сууцны хийц, ашиглалт, хүчин чадал, дэд бүтцийн хүртээмжийн талаарх хаягт суурилсан дэлгэрэнгүй мэдээллийн сантай болсон. Өөрөөр хэлбэл төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчид, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн судлаачдад нэн хэрэгцээтэй олон улсын түвшинд зэрэгцүүлж харьцуулагдах зарчмыг хангасан, шаардлагад нийцсэн мэдээллийн нарийвчилсан эх үүсвэрийг шинэчлэн гаргаснаар ихээхэн онцлогтой тооллого байлаа.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТООЛЛОГЫН ТОВЫН ТУХАЙ ТОГТООЛ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2017 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 76

Төрийн ордон, Улаанбаатар хот

**Тооллогын тов тогтоох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллогын товыг 2020 оны 01 дүгээр сарын 08-наас 09-нд шилжих шөнийн "00" /тэг тэг/ цагаар тогтоосугай.



М.ЭНХБОЛД

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТООЛЛОГЫН АЙМГИЙН КОМИСС  
БАЙГУУЛАХ ТУХАЙ ЗАХИРАМЖ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/371

Сүхбаатар сум

Г Хүн ам, орон сууцны тооллогын комисс  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн "Улсын комисс байгуулах тухай" 76 дугаар тогтоол, Хүн ам, орон сууцны тооллогын улсын комиссын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн "Аймаг, нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах аймгийн тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Комиссын дарга:

-Аймгийн Засаг дарга

Комиссын орлогч дарга:

-Аймгийн Хөгжлийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч

-Статистикийн хэлтсийн дарга

Гишүүд:

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

-Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга

- Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
- Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
- Аймгийн Онцгой байдлын газрын дарга
- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
- Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга
- Аймгийн Цагдаагийн газрын дарга
- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Аймгийн Гаалийн газрын дарга
- Аймгийн Гадаадын иргэн, харъяатын газрын хойд бүс дэх газрын дарга
- Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга
- Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга
- Аймгийн Ус цаг, уур орчны шинжилгээний төвийн дарга
- Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
- Сүхбаатар сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

- Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2.Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, ажлын явц байдалд хяналт тавьж ажиллахыг Статистикийн хэлтсийн дарга /Д.Гүндэгмаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН  
“ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ДҮНГ НИЙТЭД  
ЗАРЛАХ ТУХАЙ ТОГТООЛ”



МОНГОЛ УЛСЫН  
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ  
ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН  
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит  
тооллогын дүнг нийтэд зарлах тухай

Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 13 дугаар зүйлийн  
13.6.7 дахь хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 76 тоот  
тогтоолоор баталсан товын хугацаанд Монгол Улсын хүн ам 3 296 866, өрхийн тоо  
897 427 болсныг зарласугай.

2. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнг нийтийн хүртээл  
болгож, энэ тооллогын мэдээлэлтэй уялдуулан хөгжлийн бодлогын холбогдох суурь  
болон шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцохыг Монгол Улсын Засгийн газрын  
гишүүдэд даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйгээр хангаж  
ажиллахыг Улсын комиссын орлогч дарга /Л.Оюун-Эрдэнэ, А.Ариунзаяа/ нарт  
даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД



У.ХҮРЭЛСҮХ

АЙМГИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

КОМИССЫН ДАРГА



Ш.ОРГИЛ  
*Сэлэнгэ аймгийн Засаг дарга*

КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА НАР



Ж.САЙНЦОГ  
*Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч*



Д.ГҮНДЭГМАА  
*Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтсийн дарга*


КОМИССЫН ГИШҮҮД



Э.ОЮУНБОЛД  
*Аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга*



Ө.СУВДАА  
*Аймгийн ЗДТГ-ын дарга*




О.МӨНХБАЯР  
*Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга*



Б.ЭНХБАТ  
*Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга*



**А.ЭРДЭНЭГЭРЭЛ**  
Аймгийн ЗДТГ-ын  
ХОХБТХ-ийн дарга



**Б.ЭНХБОЛД**  
Аймгийн ЗДТГ-ын  
Цэргийн штабын  
дарга



**Ж.БАТЦОГТ**  
Аймгийн Автотээврийн  
үндэсний төвийн  
дарга



**Б.ЖАРГАЛСАЙХАН**  
Аймгийн БСУГ-ын  
дарга



**Б.САРУУЛТӨГС**  
Аймгийн ГХБХБГ-ын  
дарга



**Г.БААТАР**  
Аймгийн Онцгой  
байдлын газрын  
дарга



**Б.САРАНЧИМЭГ**  
Аймгийн Улсын  
бүртгэлийн  
хэлтсийн дарга



**Л.ЗОРИГБААТАР**  
Аймгийн ХХҮГ-ын  
дарга



**А.ЭНХБАТ**  
Аймгийн Цагдаагийн  
газрын дарга



**З.ТҮВШИНТӨГС**  
Аймгийн БОАЖГ-ын  
дарга



**Ж.ОД**  
Аймгийн Эрүүл  
мэндийн газрын  
дарга



**М.ДАМДИНХОРОЛ**  
Сэлэнгэ аймаг дахь  
Гаалийн газрын  
дарга



**Б.МӨНХБАТ**  
Аймгмйн ГИХГ-ын  
хойд бүс дэх газрын  
дарга



**Б.МӨНХЗУЛ**  
Аймгийн ШШГА-ны  
дарга



**У.БАТМӨНХ**  
Аймгийн БТСГ-ын  
дарга



**М.РЭГЗЭДМАА**  
Аймгийн  
УЦУОШТ-ийн дарга



**Ж.ОТГОНЖАРГАЛ**  
Аймгийн Нийгмийн  
даатгалын хэлтсийн  
дарга



**Т.ГАНТУЛГА**  
Сүхбаатар сумын  
Засаг дарга



**Ч.ЦЭНД-АЮУШ**  
Аймгийн ХАОСТ-ын  
комиссын нарийн  
бичгийн дарга

АЙМГИЙН ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН ТҮР ТОВЧООНЫ  
БҮРЭЛДЭХҮҮН



Түр товчооны дарга:

Д.Гүндэгмаа                      Статистикийн хэлтсийн дарга

Түр товчооны орлогч дарга:

Ч.Цэнд-Аюуш                      Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Түр товчооны гишүүд:

Х.Батбаатар                      Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Хулан                              Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Л.Мөнхсолонго                      Статистикийн хэлтсийн мэргэжилтэн


Б.Энх-Учрал                      Статистикийн хэлтсийн зохион байгуулагч

Н.Оюунаа                              Статистикийн хэлтсийн тооллогын гэрээт ажилтан

ЗУРАГ 1. ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ТООЛЛОГЫН УДИРДЛАГА,  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ




## ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ



### ХҮН АМЫН ТОО, НАС ХҮЙСИЙН ХАРЬЦАА

Сэлэнгэ аймгийн хүн амын тоо 2020 оны 1 дүгээр сарын 01-ний байдлаар 110110 болов. Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа 2553 хүн, тус аймгийн нутаг дэвсгэрт 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат иргэд 197 байна.

ЗУРАГ 2.1. ХҮН АМЫН ТОО, 2020 ОН



Хүн амын 50.7 хувь нь эрэгтэйчүүд, 49.3 хувь нь эмэгтэйчүүд байна. 2010 оны тооллогоор хүн амын тоо 97584 байсан бол 10 жилийн хугацаанд 12526 хүнээр буюу 12.8 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 2.1. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР, ХҮЙСЭЭР

Тооллого явагдсан он	Хүн амын тоо			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
1956	26 749	15 125	11 624	130.1
1963	45 051	24 460	20 591	118.8
1969	42 728	22 164	20 564	107.8
1979	65 118	33 838	31 280	108.2
1989	86 952	44 462	42 490	104.6
2000	99 949	51 067	48 882	104.5
2010	97 584	49 624	47 960	103.5
2020	110 110	55 857	54 253	103.0

Сэлэнгэ аймгийн хүн амын хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэй) 2020 оны тооллогоор 103.0 болсон байна. Энэ нь 2010 оныхоос 0.5 пунктээр буурчээ. Хүйсийн харьцаа 1979 оноос хойш буурч байгаа нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаатай холбоотой бөгөөд

дундаж наслалтын зөрүү холдож байгааг харуулж байна. Улсын дундажтай харьцуулбал 6.4 пунктээр илүү ажээ.

### ХҮН АМЫН ӨСӨЛТ

Сэлэнгэ аймаг, Монгол Улсын хүн амын 3.3 хувийг эзэлж, хүн амын тоогоор Хөвсгөл, Өвөрхангай аймгийн дараа орж байна. 2010-2020 оны тооллогын хугацаанд хүн амын жилийн дундаж өсөлт 1.28 болсон нь Сэлэнгэ аймгийн дэд бүтцийг дагаж хүн ам өсөх хандлагатай болсныг харуулж байна.

Тооллого хоорондын хүн амын өсөлт нь тухайн үеийн улс төр, нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн хөгжлөөс ихээхэн хамаардаг. 1956 оноос 1989 он хүртэл жилд дунджаар 4.0 хувиар өссөн байна (Зураг 2.2). Энэ нь ард түмний аж амьдрал үүний дотор, хүн амын эрүүл мэндийн түвшин дээшилж, төрөлт нэмэгдэхийн зэрэгцээгээр нас баралт буурч, гадаад шилжих хөдөлгөөн бараг байхгүй байсантай холбоотой. Харин 1989-2000 оны тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлт 1.27 хувь болсон нь өмнөх 10 жилийнхээс 1.9 пунктээр буурчээ. Энэ хугацаанд хүн амын өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь гадаад шилжих хөдөлгөөн байлаа. 1989-1990 онд Сэлэнгэ аймагт ажиллаж, амьдарч байсан хуучин Зөвлөлт Холбоот Улсын иргэд нутаг буцаж, залуучууд гадаадад хөдөлмөр эрхэлж, суралцах болсноос шалтгаалсан юм. 2000-2010 оны тооллого хоорондын өсөлтөд хүн амын цэвэр өсөлтөөс илүү шилжих хөдөлгөөн голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 2.2. ХҮН АМЫН 1959-2020 ОНЫ ТООЛЛОГО ХООРОНДЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, ХУВИАР



Харин 2010-2020 оны тооллого хоорондын жилийн дундаж өсөлт өмнөх 11 жилийнхээс өссөн нь хүн амын ердийн өсөлт нэмэгдэж байгаатай холбоотой юм.

ХҮСНЭГТ 2.2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, 2010-2020 ОН

Он	Ерөнхий коэффициент		
	Төрөлт	Нас баралт	Цэвэр өсөлт
2010	22.4	6.6	15.8
2011	25.5	6.7	18.8
2012	23.0	4.5	18.5
2013	18.7	6.4	12.4
2014	26.1	4.6	21.5
2015	18.6	6.4	12.3
2016	22.3	6.4	16.0
2017	21.8	5.5	16.2
2018	23.1	6.4	16.7
2019	15.6	4.8	10.8
2020	16.5	4.6	11.9

Төр засгаас хэрэгжүүлсэн нийгмийн халамжийн арга хэмжээний дүнд 2010-2012, 2014, 2016-2018 онуудад буюу өөрөөр хэлбэл тооллогын завсрын 10 жилийн 7 жилд нь төрөлт өмнөх жилүүдийнхээс нэлээд нэмэгдэж, хүн амын өсөлтөд эерэг нөлөөлсөн юм.

ХҮСНЭГТ 2.3. СУМЫН ХҮН АМЫН ӨСӨЛТ, ХУВИАР, 2000-2020 ОН

Сумын нэр	2000/1989 (%)	2010/2000 (%)	2020/2010 (%)	Жилийн дундаж өсөлт (%)		
				1989-2000	2000-2010	2010-2020
<b>БҮГД</b>	<b>114.9</b>	<b>97.6</b>	<b>112.8</b>	<b>1.2</b>	<b>-0.2</b>	<b>1.3</b>
Сүхбаатар	110.5	88.0	114.7	0.9	-1.1	1.5
Алтанбулаг	93.3	125.8	108.2	-0.6	2.4	0.8
Баруунбүрэн	118.2	93.4	112.7	1.5	-0.6	1.3
Баянгол	107.6	94.4	109.4	0.7	-0.5	0.9
Ерөө	92.9	105.3	106.7	-0.7	0.5	0.7
Жавхлант	122.0	102.3	109.0	1.8	0.2	0.9
Зүүнбүрэн	106.8	94.6	118.8	0.6	-0.5	1.9
Мандал	117.7	103.3	109.1	1.5	0.3	0.9
Орхон	106.6	73.4	110.7	0.6	-2.4	1.1
Орхонтуул	106.1	95.8	104.2	0.5	-0.4	0.4
Сайхан	378.9	90.6	117.5	12.9	-0.9	1.8
Сант	65.5	89.4	114.1	-3.8	-1.0	1.4
Түшиг	118.0	80.4	120.2	1.5	-1.8	2.0
Хүдэр	92.7	114.9	130.9	-0.7	1.4	3.1
Хушаат	139.1	127.7	115.1	3.0	2.5	1.5
Цагааннуур	148.4	95.0	128.8	3.7	-0.5	2.9
Шаамар	83.5	78.9	105.3	-1.6	-1.9	0.5

Сумдын хүн амын тооллого хоорондын жилийн дундаж өсөлтийн дүр төрх өмнөх тооллогуудын хувьд / 1989, 2000, 2010 он/ өсөлт, бууралттай гарч байсан бол 2020 оны тооллогоор бүх сумдын хувьд өсөлттэй гарч байна. Тэр дундаа Түшиг, Хүдэр, Цагааннуур сумын хувьд 2.0-3.1 хувийн өсөлттэй гарчээ.

## ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн амын тоонд 0-14 насны хүүхэд 30.4, 15-59 насны хүн 61.8, 60-аас дээш насны хүн 7.8 хувийг эзэлж байна. Хүн амын 50.7 хувь нь эрэгтэйчүүд, 49.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 2.4. ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010		2020		Хүйсийн харьцаа <sup>1</sup>	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2020
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>103.6</b>	<b>103.1</b>
0-4	11.1	11.0	11.1	11.0	105.0	104.2
5-9	8.6	8.5	10.8	10.6	104.3	105.9
10-14	9.5	9.8	8.7	8.7	100.9	103.2
15-19	8.9	7.9	7.4	7.3	117.6	103.4
20-24	9.6	8.2	7.7	7.2	121.6	110.1
25-29	9.1	8.7	8.2	7.1	108.8	119.3
30-34	8.6	8.1	8.4	7.5	108.9	115.1
35-39	7.8	8.1	7.4	6.9	100.9	110.4
40-44	7.2	7.8	7.0	6.5	95.0	110.1
45-49	6.6	6.9	6.4	6.6	99.8	100.5
50-54	4.9	5.6	5.4	6.2	91.1	89.9
55-59	3.1	3.2	4.8	5.4	98.5	91.9
60-64	1.9	2.2	3.1	3.8	89.8	83.1
65-69	1.3	1.6	1.7	2.2	85.5	83.6
70+	1.8	2.6	1.9	3.0	73.4	64.8

<sup>1</sup> 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо

Сэлэнгэ аймгийн хүн амын хүйсийн харьцаа 103.1 байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 0.5 пунктээр буурсан бол улсын дунджаас 6.5 пунктээр илүү байна. Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам буурч байна. Монгол Улсын олон жилийн судалгаанаас үзэхэд төрөх үеийн хүйсийн харьцаа дунджаар 103-104 хооронд байдаг зүй тогтолтой. Амьдралын эхний жилүүдэд эрэгтэй хүүхдийн нас баралт илүү байж, цаашдаа хүйсийн харьцаа тэнцвэржиж байснаа нас ахих тутам буурдаг ажээ. Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутамд буурч байгаа нь эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс харьцангуй их байдагтай холбоотой бөгөөд үүнийг ахимаг насны бүлэгт, жишээлбэл 70, түүнээс дээш насанд хүйсийн харьцаа 64.8 түүнээс бага болж огцом буурч байгаагаас харж болно. Насны бүлэг дэх хүйсийн харьцаа төрөх үеийн хүйсийн харьцаа, нас баралтаас гадна хүйсийн ялгаатай шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалдаг.

Хүн амын хүйсийн харьцааг сумаар авч үзвэл нэлээд ялгаатай тал ажиглагдаж байна. Алтанбулаг, Баруунбүрэн, Жавхлант, Мандал, Орхон, Орхонтуул, Сайхан, Түшиг сумын хүн амын хүйсийн харьцаа өмнөх тооллогын үеийнхээс нэмэгдсэн нь газар тариалан, үйлдвэрлэл эрчимжиж эхэлсэнтэй холбоотойгоор шилжих хөдөлгөөн ихэссэнээс шалтгаалжээ. Харин Сүхбаатар, Баянгол, Ерөө, Зүүнбүрэн, Сант, Хүдэр, Хушаат, Цагааннуур, Шаамар сумын хувьд өмнөх тооллогын үеийнхээс 0.2-12.4 пунктээр буурчээ.

Хүйсийн харьцаа Сайхан, Цагааннуур, Шаамар, Сүхбаатар, Зүүнбүрэн суманд улсын дундажтай харьцуулахад 0.5-7.2 пунктээр доогуур, бусад сумын хувьд 0.7-17.3 пунктээр илүү байна.

**ХҮСНЭГТ 2.5. ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, СУМААР, 2010, 2020 ОН**

Сумын нэр	2010			2020		
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
<b>БҮГД</b>	<b>48 756</b>	<b>47 048</b>	<b>103.5</b>	<b>54 706</b>	<b>53 049</b>	<b>103.1</b>
Сүхбаатар	9 657	10 035	96.2	11 061	11 517	96.0
Алтанбулаг	2 225	2 164	102.8	2 411	2 339	103.1
Баруунбүрэн	1 426	1 319	108.1	1 609	1 485	108.4
Баянгол	2 677	2 410	111.1	2 884	2 683	107.5
Ерөө	3 474	2 928	118.6	3 520	3 314	106.2
Жавхлант	938	870	107.8	1 076	894	120.4
Зүүнбүрэн	1 173	1 199	97.8	1 380	1 439	95.9
Мандал	12 458	12 294	101.3	13 755	13 256	103.8
Орхон	1 086	983	110.5	1 218	1 072	113.6
Орхонтуул	1 909	1 692	112.8	2 000	1 754	114.0
Сайхан	3 939	3 976	99.1	4 711	4 591	102.6
Сант	986	858	114.9	1 093	1 011	108.1
Түшиг	776	751	103.3	937	898	104.3
Хүдэр	1 085	982	110.5	1 410	1 296	108.8
Хушаат	967	829	116.6	1 088	979	111.1
Цагааннуур	2 017	1 929	104.6	2 558	2 523	101.4
Шаамар	1 963	1 829	107.3	1 995	1 998	99.8

2020 онд хотын хүн амын хүйсийн харьцаа 100.4 болж 2010 оноос 1.6 пунктээр нэмэгдэж, хөдөөгийн хүйсийн харьцаа 104.6 болж 3.9 пунктээр буурчээ. Хөдөөгийн хүн амын хүйсийн харьцаа аймгийн дунджаас өндөр байгаа нь төв, суурин газар руу эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү шилжиж байгаатай холбоотой юм.


**НЭГДСЭН ДҮН**

ХҮСНЭГТ 2.6. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН

Байршил	2010			2020		
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
<b>БҮГД</b>	<b>48 756</b>	<b>47 048</b>	<b>103.6</b>	<b>54 706</b>	<b>53 049</b>	<b>103.1</b>
Хот	23 365	23 643	98.8	18 642	18 575	100.4
Хөдөө	25 391	23 405	108.5	36 064	34 474	104.6

Нас, хүйсийн бүтцийг харуулах өөр нэг гол үзүүлэлт бол хүн амын нас, хүйсийн суварга билээ.

ЗУРАГ 2.3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН




Хүн амын ердийн хөдөлгөөний өөрчлөлтөөс шалтгаалан 20-иос доош насанд суваргын хэлбэр нэлээд өөрчлөгдсөн байна. Тухайлбал, 2010 оны суваргын суурь нэлээд өргөссөн нь 2001-2005 онуудад төрөлт буурсантай холбоотой бол 2020 оны суварга 5-9 насанд нарийссан байна. Төрөлтийн ерөнхий коэффициент 2010 онд 22.4, 2011 онд 25.5, 2014 онд 26.1 болж өсөлттэй гарч байна.

Зургаас харахад манай аймгийн хөдөлмөрийн насны хүн ам, тэр дундаа 25-59 насны хүн ам 2000, 2010 оны тооллогоос нэлээд өссөн байна. Суваргын хэлбэр 30-аас дээш насанд аажмаар нарийсаж байгаа нь 1990-ээд оноос өмнө төрөлт тогтмол өндөр байж, насны бүлэг ахих тусам нас баралтын нөлөөгөөр тухайн насны хүн амын тоо буурч байгаагаар тайлбарлагдана. Сэлэнгэ аймгийн хүн ам 2010 онд ерөнхийдөө идэрших хандлагатай байсан нь дээрх зургаас харагдаж байгаа боловч 2020 онд залуу насны бүтэцтэй болжээ.

Сэлэнгэ аймгийн хүн ам нь насны бүтцийн хувьд залуужиж байгаа нь доорх зургаас харагдаж байна. Нийт хүн амд 0-14 насны хүүхдийн эзлэх хувийн жин 2010 оны тооллогоос 1.2 пунктээр нэмэгдсэн байна.

**ЗУРАГ 2.4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН**



Хүн амын насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа тэр зааг насыг голч нас гэсэн ойлголтоор илэрхийлдэг. 2020 оны голч нас нь Сэлэнгэ аймгийн хувьд 28.3 байгаа нь хүн амын тэн хагас нь 28.3-аас доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна гэсэн үг юм. Энэ үзүүлэлтээрээ Сэлэнгэ аймаг улсын дунджаас 0.4 пунктээр дээгүүр байна. Голч нас 2000 оноос хойш тогтвортой нэмэгдэж байгаа нь төрөлтийн бууралттай холбоотой. Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах, эдийн засгийн ач холбогдолтой үзүүлэлт бол хүн ам зүйн ачаалал юм. Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцааг хүн ам зүйн ачаалал гэнэ. Хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настны тоо нь хүн амын нийгэм, эдийн засгийн чухал үзүүлэлтийн нэг юм. Хүн ам зүйн ачаалал нь 2000 онд 67.2 хувь, 2010 онд 49.0 хувь болж тооллогоос тооллогын хооронд буурч байсан бол 2020 онд 53.4 хувьд хүрч өсжээ. Энэ үзүүлэлтийг улсын дундажтай харьцуулбал 1.9 пунктээр бага байна.

**ХҮСНЭГТ 2.7. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2000, 2010, 2020 ОН**

Үзүүлэлт	2000	2010	2020
Голч нас /жилээр/	21.2	26.9	28.3
Хүн ам зүйн ачаалал /хувиар/	67.2	49.0	53.4
Үүнээс:			
Хүүхэд	62.6	43.5	48.2
Хөгшид	4.6	5.4	10.2
Хөгшрөлтийн индекс	7.4	12.5	14.1

Сэлэнгэ аймгийн хүн амын зүйн ачаалал 2010 онд 2000 оныхоос 18.2 пунктээр буурсан бол 2020 онд 2010 оныхоос 4.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

# УЛСЫН ХАРЬЯАЛАЛ, ҮНДЭС, УГСАА, ШАШИН


СЭЛЭНГЭ АЙМАГТ СУУГАА СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХАРЬЯАТ

107 557



СЭЛЭНГЭ АЙМАГТ СУУГАА ГАДААДЫН  
ХАРЬЯАТ


197



### ХҮН АМЫН ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ


Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 99.8 хувь нь Монгол Улсын харьяат, 0.2 хувь нь гадаадын харьяат иргэн байна.

ЗУРАГ 3.1. ХҮН АМЫН ТОО, ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛААР, 2020 ОН



Сэлэнгэ аймагт 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадын харьяат иргэдийн тоо 2010 оныхоос 126 иргэнээр буурчээ. Гадаадын харьяат иргэдийн дотор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн 86 буюу 43.7 хувийг, Оросын Холбооны Улсын иргэн 62 буюу 31.5 хувь, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын иргэн 28 буюу 14.2 хувь, Америкийн Нэгдсэн Улсын иргэн 10 буюу 5.1 хувийг, бусад орны иргэд 5.5 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3.2. СЭЛЭНГЭ АЙМАГТ ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭД, УЛСААР, ХУВИАР, 2010, 2020 ОН



Өмнөх тооллоготой харьцуулахад БНХАУ-ын иргэдийн эзлэх хувь 16.1 пунктээр буурч, ОХУ-ын иргэд 9.2 пунктээр нэмэгджээ. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Баянгол, Ерөө, Мандал, Сайхан сумдад гадаадын харьяат иргэдийн 92.4 хувь нь оршин сууж байна.

Насны бүтцийг авч үзвэл 9.7 хувийг 0-14 насны, 17.3 хувийг 15-24 насны, 21.3 хувийг 25-34 насны, 14.2 хувийг 35-44 насны, 18.2 хувийг 45-54 насны иргэд, 19.3 хувийг 55-аас дээш насны иргэд эзэлж байна.

Гадаадын харьяат иргэдийн 68.0 хувийг эрэгтэйчүүд, 32.0 хувийг эмэгтэйчүүд эзэлжээ. Эндээс гадаадын харьяат иргэдийн дийлэнх нь хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд байгааг харуулж байна.

**ХҮСНЭГТ 3.1. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮН АМ, ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ХУВИАР 2020 ОН**

Насны бүлэг	Хүн амын насны бүтэц	Гадаадын харьяат иргэд			Хүйсийн харьцаа
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>212.7</b>
0-14	30.4	9.7	6.7	15.9	90.0
15-24	14.8	17.3	16.4	19.1	183.3
25-34	15.6	21.3	25.4	12.7	425.0
35-44	13.9	14.2	17.2	7.9	460.0
45-54	12.4	18.2	18.0	19.0	200.0
55+	12.9	19.3	16.3	25.4	137.5

**ХҮН АМЫН ҮНДЭС УГСАА**

Сэлэнгэ аймгийн хүн амын 85.4 хувийг халхчууд эзэлж байгаа нь өмнөх тооллогоос 2.6 пунктээр өсжээ. Баяд, дөрвөд, урианхай, тува, захчин, дархад, торгуудын эзлэх хувь 0.1-0.6 пунктээр буурчээ.

**ХҮСНЭГТ 3.2. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2010, 2020 ОН**

Үндэс угсаа	2010		2020	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>95 804</b>	<b>100.0</b>	<b>107 755</b>	<b>100.0</b>
Халх	79 300	82.8	92 019	85.4
Баяд	3 482	3.6	3 625	3.4
Дөрвөд	3 231	3.4	3 087	2.9
Урианхай	2 031	2.1	1 824	1.7
Хотон	1 631	1.7	1 805	1.7
Буриад	1 212	1.3	751	0.7
Захчин	1 147	1.2	961	0.9
Тува	913	1.0	443	0.4
Казак	879	0.9	1 015	0.9
Торгууд	608	0.6	534	0.5
Дархад	379	0.4	361	0.3
Бусад	668	0.7	1 132	1.9
Монгол Улсын харьяат - Бүгд	95 481	99.7	107 557	99.8
Гадаадын харьяат	323	0.3	197	0.2
Харьяалалгүй			1	

Хотон, халх, тува, казахуудын дунд 0-14 настай хүүхдийн эзлэх хувь аймгийн дунджаас өндөр байгаа нь тэдний дунд төрөлтийн түвшин өндөр байгаатай холбоотой юм. Харин буриад, дархад, урианхай, захчин иргэдийн дунд 45-аас дээш настай хүний эзлэх хувь 30-аас илүү байна.

**ХҮСНЭГТ 3.3. ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСАА, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2020 ОН**

Үндэс, угсаа	Насны бүлэг						
	Бүгд	0-14	15-24	25-34	35-44	45-54	55+
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>30.4</b>	<b>14.8</b>	<b>15.6</b>	<b>13.9</b>	<b>12.4</b>	<b>12.9</b>
Халх	100.0	30.8	14.8	15.6	13.9	12.2	12.7
Баяд	100.0	27.9	17.7	14.8	14.9	12.9	11.8
Дөрвөд	100.0	23.4	13.4	17.1	15.1	15.1	15.9
Урианхай	100.0	26.3	12.9	15.1	14.3	14.4	17.0
Хотон	100.0	45.0	16.5	12.2	10.9	8.1	7.3
Буриад	100.0	23.8	8.4	15.4	11.1	15.7	25.6
Захчин	100.0	21.9	13.1	15.0	17.5	13.6	18.9
Тува	100.0	66.1	10.1	6.5	4.1	5.0	8.2
Казак	100.0	31.3	14.0	16.3	11.9	15.3	11.2
Торгууд	100.0	22.1	9.4	16.9	16.5	14.9	20.2
Дархад	100.0	23.2	8.9	21.6	13.0	14.2	19.1
Бусад	100.0	15.6	17.2	20.2	16.4	14.5	16.1
Монгол Улсын харьяат-Бүгд	100.0	30.5	14.8	15.6	13.9	12.4	12.8
Гадаадын харьяат	100.0	9.6	17.2	21.2	14.1	18.3	19.6

Үндэс, угсааг байршлаар харвал баядууд Баянгол, Хушаат, Цагааннуур сумдад олноор, дөрвөдүүд Ерөө, Сайхан, Орхонтуул сумдад, урианхайчууд Ерөө, Хушаат, Орхонтуул сумдад, хотонгууд Баруунбүрэн, Цагааннуур суманд голлон суурьшжээ.


**ХҮСНЭГТ 3.4. ХҮН АМЫН ТАРХАН СУУРЬШИЛТ, СУМ, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2020 ОН**

Сумын нэр	Монгол Улсын харьяат-Бүгд	Халх	Баяд	Дөрвөд	Урианхай	Хотон	Буриад	Захчин	Бусад	Монголын харьяат	Гадаадын харьяат
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Сүхбаатар	20.9	23.0	7.6	9.2	6.0	1.6	22.9	14.2	0.0	9.4	10.8
Алтанбулаг	4.4	4.3	7.8	4.0	5.5	0.3	7.3	3.0	0.0	4.1	3.5
Баруунбүрэн	2.9	2.3	1.7	2.3	2.4	40.2	0.1	0.6	0.0	2.2	2.3
Баянгол	5.1	5.2	10.3	3.0	2.5	0.4	1.3	7.1	0.0	4.2	4.6
Ерөө	6.3	5.3	7.4	17.0	26.9	0.8	19.8	7.0	23.0	12.4	4.6
Жавхлант	1.9	1.5	5.4	4.6	0.4	0.3	1.7	9.4	0.0	4.8	0.0
Зүүнбүрэн	2.6	2.4	2.9	0.7	0.8	0.2	1.3	0.5	0.0	9.1	42.5
Мандал	25.1	27.3	9.4	8.9	10.9	2.8	21.4	11.6	0.0	21.9	12.5
Орхон	2.1	2.2	2.1	1.5	2.0	0.0	0.8	2.4	7.7	2.0	0.0
Орхонтуул	3.5	3.1	7.4	11.2	11.3	6.1	0.9	2.1	15.4	1.7	1.4
Сайхан	8.6	8.8	7.2	13.1	4.8	3.6	3.2	10.8	0.0	7.3	0.2
Сант	2.1	1.7	5.9	3.1	0.5	4.2	0.7	7.2	0.0	1.5	0.5
Түшиг	1.7	1.7	1.1	5.1	0.4	0.1	2.3	3.0	23.1	1.0	0.0
Хүдэр	2.5	2.4	1.8	4.2	2.6	1.2	11.0	4.4	0.0	2.1	2.8
Хушаат	1.9	1.3	10.3	1.6	11.3	0.2	0.5	4.7	0.0	5.6	12.7
Цагааннуур	4.7	3.6	10.0	9.2	10.3	37.3	2.7	9.8	30.8	4.6	0.2
Шаамар	3.7	3.9	1.7	1.3	1.4	0.7	2.1	2.2	0.0	6.1	1.4

ЗУРАГ 3.3. ХҮН АМ, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР, 2020 ОН




ЗУРАГ 3.4. КАЗАХ УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, СУМДААР, 2020 ОН



Казахууд Ерөө, Жавхлант, Мандал, Сүхбаатар сумдад ихэвчлэн оршин сууж байна.

ЗУРАГ 3.5. ДӨРВӨД УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, СУМДААР, 2020 ОН



Дөрвөд угсаатнууд Ерөө, Мандал, Орхонтуул, Сайхан, Сүхбаатар, Цагааннуур сумдад тархан суурьшсан байна.

## ШАШИН

Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн “Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” гэсэн 3 дугаар бүлгийн 1 дэх хэсэгт “Аливаа шашныг шүтэх, эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна” гэж заасан. Хүн ам, орон сууцны тооллогод “Та шашин шүтдэг үү, шүтдэг бол ямар шашин шүтдэг вэ?” гэсэн асуултыг анх удаагаа 2010 оны тооллогоор асууж байсан бөгөөд энэ удаагийн тооллогод хүн амын 10 хувийн түүвэрт сонгогдсон 15, түүнээс дээш насны хүн амаас асуусан болно. Шашин шүтдэг хүмүүсийг хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 7.1 пунктээр илүү шашин шүтдэг байна.

### ХҮСНЭГТ 3.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ШАШИН ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН


Шашин шүтлэгийн байдал	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Шүтлэггүй	56.0	60.8	51.1	54.9	58.5	51.4
Шүтдэг	44.0	39.2	48.9	45.1	41.5	48.6

Шашин шүтдэг хүмүүсийн 85.1 хувь нь Буддын шашинтан болох нь тооллогын дүнгээс харагдаж байна. Мөн 2010 онтой харьцуулахад нийт хүн амд эзлэх Христ болон Бөөгийн шашинтан буурсан нь бусад шашны урсгал дэлгэрсэнтэй холбоотой байж болох юм.

### ХҮСНЭГТ 3.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ШАШИН ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Шашны төрөл	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Будда	88.1	89.0	87.3	85.1	85.5	84.7
Христ	4.8	3.6	6.0	3.9	2.9	4.7
Бөө	4.4	1.8	1.6	6.9	7.0	6.9
Ислам	1.7	4.6	4.3	1.7	1.8	1.6
Бусад	0.9	1.0	0.8	2.4	2.9	2.1

ЗУРАГ 3.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН



Шашинтууд нас ахих тутам буддын шашныг илүү шүтэж байна. Тухайлбал, 15-19 насны шашинтнуудын 73.6 хувь нь будда шүтэж байхад 50-59 насныхны 87.4 хувь, 60-69 насныхны 89.8 хувь, 70 ба түүнээс дээш насныхан мөн адил 89.8 хувь нь буддын шашинтан байна. Нөгөө талаар христийн шашинтны тоо нас ахих тутам буурч байгаад 70 ба түүнээс дээш насныхны хувьд өсөж байна. Тухайлбал, 15-19 насныхны 7.3 хувь нь христийн шашинтан байхад 60-69 насанд 4.0 хувь, 70 ба түүнээс дээш насанд 5.6 хувь болж өсөж байна.

ХҮСНЭГТ 3.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Шашин шүтдэг	Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>85.1</b>	<b>3.9</b>	<b>1.7</b>	<b>6.9</b>	<b>2.4</b>
15-19	100.0	73.6	7.6	4.0	11.2	3.6
20-29	100.0	79.8	2.9	3.5	9.6	4.2
30-39	100.0	83.8	3.3	0.6	8.0	4.3
40-49	100.0	87.7	2.4	1.1	7.4	1.5
50-59	100.0	87.4	4.8	1.9	4.8	1.0
60-69	100.0	89.8	4.0	0.9	3.8	1.4
70+	100.0	89.8	5.6	1.0	3.1	0.5
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
15-19	7.0	6.0	13.7	16.4	11.2	10.3
20-29	15.3	14.3	11.5	31.1	21.2	26.4
30-39	19.4	19.1	16.5	6.6	22.4	34.5
40-49	21.0	21.7	12.9	13.1	22.4	12.6
50-59	20.1	20.7	25.2	23.0	14.0	8.0
60-69	11.8	12.4	12.2	6.6	6.4	6.9
70+	5.4	5.7	7.9	3.3	2.4	1.1

# 4

## БҮЛЭГ

### ХҮН АМЫН СУУРЬШИЛ, ХОТЖИЛТ


ХОТ, СУУРИНД  
АМЬДАРДАГ  
ХҮН АМ **34.5%**

ХОТЫН ХҮН АМ



**65.5%** ХӨДӨӨ  
АМЬДАРДАГ  
ХҮН АМ

ХӨДӨВГИЙН ХҮН АМ



**ХҮН АМЫН СУУРЬШИЛ**

**ХҮСНЭГТ 4.1. ХҮН АМЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН**

Хот, хөдөө	2010 он		2020 он	
	Хүн амын тоо	Дүнд эзлэх хувь	Хүн амын тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>95 804</b>	<b>100.0</b>	<b>107 755</b>	<b>100.0</b>
Хот	47 008	49.1	37217	34.5
Хөдөө	48 796	50.9	70538	65.5

Тус аймгийн хүн амын 21.0 хувь нь аймгийн төвийн сум болох Сүхбаатар суманд амьдарч байгаа нь өмнөх тооллогынхоос 0.4 пунктээр өсжээ. Мандал, Ерөө, Орхонтуул, Шаамар, Алтанбулаг, Орхон, Жавхлант, Баянгол сумын хүн ам 0.1-0.8 пунктээр буурч, бусад сумын хүн ам 0.1-0.5 пунктээр өссөн байна. Харин Хушаат сумын хувьд 2010 оныхтой ижил байна.

**ХҮСНЭГТ 4.2. СУМЫН ХҮН АМЫН ТОО, ХУВИАР, 2010, 2020 ОН**

Сумын нэр	2010		2020	
	Хүн амын тоо	Дүнд эзлэх хувь	Хүн амын тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>95 804</b>	<b>100.0</b>	<b>107 755</b>	<b>100.0</b>
Сүхбаатар	19 692	20.6	22 578	21.0
Алтанбулаг	4 389	4.6	4 750	4.4
Баруунбүрэн	2 745	2.8	3 094	2.9
Баянгол	5 087	5.3	5 567	5.2
Ерөө	6 402	6.7	6 834	6.3
Жавхлант	1 808	1.9	1 970	1.8
Зүүнбүрэн	2 372	2.5	2 819	2.6
Мандал	24 752	25.8	27 011	25.1
Орхон	2 069	2.2	2 290	2.1
Орхонтуул	3 601	3.8	3 754	3.5
Сайхан	7 915	8.3	9 302	8.6
Сант	1 844	1.9	2 104	2.0
Түшиг	1 527	1.6	1 835	1.7
Хүдэр	2 067	2.1	2 706	2.5
Хушаат	1 796	1.9	2 067	1.9
Цагааннуур	3 946	4.1	5 081	4.7
Шаамар	3 792	3.9	3 993	3.7

Сэлэнгэ аймгийн хүн ам өмнөх тооллогоос өссөн нь төр засгаас ахмад үеийнхэнд үзүүлдэг эмнэлгийн үйлчилгээ нэмэгдсэн, хорт хавдрыг эрт үед нь илрүүлдэг болсон, хүн амын дундаж наслалт нэмэгдсэн, төрөлт нэмэгдсэнтэй холбоотой юм.

Сэлэнгэ аймгийн сумдын нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүйн зэрэгцээ хүн амын суурьшил, нягтрал, хөгжлийн түвшин өөр өөр байх нь зүй ёсны асуудал билээ.

Хүн амын суурьшлыг бүсчилж үзэхэд аймгийн нийт хүн амын 30.2 хувь нь Хараагийн бүс, 29.1 хувь нь Бэлчир бүс, 21.0 хувь нь Орхоны бүсэд оршин сууж байна. Дээрх бүсүүд нь газар тариалан, уул уурхай давуу хөгжсөн тул ажлын байр олох найдвартай газар болж, хүмүүс ихээр татагдаж байна.

**ХҮСНЭГТ 4.3. ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2010, 2020 ОН**

Бүс	Хүн ам		2020/2010 (%)	Дүнд эзлэх хувь	
	2010	2020		2010	2020
<b>БҮГД</b>	<b>95 804</b>	<b>107 755</b>	<b>112.5</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Бэлчир	27 873	31 321	112.4	29.2	29.1
Ерөө	10 277	11 510	112.0	10.7	10.7
Хараа	29 839	32 578	109.2	31.1	30.2
Орхон	19 970	22 611	113.2	20.8	21.0
Сэлэнгэ	7 845	9 735	124.1	8.2	9.0

2020 оны тооллогын хүн амын тоог 2010 оны хүн амын тоотой харьцуулахад Түшиг, Хүдэр, Цагааннуур сумдын хүн ам хамгийн их 20.2-30.9 хувийн өсөлттэй байгаа бол Орхонтуул, Шаамар, Ерөө, Жавхлант, Алтанбулаг, Баянгол, Мандал сумдын хүн ам хамгийн бага 4.2-9.4 хувийн өсөлттэй байна. Бусдын сумдын хувьд 10.7–18.8 хувийн өсөлттэй байна.

**ХҮСНЭГТ 4.4. ХҮН АМЫН ТОО, СУМ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2010, 2020 ОН**

Сумын нэр	Хүн ам		2020/2010 (%)	Дүнд эзлэх хувь	
	2010	2020		2010	2020
<b>БҮГД</b>	<b>95 804</b>	<b>107 755</b>	<b>112.5</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Сүхбаатар	19 692	22 578	114.7	20.5	21.0
Алтанбулаг	4 389	4 750	108.2	4.6	4.4
Баруунбүрэн	2 745	3 094	112.7	2.8	2.9
Баянгол	5 087	5 567	109.4	5.3	5.2
Ерөө	6 402	6 834	106.7	6.6	6.3
Жавхлант	1 808	1 970	109.0	1.9	1.8
Зүүнбүрэн	2 372	2 819	118.8	2.5	2.6
Мандал	24 752	27 011	109.1	25.8	25.1
Орхон	2 069	2 290	110.7	2.2	2.1
Орхонтуул	3 601	3 754	104.2	3.8	3.5
Сайхан	7 915	9 302	117.5	8.3	8.6
Сант	1 844	2 104	114.1	1.9	2.0
Түшиг	1 527	1 835	120.2	1.6	1.7
Хүдэр	2 067	2 706	130.9	2.2	2.5
Хушаат	1 796	2 067	115.1	1.9	1.9
Цагааннуур	3 946	5 081	128.8	4.1	4.7
Шаамар	3 792	3 993	105.3	4.0	3.7

Сэлэнгэ аймаг нь хатуу хучилттай зам, төмөр зам гэх мэт дэд бүтэц сайтай, ОХУ-тай хиллэдэг зэрэг нь аймгийн хотжих үйл явцад нөлөөлж байгаа боловч Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймагтай хил залган ойролцоо оршдог тул ажлын байр хайх, сурах зорилгоор иргэд дээрх аймаг, хотод шилжин явдаг. Сэлэнгэ аймаг хүн амын тоогоор 2010 онд Хөвсгөл, Өвөрхангай аймгийн дараа 3 дугаарт жагсаж байсан бол 2020 онд хүн ам нь өссөн аймгийн тоонд багтсан байна. Аймгийн хүн амд хотын хүн амын эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогоос 14.6 пунктээр буурч, хөдөөгийн хүн амын эзлэх хувь 14.6 пунктээр нэмэгдэв.

ХҮСНЭГТ 4.5. ХҮН АМЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 1969, 1979, 1989, 2000, 2010, 2020 ОН

Он	Хот		Хөдөө	
	Мянган хүн	Дүнд эзлэх хувь	Мянган хүн	Дүнд эзлэх хувь
1969	22.3	52.2	20.4	47.8
1979	34.3	52.7	30.8	47.3
1989	46.7	53.7	40.2	46.3
2000	56.4	56.5	43.5	43.5
2010	47.0	49.1	48.8	50.9
2020	37.2	34.5	70.5	65.5

#### ХҮН АМЫН НЯГТРАЛ

Улс төр, соёл, түүх, засаг захиргаа, цаг агаар, газарзүй зэрэг олон хүчин зүйлс хүн амын суурьшил, улмаар хүн амын нягтралд нөлөөлдөг. Бүс нутаг, аймаг, нийслэлийн хүн амын нягтралд хамгийн ихээр нөлөөлсөн хүчин зүйлсийн нэгд шилжих хөдөлгөөн ордог байна.

Аймгийн нэг километр квадрат нутаг дэвсгэрт 2010 онд 2.3 хүн ногдож байсан бол 2020 онд 0.3-аар өсөж 2.6 болов. Нэг километр квадрат нутаг дэвсгэрт 2.6 хүн ногдож байгаа нь бусад аймагтай харьцуулахад өндөр нягтралтай аймгийн тоонд ордог. Ерөөгийн бүс хамгийн бага нягтралтай 1 километр квадрат нутаг дэвсгэрт 0.9 хүн суурьшиж байхад хүн амын тоогоор хамгийн их бэлчрийн бүсэд 1 километр квадрат нутаг дэвсгэрт 11.1 хүн ногдож байна.

ХҮСНЭГТ 4.6. ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, БҮС, ХУВИАР, 2020 ОН

Он	Хүн ам		Нутаг дэвсгэр		1 км-т ногдох хүн
	Хүн	Эзлэх хувь	Мян.км <sup>2</sup>	Эзлэх хувь	
<b>БҮГД</b>	<b>107 755</b>	<b>100.0</b>	<b>41 152.6</b>	<b>100.0</b>	<b>2.6</b>
Бэлчир	31 321	29.1	2 817.6	6.8	11.1
Ерөө	11 510	10.7	12 231.9	29.7	0.9
Хараа	32 578	30.2	6 820.0	16.6	4.8
Орхон	22 611	21.0	11 770.7	28.6	1.9
Сэлэнгэ	9 735	9.0	7 512.4	18.3	1.3

Хүн амын нягтралыг сумаар харвал Сүхбаатар сум хүн амын нягтралаараа хамгийн өндөр байна. Өмнөх тооллогын үед тухайн сумын нэг метр квадрат нутаг дэвсгэрт 433.7 хүн ногдож байснаа 2020 онд 479.3 болж 45.6 хүнээр өсжээ.

Энэ нь хүн амын ердийн өсөлт, шилжих хөдөлгөөнтэй холбоотой юм. Сүхбаатар сум Сэлэнгэ аймгийн бүх нутаг дэвсгэрийн дөнгөж 0.11 хувийг эзэлдэг атлаа хүн амын 21.0 хувь нь оршин сууж байна. Сүхбаатар сумын хүн амын нягтрал улсын дунджаас 477.2 хүнээр, Улаанбаатар хотоос 151.7 хүнээр олон байна. Хүн ам хамгийн сийрэг суурьшилтай сумдад Түшиг (нэг километр квадрат нутаг дэвсгэрт 0.7 хүн), Ерөө (нэг километр квадрат нутаг дэвсгэрт 0.8 хүн), Хушаат (нэг километр квадрат нутаг дэвсгэрт 1.0 хүн), Хүдэр (нэг километр квадрат нутаг дэвсгэрт 1.0 хүн) сумд багтаж байна.


ХҮСНЭГТ 4.7.ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, ХУВИАР, СУМААР, 2010, 2020 ОН

Сумын нэр	2010 он			2020 он		
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүн/км <sup>2</sup>	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүн/км <sup>2</sup>
<b>БҮГД</b>	<b>95 804</b>	<b>100.0</b>	<b>2.3</b>	<b>107 755</b>	<b>100.0</b>	<b>2.6</b>
Сүхбаатар	19 692	20.5	433.7	22 578	21.0	479.3
Алтанбулаг	4 389	4.6	2.1	4 750	4.4	2.3
Баруунбүрэн	2 745	2.8	1.0	3 094	2.9	1.1
Баянгол	5 087	5.3	2.6	5 567	5.2	2.8
Ерөө	6 402	6.6	0.8	6 834	6.3	0.8
Жавхлант	1 808	1.9	1.5	1 970	1.8	1.7
Зүүнбүрэн	2 372	2.5	2.0	2 819	2.6	2.3
Мандал	24 752	25.8	5.1	27 011	25.1	5.6
Орхон	2 069	2.2	1.6	2 290	2.1	1.8
Орхонтуул	3 601	3.8	1.2	3 754	3.5	1.3
Сайхан	7 915	8.3	6.0	9 302	8.6	7.1
Сант	1 844	1.9	1.3	2 104	2.0	1.5
Түшиг	1 527	1.6	0.6	1 835	1.7	0.7
Хүдэр	2 067	2.2	0.7	2 706	2.5	1.0
Хушаат	1 796	1.9	0.9	2 067	1.9	1.0
Цагааннуур	3 946	4.1	1.0	5 081	4.7	1.3
Шаамар	3 792	4.0	5.6	3 993	3.7	5.9

ЗУРАГ 4.1.ХҮН АМЫН НЯГТРАЛ, СУМААР, 2020 ОН



# ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН



Монгол Улсын хүн амын шилжих хөдөлгөөн сүүлийн 20 орчим жилд маш их идэвхэжсэн. Тооллогоор байнга оршин сууж байсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс өөр газар руу 6, түүнээс дээш сарын хугацаагаар шилжин суурьшсан хүн амыг шилжих хөдөлгөөнд оролцсон гэж үзсэн. Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс гол төлөв хөдөөгөөс мэргэжил, боловсрол эзэмших, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээнд ойртох, хөдөлмөр эрхлэх зэрэг шалтгаанаар төв суурин газар руу шилжих нь нэмэгдэв.

Шилжих хөдөлгөөнийг тодорхой цаг хугацаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд авч үздэгийн дагуу шилжих хөдөлгөөнийг тооллогын товын үед:


- төрсөн нутгаасаа өөр газар амьдарч байгаа;
- таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газраасаа өөр газарт шилжиж ирсэн (Үүнд 5 жил 1 сарын хөдөлгөөнийг хамруулав)
- нэг жилийн өмнө байнга оршин сууж байсан газраасаа өөр газарт шилжиж ирсэн (Үүнд 1 сарын хөдөлгөөнийг хамруулав) гэсэн гурван үндсэн хугацаагаар авсан.

Шилжих хөдөлгөөний урсгал, шилжин суурьшсан хугацааг тооллогын товын үед байнга оршин сууж байсан газраа шилжиж ирсэн хүн бүрээс оршин суугаа хугацаа, өмнө нь байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийн нэрийг асууж тодорхойлов.

Олон улсад шилжих хөдөлгөөний чиг хандлагыг цаг хугацаагаар хэмжин судалдаг жишгийг үндэслэн хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоос эхлэн таван жилийн өмнөх шилжих хөдөлгөөнийг судалсан. Үүнийг тоолуулагч 2005 оноос өмнө болон хойших хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан товын үед болон товоос таван жилийн өмнө байнга сууж байсан газраар тооцоолсон болно. Анхаарах асуудал нь 2000 оны тооллогын тов 1 дүгээр сарын 4-нөөс 5-нд шилжих шөнө байсан бол 2020 оных 01 дүгээр сарын 9-нөөс 15-нд шилжих шөнө байсан гэдгийг судлаачид харгалзаж үзэх нь зүйтэй. Тав хүртэлх насны хүүхдүүд тооллого явуулахаас таван жилийн өмнө төрөөгүй байсан тул зөвхөн 5, түүнээс дээш насны хүмүүсээс уг асуултыг асуусан.

Шилжих хөдөлгөөнийг хэмжих хамгийн чухал хэмжүүр нь нутаг дэвсгэр буюу засаг захиргааны нэгж юм. Тооллогод аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнийг асууж тодорхойлсон.

ЗУРАГ 5.1. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУВИАР, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2010, 2020 ОН



Сүүлийн 5 жилд шилжилт хөдөлгөөнд оролцогчид 6704 байгаа нь 2010 оноос 49.8 хувиар буурчээ. Сүүлийн 1 жилд шилжилт хөдөлгөөнд оролцогчдын тоо 2744 бөгөөд үүнээс 1178 нь нийслэл, 1434 нь бусад аймаг хооронд шилжилт хөдөлгөөнд оролцсон байна.

Шилжих хөдөлгөөнийг хэмжих гурав дахь арга нь байнга оршин сууж байгаа хугацааг үндэслэсэн байв. Тооллогын үед байнга оршин сууц байсан аймаг, нийслэлд шилжиж ирсэн хүн нэг бүрээс байнга оршин сууж байгаа хугацаа, урьд нь байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийг асуусан.

Шилжих хөдөлгөөнийг хэмжих хамгийн чухал нэг хэмжүүр нь нутаг дэвсгэр буюу засаг захиргааны нэгж юм. Тооллогын шилжих хөдөлгөөний үзүүлэлтэд аймаг, нийслэл хоорондын хөдөлгөөнийг хамруулж, аймаг, нийслэл доторх шилжих хөдөлгөөнийг оруулаагүй болно.

Сүүлчийн 1 жилийн шилжих хөдөлгөөнд оролцогч 2.7 мянган хүн байгаа нь 2010 оныхтой харьцуулахад 31.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хүн амын 27.7 хувь нь шилжин иржээ. тэдгээрийн 1.6 хувь нь нэг жил хүртэл, 5.7 хувь нь 1-3 жил, 14.5 хувь нь 4-9 жил, 78.2 хувь нь 10, түүнээс дээш жилийн өмнө шилжин ирж суурьшжээ.

### ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнийг хугацаа үл харгалзан тухайн хүний төрсөн болон тоолох үед байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийг үндэслэн тооцов. Шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амд тооллогын үед төрсөн газраа байнга оршин суугаа хүнийг хамруулав.

Харин шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амд тоолох үед тухайн нутаг дэвсгэрээс өөр газар төрсөн, мөн тооллогын үед төрсөн газраа байнга оршин сууж байгаа боловч амьдралынхаа аль нэг хугацаанд бусад газарт 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар сууж байгаад эргэж ирсэн хүнийг хамруулав.

**ХҮСНЭГТ 5.1. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧИД ХУВИАР, ХҮЙСЭЭР 2010, 2020 ОН**

	2010 он			2020 он		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Төрснөөс хойш сууж байгаа	51.5	53.1	49.8	72.3	74.5	70.2
Шилжиж ирсэн	48.5	46.9	50.2	27.7	25.5	29.8

Аймгийн хүн амын 72.3 хувь, үүний дотор эрэгтэйчүүдийн 74.5 хувь, эмэгтэйчүүдийн 70.2 хувь нь төрснөөсөө хойш тухайн аймагт оршин сууж байна.

Сэлэнгэ аймгаас бусад аймаг, нийслэл рүү 36.9 мянган хүн шилжин явсан байхад тухайн аймагт 29.8 мянган хүн шилжин ирсэн байна. Сэлэнгэ аймагт ирж суурьшсан хүн амын дотор эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс цөөн, тус аймагт байнга оршин сууж байгаад өөр аймаг, нийслэл рүү явж суурьшсан хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байна.

**ХҮСНЭГТ 5.2. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧИД ХУВИАР, ХҮЙСЭЭР, 2020 ОН**

	Дүнд эзлэх хувь	Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний байдал		
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирсэн	Шилжин явсан
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Эрэгтэй	50.8	51.0	45.7	44.8
Эмэгтэй	49.2	49.0	54.3	55.2

Тооллогын үед тус аймагт байнга оршин суугаа хүн амын 51.5 хувь нь Сэлэнгэ аймагт төрснөөсөө хойш оршин суугаа бол 14.5 хувь нь Улаанбаатар хотоос, 14.3 хувь нь Увс аймгаас, 7.5 хувь нь Архангай аймгаас, 0.1-7.2 хувь нь бусад аймгаас шилжиж иржээ.

ХҮСНЭГТ 5.3. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ИРГЭД, АЙМАГ НИЙСЛЭЛЭЭР, ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Шилжиж ирсэн			Шилжиж явсан		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Архангай	7.5	8.8	6.5	0.6	0.6	0.6
Баян-Өлгий	5.4	5.7	5.2	0.3	0.3	0.2
Баянхонгор	4.8	4.6	5.0	0.1	0.1	0.0
Булган	3.2	2.9	3.4	0.8	1.1	0.5
Говь-Алтай	5.1	4.8	5.3	0.3	0.3	0.3
Дорноговь	1.4	1.2	1.6	1.7	2.0	1.5
Дорнод	1.3	1.2	1.3	0.6	0.3	0.8
Дундговь	1.3	1.2	1.4	0.1	0.1	0.0
Завхан	6.6	6.8	6.5	0.2	0.2	0.1
Өвөрхангай	3.3	3.1	3.5	0.4	0.4	0.5
Өмнөговь	0.5	0.4	0.6	1.4	1.7	1.2
Сүхбаатар	0.4	0.5	0.4	0.3	0.4	0.2
Төв	5.2	4.7	5.5	2.8	3.0	2.6
Увс	14.3	14.7	14.0	0.1	0.1	0.0
Ховд	7.0	7.0	7.0	0.3	0.3	0.2
Хөвсгөл	8.0	7.3	8.6	0.9	0.9	0.9
Хэнтий	1.1	1.0	1.2	0.4	0.5	0.4
Дархан-Уул	7.2	7.0	7.3	18.0	17.4	18.4
Улаанбаатар	14.5	15.3	13.8	64.5	63.8	65.0
Орхон	1.5	1.4	1.5	5.9	5.8	5.9
Говьсүмбэр	0.1	0.1	0.1	0.6	0.7	0.5
Гадаад*	0.4	0.4	0.3	0.0	0.0	0.0

Баруун бүсийн аймгуудад төрөөд Сэлэнгэ аймагт амьдарч буй хүн амын дотор эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо байхад бусад аймаг, нийслэлд төрөөд тус аймагт байнга оршин суугаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага зэрэг илүү байна.

Сэлэнгэ аймагт оршин сууж байгаад шилжин явсан хүн 36.9 мянга байгааг шилжин суурьшсан аймгаар харвал Улаанбаатар хотод 64.5 хувь, Дархан-Уул аймагт 18.0 хувь, Орхон аймагт 5.9 хувь, Төв аймагт 2.8 хувь шилжин суурьшсанаас үзэхэд шилжих хөдөлгөөний гол чиглэл нь Улаанбаатар хот болон Төвийн бүсийн бусад аймаг байна.

Хүснэгт 5.4-д төрснөөс хойших шилжигчдийн урсгалыг бүс нутгаар тодорхойлсон байдлыг харуулав.

**НЭГДСЭН ДҮН**

ХҮСНЭГТ 5.4. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, ТӨРСӨН БҮС НУТГААР 2010,2020 ОН

Төрсөн бүс	Хүн амын тоо	Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний байдал		
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгчид	Шилжин явагчид
<b>2010</b>				
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Баруун	22.5	18.5	1.0	31.8
Хангай	25.7	25.1	6.4	27.5
Төв	18.2	16.9	15.9	21.2
Зүүн	9.7	9.2	1.7	10.9
Улаанбаатар	23.1	30.3	75.0	5.9
Гадаад*	0.8	-	-	2.7
<b>2020</b>				
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Баруун	19.2	15.5	0.9	33.0
Хангай	23.1	21.8	6.7	28.2
Төв	17.8	16.9	14.4	21.2
Зүүн	9.3	9.0	1.7	10.5
Улаанбаатар	30.3	36.8	76.3	5.8
Гадаад*	0.3	-	-	1.3

\*Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнгээр төрсөн бүсдээ байнга амьдарч байгаа хүн амын эзлэх хувь хамгийн өндөр байгаа бүс нь баруун бүс (98.6 хувь) бөгөөд өмнөх тооллогоос 0.7 пунктээр, дараа нь зүүн бүсийнх (95.2 хувь) 2.4 пунктээр, хангайн (92.5 хувь) бүсийнх 2.3 пунктээр, төвийн (81.6 хувь) бүсийнх 10.1 пунктээр, Улаанбаатар (64.6 хувь) хотынх 15.7 пунктээр тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 5.5. ШИЛЖИН ИРСЭН ИРГЭД, ОРШИН СУУГАА ХУГАЦАА, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2020 ОН

Оршин суугаа хугацаа	Бүгд	Насын бүлэг		
		0-14	15-59	60+
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
1 жил хүртэл	1.6	7.9	1.3	0.3
1-3 жил	5.8	23.7	5.4	1.0
4 жил	2.1	8.8	1.8	0.8
5-6 жил	4.7	19.1	4.5	0.6
7-9 жил	7.7	20.5	8.1	1.8
10-12 жил	12.0	17.7	13.4	4.5
13-15 жил	7.0	2.3	8.6	2.9
16-19 жил	10.2	0.0	12.2	6.1
20, түүнээс дээш жил	49.0	0.0	44.8	82.1

Сэлэнгэ аймагт шилжин ирсэн хүн амын 14.2 хувь нь сүүлчийн 6 жилд, 36.9 хувь нь 7-19 жил, 49.0 хувь нь 20-оос дээш жил оршин сууж байна. Сэлэнгэ аймгийн хот, тосгонд шилжин ирж суурьшигчдын 49.2 хувь нь эрэгтэйчүүд, 50.8 хувь эмэгтэйчүүд байна.

**ЗУРАГ 5.2. ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦСОН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2020 ОН**



Хүн амын шилжих хөдөлгөөнд оролцсон байдлыг насны бүлгээр авч үзвэл сонирхолтой дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал, 0-24 насны хүн амын дийлэнх нь тухайн аймгийн уугуул иргэд байхад 25-29 наснаас эхлэн шилжин ирэгчдийн эзлэх хувь эрс нэмэгдэж, 25-29 насныхны 26.6 хувь, 55-59 насныхны 54.1 хувь, 70-аас дээш насныхны 66.7 хувь нь нь шилжин ирэгчид болжээ.

### ТАВАН ЖИЛИЙН ӨМНӨХТЭЙ ХАРЬЦУУЛСАН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор 5 жилийн шилжих хөдөлгөөнийг 2015 оны 1 дүгээр сард байнга сууж байсан аймаг, нийслэлээр авсан.

ХҮСНЭГТ 5.6 ТАВАН ЖИЛИЙН ӨМНӨ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦСОН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР, 2020 ОН

Хүйс	5, түүнээс дээш насны хүн ам	5 жилийн өмнөх шилжих хөдөлгөөний байдал			Цэвэр шилжих хөдөлгөөн (+/-)
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин иргэсэд	Шилжин явагсад	
<b>2010 он</b>					
<b>БҮГД</b>	<b>83 809</b>	<b>70 451</b>	<b>13 358</b>	<b>16 079</b>	<b>-2 721</b>
Эрэгтэй	42 639	35 679	6 960	7 958	-998
Эмэгтэй	41 170	34 772	6 398	8 121	-1 723
<b>2020 он</b>					
<b>БҮГД</b>	<b>95 866</b>	<b>89 162</b>	<b>6 704</b>	<b>8 749</b>	<b>-2 045</b>
Эрэгтэй	48 777	45 310	3 467	4 227	-760
Эмэгтэй	47089	43 852	3 237	4 522	-1 285

Олон улсад шилжих хөдөлгөөний чиг хандлагыг цаг хугацаагаар хэмжин судалдаг жишгийг үндэслэн хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоос эхлэн таван жилийн өмнөх шилжих хөдөлгөөнийг судалсан. Үүнийг тоолуулагч 2015 оноос өмнө болон хойших хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан товын үед болон товоос таван жилийн өмнө байнга сууж байсан газраар тооцоолсон болно. Тав хүртэлх насны хүүхдүүд тооллого явуулахаас таван жилийн өмнө төрөөгүй байсан тул зөвхөн тав, түүнээс дээш насны хүмүүсээс уг асуултыг асуусан.

Таван жилийн өмнө тус аймагт амьдарч байсан 8749 хүн тооллогын үед өөр аймаг, нийслэл рүү явж суурьшсан бол бусад аймаг, нийслэлээс энэ хугацаанд 6704 хүн ирж суурьшсан байна. Таван жилийн шилжих хөдөлгөөний дүнд аймгийн хүн ам 2045 хүнээр буурчээ.

## НЭГ ЖИЛИЙН ӨМНӨХТЭЙ ХАРЬЦУУЛСАН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Тооллогын товоос өмнөх нэг жилийн шилжих хөдөлгөөн нь төрснөөс хойш болон 5 жилийн өмнөхийг бодвол богино хугацаатай учир тоолуулж байгаа хүн хариулахад хялбар байдаг. Тиймээс төрснөөс хойш болон 5 жилийн өмнөх шилжих хөдөлгөөний талаар өгсөн мэдээллээс илүү бодитой байж болох талтай.

### ХҮСНЭГТ 5.7. НЭГ ЖИЛИЙН ӨМНӨ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, ХҮЙСЭЭР 2010, 2020 ОН

Хүйс	Сүүлийн нэг жилийн өмнөх шилжих хөдөлгөөний байдал				Цэвэр шилжих хөдөлгөөн (+/-)
	Шилжин ирэгчид	Дүнд эзлэх хувь	Шилжин явагчид	Дүнд эзлэх хувь	
<b>2010 он</b>					
<b>БҮГД</b>	<b>4 039</b>	<b>100.0</b>	<b>5 038</b>	<b>100.0</b>	<b>-999</b>
Эрэгтэй	2 157	53.4	2 498	49.6	-341
Эмэгтэй	1 882	46.6	2 540	50.4	-658
<b>2020 он</b>					
<b>БҮГД</b>	<b>2 744</b>	<b>100.0</b>	<b>4 655</b>	<b>100.0</b>	<b>-1 911</b>
Эрэгтэй	1 596	58.2	2 370	50.9	-774
Эмэгтэй	1 148	41.8	2 295	49.1	-1 147

Сүүлчийн нэг жилд Сэлэнгэ аймгийн хүн ам шилжих хөдөлгөөний улмаас 1911 хүнээр буурчээ. Тэдгээрийн 60.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

### ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН НАС, ХҮЙСНИЙ БҮТЭЦ


Шилжих хөдөлгөөнийг хугацаа, нутаг дэвсгэрээс гадна хүн ам зүй, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд тухайлбал, нас, хүйс, боловсрол, гэрлэлтийн байдал эдийн засгийн идэвх, орлого, өрхийн сууцны нөхцөл, дэд бүтцийн хангамж зэрэг олон үзүүлэлттэй хамруулан судлах нь илүү ач холбогдолтой юм. Хэдийгээр тооллогоор цуглуулсан мэдээлэл, үзүүлэлтүүд хязгаарлагдмал ч энэ сэдвээр олон талаас нь нарийвчлан судлах боломж бий бөгөөд дараа дараагийн түүвэр судалгаа хийх хамгийн өргөн хүрээний эх олонлог болно.

ХҮСНЭГТ 5.8. СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧИД , НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР,  
 2010, 2020 ОН

Насын бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>2010 он</b>						
<b>БҮГД</b>	<b>4 044</b>	<b>100.0</b>	<b>2159</b>	<b>100.0</b>	<b>1 855</b>	<b>100.0</b>
0-4	512	12.6	270	12.5	242	12.8
5-9	302	7.5	146	6.8	156	8.3
10-14	274	6.8	141	6.5	133	7.1
15-19	298	7.4	167	7.7	131	7.0
20-24	763	18.9	357	16.6	406	21.5
25-29	444	11.0	232	10.8	212	11.3
30-34	367	9.0	206	9.5	161	8.5
35-39	322	8.0	188	8.7	134	7.1
40-44	254	6.3	154	7.1	100	5.3
45+	508	12.8	298	13.8	210	11.1
<b>2020 он</b>						
<b>БҮГД</b>	<b>2 744</b>	<b>100.0</b>	<b>1596</b>	<b>100.0</b>	<b>1 148</b>	<b>100.0</b>
0-4	302	11.0	156	9.8	146	12.7
5-9	313	11.4	157	9.8	156	13.6
10-14	149	5.4	77	4.8	72	6.3
15-19	137	5.0	82	5.1	55	4.8
20-24	385	14.0	190	11.9	195	17.0
25-29	339	12.4	202	12.7	137	11.9
30-34	330	12.0	202	12.7	128	11.1
35-39	210	7.7	151	9.5	59	5.1
40-44	159	5.8	109	6.8	50	4.4
45+	420	15.3	270	16.9	150	13.1

Сүүлийн нэг жилд шилжих хөдөлгөөнд оролцсон эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 39 хувиар илүү байгаа нь эрэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд давамгайлж байгааг харуулна. Ялангуяа 20-54 насны эрэгтэйчүүд илүү байгаа юм. Ахимаг насанд эрэгтэйчүүдийн шилжих хөдөлгөөн давамгайлж байгааг тэд эхлээд зорьсон газраа ганцаараа очиж, дараа ар гэрийнхнийгээ татаж авч байгаатай холбон тайлбарлаж болно. Арван таваас доош насны хүүхдүүд, 60-аас дээш насны өндөр настнууд шилжих хөдөлгөөнд оролцсон байгаагаас үзэхэд гэр бүлээрээ шилжих явдал байгааг гэрчилнэ.

ЗУРАГ 5.3. СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧИД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН




Хотын хүн амын өсөлтийн дийлэнхийг шилжих хөдөлгөөний өсөлт бүрдүүлдэг. Нийслэлээс гадна аймгийн төв орон нутагтаа боловсрол, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээний чанараар хөдөөгөөс илүү байдгийн зэрэгцээгээр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, ажлын байр олох боломж илүү байдаг нь тодорхой юм. Ялангуяа сүүлчийн жилүүдэд тохиолдож байгаа байгалийн гамшигт үзэгдлүүд нь малчдад хүндээр тусч, төв суурин газарт шилжих нь нэмэгдсэнээс манай улсын хотжих үйл явц өмнөхөөсөө илүү хурдацтай явагдаж байна.

Сэлэнгэ аймаг улсын хүн амын 3.4 хувийг эзэлж, хүн амын тоогоор Хөвсгөл, Өвөрхангай аймгийн дараа орж байна. Сэлэнгэ аймаг дэд бүтэц сайн хөгжсөн хэдий ч хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас 2010-2020 оны тооллогын хугацаанд хүн амын жилийн дундаж өсөлт 1.5 хувиар өссөн байна.

Сэлэнгэ аймгийн хотын хүн амын хувь 2010 оны тооллогоор 49.1 байсан бол 2020 оны тооллогоор 34.5 хувь болж 14.6 пунктээр буурчээ. Хоёр тооллогын хооронд хотын хүн ам 11951 хүнээр өссөн нь дунд зэргийн хүн амтай 3 сумын хүн амын дүн гэсэн үг.

## БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ



10, түүнээс дээш  
насны хүн ам

- A** Боловсролгүй
- B** Бага
- C** Суурь
- D** Бүрэн дунд
- E** Техникийн болон мэргэжлийн
- F** Тусгай мэргэжлийн дунд
- H** Дээд

Хүний хөгжлийн үзүүлэлтийн нэг болох хүн амын боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэгийг илэрхийлэх үзүүлэлтийг тус улсын хүн амын тооллого болгонд тусгасан учраас эдгээр үзүүлэлтийн өөрчлөлтийг тодорхойлох бүрэн боломжтой.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын асуулгад бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшинтэй холбогдох асуултыг 6, түүнээс дээш насны бүх хүнээс, 2-39 насны хүнээс сургуульд сурдаг, цэцэрлэгт хүмүүждэг эсэхийг асуусан.

## БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд, шилжсэнээс хойших 20 орчим жилд боловсролын тогтолцоог шинэчилж, хөгжингүй орны боловсролын стандартыг нэвтрүүлж байна. Тооллого хоорондын хүн амын боловсролын түвшинг зэрэгцүүлэн жишиж өөрчлөлтийг харах нь чухал билээ. Төвлөрсөн төлөвлөгөөт нийгмийн харилцаанд мөрдөж байсан боловсролын ангилал 2010 оны тооллогын үеийнхээс нэлээд ялгаатай болсон тул 2010, 2020 оны тооллогын дүнг тодорхой хэмжээгээр бүлэглэж зэрэгцүүлсэн. Энэ удаа хүн амын боловсролын түвшинг НҮБ-ын зөвлөмж, олон улсын нийтлэг жишгийг харгалзан 10, түүнээс дээш насныханд тодорхойлов.

Арав түүнээс дээш настай хүн амд боловсролтой хүн амын эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс 2.8 пунктээр нэмэгдэж, 95.7 хувь болсон байна.

### ХҮСНЭГТ 6.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Боловсролын түвшин	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>
Боловсролгүй	7.1	7.4	6.8	4.3	4.5	4.1
Боловсролтой	92.9	92.6	93.2	95.7	95.5	95.9
Бага	16.6	17.1	16.0	12.5	12.8	12.1
Суурь	23.4	26.9	19.8	22.5	25.4	19.5
Бүрэн дунд	35.0	35.0	35.1	34.8	35.5	34.0
Техникийн болон мэргэжлийн	4.6	5.3	3.9	6.5	7.8	5.3
Тусгай мэргэжлийн дунд	7.1	5.2	9.1	5.6	4.9	6.3
Дээд	13.3	10.5	16.1	18.1	13.6	22.7

Улсын болон хувийн хэвшлийн олон их дээд сургууль байгуулагдаж, түүнд олон арван мянган залуучууд суралцан, төгсөж байгаагийн дүнд 10, түүнээс дээш насны нийт хүн амд дээд боловсролтой хүний эзлэх хувь өнгөрсөн 10 жилд 4.8 пунктээр нэмэгдсэн нь эерэг үзүүлэлт байгаа боловч үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллах дунд мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн эзлэх хувь буурсан байна. Мөн бага, суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн хувийн жин буурсан нь эцэг эхчүүд хүүхдэдээ аль болох дээд боловсрол эзэмшүүлэх сонирхолтой болсонтой холбоотой.

Боловсрол эзэмшигчийг хүйсээр ангилж үзэхэд нэлээд ялгаатай байдал ажиглагдана. Энэ удаагийн тооллогоор дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 9.1 хувиар илүү байна.

Арав түүнээс дээш насны нийт хүн амд боловсролгүй хүн амын эзлэх хувь нэлэнхийдээ буурсны дотор эрэгтэйчүүдийнх илүү буурчээ. Өмнөх тооллогуудын дүнгээс үзэхэд ахимаг насныхны боловсролын түвшин залуу үеийнхтэй харьцуулахад бага байсан бол сүүлийн үед нас дэвшилтээс шалтгаалан боловсрол өндөртэй залуу үе бага боловсролтой ахмад насны хүмүүсийг түрж, боловсролын түвшний ерөнхий байдал сайжрахад нөлөөлсөн.

Хүн амын боловсролын түвшин дээшлэх тутам хот, хөдөөд ялгаа нь нэмэгдэх ажээ.

**ХҮСНЭГТ 6.2. АРАВ ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХОТ ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН**

Боловсролын түвшин	Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Боловсролгүй	4.0	4.2	3.8	4.5	4.7	4.3
Боловсролтой	96.0	95.8	96.2	95.5	95.3	95.7
Бага	10.6	10.8	10.5	12.6	13.0	12.2
Суурь	19.1	22.1	16.1	22.8	25.4	20.1
Бүрэн дунд	34.6	36.1	33.1	32.6	32.8	32.4
Техникийн болон мэргэжлийн	5.6	6.6	4.7	6.6	7.8	5.2
Тусгай мэргэжлийн дунд	5.8	4.8	6.7	5.1	4.5	5.7
Дээд	20.3	15.4	25.2	15.8	11.7	20.0

Боловсролгүй хүний эзлэх хувь хөдөөд хотоос 0.5 пунктээр их бол дээд боловсролтой хотын хүн ам хөдөөгийнхөөс 4.5 пунктээр их байна. Харин хотод бүрэн дунд боловсролтой хүн ам олон байхад хөдөөд суурь болон бага боловсролтой хүн илүү олон байна. Хөдөөгийн дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс өндөр, суурь болон бага боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа нь хөдөөгийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсролтойг харуулжээ. Энэ байдал хот суурин газарт мөн ажиглагдаж байна.

**НЭГДСЭН ДҮН**


ХҮСНЭГТ 6.3. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2020 ОН

Насны бүлгээр	2010 он							
	Бүгд	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>7.2</b>	<b>15.3</b>	<b>21.8</b>	<b>32.6</b>	<b>4.3</b>	<b>6.6</b>	<b>12.2</b>
10-14	100.0	36.1	59.6	4.3				
15-19	100.0	2.8	16.2	51.6	25.0	2.9	1.2	0.3
20-24	100.0	3.7	5.0	13.9	49.2	5.9	3.0	19.3
25-29	100.0	4.0	8.1	17.8	39.3	2.7	2.2	25.9
30-34	100.0	2.7	6.3	23.4	43.8	2.6	3.4	17.8
35-39	100.0	1.8	3.3	22.4	45.3	6.2	8.1	12.9
40-44	100.0	2.1	4.0	21.2	43.1	7.2	11.5	10.9
45-49	100.0	2.6	5.2	23.0	35.5	7.2	13.0	13.5
50-54	100.0	1.9	8.5	26.5	28.3	6.9	15.1	12.8
55-59	100.0	2.3	12.8	23.7	26.0	6.1	17.0	12.1
60+	100.0	6.9	31.0	16.5	18.5	3.1	13.4	10.6
2020 он								
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>4.3</b>	<b>11.9</b>	<b>21.5</b>	<b>33.3</b>	<b>6.2</b>	<b>5.3</b>	<b>17.3</b>
10-14	100.0	27.4	72.2	0.4				
15-19	100.0	1.8	5.6	61.3	27.2	3.1	0.7	0.3
20-24	100.0	1.9	2.5	15.6	51.8	6.3	2.4	19.5
25-29	100.0	1.2	2.1	11.2	35.4	8.5	3.6	38.0
30-34	100.0	1.6	3.0	14.0	38.3	5.9	3.2	34.0
35-39	100.0	1.9	4.6	20.9	39.6	4.3	2.7	26.0
40-44	100.0	1.2	3.0	25.8	42.9	5.6	4.1	17.4
45-49	100.0	0.8	2.8	22.8	42.4	9.3	7.9	14.0
50-54	100.0	1.3	3.2	22.8	38.8	10.2	10.9	12.8
5-59	100.0	1.2	3.7	23.6	33.2	11.0	12.6	14.7
60+	100.0	1.4	12.5	24.5	25.7	7.9	14.9	13.1

Боловсролын түвшинг насаар ангилж үзэхэд зарим сонирхолтой дүр зураг ажиглагдана. Дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүний эзлэх хувь 30-34 наснаас өсөж байснаа 45-59 насанд буурч, цаашдаа өсжээ. Энэ нь 1960-аад оны эхнээс манай улсад дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой боловсон хүчнийг олноор нь бэлтгэж байсантай холбоотой. Харин 25-29 насны дээд боловсролтой хүний эзлэх хувийн жин хамгийн өндөр, 20-24 насны боловсролгүй хүний эзлэх хувь бусад насныхнаас өндөр байна. Энэ нь нийгэм, эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдсөн шилжилтийн үед сургууль завсардалт өндөр байсныг гэрчилнэ. Ерөнхийдөө 20-40 хүртэл насны хүмүүсийн боловсролын түвшин сайн харагдаж байна. Гэвч тухайн насны хүн амын дотор мэргэжлийн боловсролтой хүний эзлэх хувь бага байгаа нь үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжилтэй ажилчдын хүрэлцээ хангалтгүй байгааг харуулна.

**НЭГДСЭН ДҮН**

**ЗУРАГ 6.1. ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН**




Дээрх графикаас харахад ихэнх насны бүлэгт эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээс илүү дээд боловсрол эзэмшсэн байна.

**БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ**

Бичиг үсгийн мэдлэгийн тодорхойлолтын талаарх НҮБ-ын зөвлөмжийг 2010, 2020 оны тооллогод үндсэнд нь баримталсан юм. Аль нэг хэлээр энгийн өгүүлбэрийг уншиж ойлгодог, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзсэн. Зургаа, түүнээс дээш насны боловсролгүй хүнээс бичиг үсэг мэддэг эсэхийг тодруулж асуусан.

**ЗУРАГ 6.2. ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГЭЭР, 2020 ОН**



Хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшинг олон улсын хэмжээнд зэрэгцүүлэхийн тулд 15, түүнээс дээш насаар тодорхойлов.


ХҮСНЭГТ 6.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Бичиг үсгийн мэдлэг	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Бичиг үсэг мэддэг	98.4	98.8	98.0	98.6	99.1	98.3
Бичиг үсэг мэддэггүй	1.6	1.2	2.0	1.4	0.9	1.7

Сэлэнгэ аймгийн 15, түүнээс дээш насны хүн амын 98.6 хувь бичиг үсэг мэдэж байгаа нь улсын дунджаас өндөр үзүүлэлт юм. Харин хот, хөдөөгийн оршин суугчдын хувьд 0.8 пунктээр зөрүүтэй байгаа нь улсын дундажтай харьцуулбал ялгаа багатайг илэрхийлж байна. арван тав, түүнээс дээш насны хотын хүн амын 0.9 хувь буюу 26 хүн бичиг үсэг мэдэхгүй байгаагаас үзэхэд хотынхон бараг бүхэлдээ бичигтэн болсон гэж болно.

Бичиг үсэг мэдэхгүй хүн амын эзлэх хувийг насаар ангилж үзэхэд анхаарах асуудал ажиглагдана. 15-29 насны залуучуудын 1.7 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаа боловч тэд нийт бичиг үсэг мэддэггүй 15, түүнээс дээш насны хүн амын 10.7 хувийг эзэлж байна. Бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь 35-39 насанд харьцангуй өндөр байгаа бөгөөд улсын дунджаас их байгааг доорх зургаас харж болно.

ЗУРАГ 6.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД БИЧИГ ҮСЭГ МЭДДЭГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН



### СУРГУУЛЬ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод сургуульд суралцаж байгаа болон цэцэрлэгт хүмүүжиж байгаа эсэхийг 2-39 насныхнаас асуусан.

НҮБ-ын зөвлөмжийн дагуу сургуульд суралцах насыг 5-29 насаар авч үзэх ёстой боловч манай улсын боловсролын шинэ тогтолцооны дагуу хүүхдийг 6 наснаас эхлэн сургуульд элсүүлэх болсонтой холбогдуулан сургуульд хамрагдалтыг 6-29 насаар тодорхойлов.

Аймгийн хэмжээнд 6-29 насны хүн амын 73.9 хувь, эрэгтэйчүүдийн 71.5 хувь, эмэгтэйчүүдийн 76.4 хувь нь сургуульд сурч байна. Харин 6 настай хүүхдүүдийн 96.3 хувь нь, 7 настай хүүхдүүдийн 98.7 хувь нь сургуульд сурч байна.

Сургуульд хамрагдалт 11 жилийн өмнөхөөс сайжирчээ. Тухайлбал, 2010 онд 6 настай бүх хүүхдийн 94.4 хувь нь сургуульд сурч байсан бол 2020 онд 96.3 хувь болж өсжээ. Есөн настай хүүхдийн сургуульд хамрагдалт 2010 онд 98.9 хувь байсан нь хамгийн өндөр байсан бол 2020 онд 99.5 хувь болж нэмэгдэв. Сургуульд хамрагдалт арван нэгэн жилийн өмнө 15 наснаас нэлээд буурч байсан бол 2020 онд уг үзүүлэлт өсөж байгаагаас үзэхэд бүрэн дунд боловсрол эзэмших насны хүүхдийн сургуульд хамрагдалт эрс нэмэгдсэн гэж дүгнэх үндэслэлтэй юм. (Хүснэгт 6.5).

ХҮСНЭГТ 6.5. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Нас	Сургуульд суралцаж байгаа			Сургуульд суралцаагүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>6-29</b>	73.9	71.5	76.4	26.1	28.5	23.6
<b>6-9</b>	<b>98.5</b>	<b>98.3</b>	<b>98.8</b>	<b>1.5</b>	<b>1.7</b>	<b>1.2</b>
6	96.3	95.7	96.8	3.7	4.3	3.2
7	98.7	98.4	99.0	1.3	1.6	1.0
8	99.7	99.5	99.9	0.3	0.5	0.1
9	99.5	99.4	99.7	0.5	0.6	0.3
<b>10-14</b>	<b>99.8</b>	<b>99.8</b>	<b>99.8</b>	<b>0.2</b>	<b>0.2</b>	<b>0.2</b>
10	99.9	99.9	99.9	0.1	0.1	0.1
11	99.9	99.8	99.9	0.1	0.2	0.1
12	99.8	99.9	99.8	0.2	0.1	0.2
13	99.9	99.9	99.9	0.1	0.1	0.1
14	99.6	99.5	99.6	0.4	0.5	0.4
<b>15-19</b>	<b>92.5</b>	<b>90.1</b>	<b>95.0</b>	<b>7.5</b>	<b>9.9</b>	<b>5.0</b>
15	98.9	98.6	99.2	1.1	1.4	0.8
16	97.7	97.0	98.4	2.3	3.0	1.6
17	96.9	96.3	97.4	3.1	3.7	2.6
18	88.5	83.8	93.3	11.5	16.2	6.7
19	82.0	76.4	87.8	18.0	23.6	12.2
<b>20-24</b>	<b>55.6</b>	<b>52.0</b>	<b>59.6</b>	<b>44.4</b>	<b>48.0</b>	<b>40.4</b>
20	78.4	72.1	85.7	21.6	27.9	14.3
21	71.9	65.0	79.1	28.1	35.0	20.9
22	56.4	52.5	60.6	43.6	47.5	39.4
23	41.3	40.4	42.2	58.7	59.6	57.8
24	30.0	29.7	30.4	70.0	70.3	69.6
<b>25-29</b>	<b>17.2</b>	<b>15.5</b>	<b>19.2</b>	<b>82.8</b>	<b>84.5</b>	<b>80.8</b>
25	26.2	25.5	27.0	73.8	74.5	73.0
26	22.9	19.7	26.6	77.1	80.3	73.4
27	16.0	14.2	18.2	84.0	85.8	81.8
28	12.7	11.6	14.1	87.3	88.4	85.9
29	10.6	8.9	12.7	89.4	91.1	87.3

Сургуульд хамрагдалт хот, хөдөөд ойролцоо байна. Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт нийт дүнгээрээ хотод 79.1 хувь, хөдөөд 70.9 хувь байна.

**ХҮСНЭГТ 6.6. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН**


Нас	Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>6-29</b>	<b>79.1</b>	<b>77.4</b>	<b>81.0</b>	<b>70.9</b>	<b>68.2</b>	<b>73.8</b>
6	96.6	96.5	96.6	96.1	95.2	96.9
7	98.5	98.3	98.8	98.8	98.5	99.1
8	99.5	99.3	99.7	99.8	99.6	100.0
9	99.6	99.6	99.6	99.5	99.2	99.8
<b>6-9</b>	<b>98.5</b>	<b>98.4</b>	<b>98.7</b>	<b>98.6</b>	<b>98.2</b>	<b>99.0</b>
<b>10-14</b>	<b>99.9</b>	<b>99.9</b>	<b>99.8</b>	<b>99.8</b>	<b>99.7</b>	<b>99.8</b>
<b>15-17</b>	<b>98.0</b>	<b>97.9</b>	<b>98.1</b>	<b>97.7</b>	<b>96.9</b>	<b>98.4</b>
15	98.9	98.8	99.0	98.9	98.5	99.3
16	98.3	98.0	98.7	97.2	96.2	98.2
17	96.9	96.9	96.8	96.9	95.9	97.8
<b>6-17</b>	<b>99.0</b>	<b>98.9</b>	<b>99.1</b>	<b>98.8</b>	<b>98.5</b>	<b>99.2</b>
18	91.8	89.1	94.8	86.5	80.3	92.5
19	84.9	80.3	89.8	80.5	74.3	86.8
<b>20-24</b>	<b>59.3</b>	<b>55.6</b>	<b>63.2</b>	<b>54.1</b>	<b>50.4</b>	<b>58.1</b>
<b>25-29</b>	<b>19.9</b>	<b>18.0</b>	<b>22.1</b>	<b>16.0</b>	<b>14.5</b>	<b>17.9</b>

Сургуульд хамрагдалтыг хүйсээр харвал 2010 онтой харьцуулахад сургуульд хамрагдалтын байдал 6-14 насны хүн амын хувьд ижил түвшинд байгаа ч 15, түүнээс дээш насанд буюу суурь боловсролын түвшнийг дүүргэсний дараагаар эрэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад буурсан харагдаж байна.

Сургуульд хамрагдалтын байдал 20-24 насны хүн амд 59.3 хувь болж 2010 оноос 41.5 пунктээр өссөн нь хамгийн өндөр байна. Сургуульд хамрагдалтыг хот, хөдөөгөөр харвал 14 нас хүртэл хөдөөд өндөр байсан бол 15, түүнээс дээш насанд хотын хүн амын сургууль хамрагдалт өндөр болж байна. Энэ хандлага нь нас ахих тусам нэмэгдсээр 25-29 насанд хотын хүн амын сургуульд хамрагдалт хөдөөгийнхөөс 3.9 пунктээр өндөр байна.

Хүйсийн харьцаа 100-тай тэнцүү байхад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд адил хэмжээгээр сургуульд суралцаж байна гэсэн утга билээ. Хүйсийн харьцаа 20-24 наснаас эхлэн нэлээд өссөн бөгөөд улсын дундажтай харьцуулахад өндөр байна.

**ЗУРАГ 6.4. СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАС БҮЛГЭЭР, 2020 ОН**




Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нас буюу 2-оос 5 насны хүүхдийн 84.7 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байна. Сургуульд орох нас дөхөх тусам сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт нэмэгдэх ажээ. Тухайлбал, 2 настай хүүхдийн 65.0 хувь, 5 настай хүүхдүүдийнх 95.3 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна.

**ХҮСНЭГТ 6.7. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН**

Нас	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>8 041</b>	<b>84.7</b>	<b>4 030</b>	<b>83.4</b>	<b>4011</b>	<b>86.0</b>
2	1 490	65.0	707	61.6	783	68.5
3	1 980	85.6	1 000	84.1	980	87.3
4	2 199	91.4	1 097	91.3	1102	91.5
5	2 372	95.3	1 226	94.6	1146	96.1


## ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ



## ӨРХИЙН ТОО, БҮТЭЦ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор өрхийг өмнөх тооллогын нэгэн адил судалсан боловч өрхөд тоологдсон, өрх үүсгээгүй тоологдсон хүний тодорхойлолт өмнөх тооллогоос ялгаатай байлаа. Гэр бүл, ураг төрлийн хамааралтай хүмүүс өрх үүсгэж тоологдох, хоорондоо огт хамааралгүй хүмүүс нэг орон байранд хамт тоологдох гэсэн 2 хэлбэр байлаа. Өрхөд хамаарахгүй хүмүүст цэрэг, хоригдол, оюутнууд, албан болон албан бусаар ашигт малтмал олборлогчид, орон гэргүй иргэд зонхилж байв.

ЗУРАГ 7.1. ӨРХ, ӨРХӨД ХАМААРАЛГҮЙ ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, 2020 ОН




Аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 97.9 хувь буюу 105.5 мянган хүн өрхөд, үлдсэн 2.1 хувь буюу 2.2 мянган хүн өрхөд хамаарахгүйгээр тоологджээ. Аймгийн хэмжээнд өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 7.9 хувиар нэмэгдэж, өрхөд хамаарахгүйгээр тоологдсон хүн ам 15.3 хувиар буурчээ.

ХҮСНЭГТ 7.1. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Байршил	2010		2020		2020/2010
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	
<b>БҮГД</b>	<b>26 889</b>	<b>100.0</b>	<b>29 004</b>	<b>100.0</b>	<b>107.9</b>
Хот	13 340	49.6	9 858	34.0	73.9
Хөдөө	13 549	50.4	19 146	66.0	141.3

Хотын өрх 26.1 хувиар буурч, хөдөөгийн өрх 41.3 хувиар нэмэгджээ. Улсын дүнтэй харьцуулахад хөдөөгийн өрхийн хувь их байна. Энэ нь шилжин ирэгчид хөдөөд газар тариалан, мал аж ахуй эрхлэх зэргээр хөдөө рүү чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн их байгаатай холбоотой.

ЗУРАГ 7.2. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН



Хүн ам, орон сууны 2010 оны тооллогоос эхлэн НҮБ-ын аргачлалын дагуу өрхийг хэлбэрээр нь ангилан тодорхойлж байна. Ингэж ангилахдаа өрхийн гишүүд өрхийн тэргүүлэгчтэйгээ ямар хамааралтай болохыг харгалзаж үздэг.

Нийт өрхийн 13.4 хувь нь ганц бие, 60.0 хувь нь ам бүлээрээ байгаа, 25.3 хувь нь нийлмэл, 1.3 хувь нь холимог ам бүлтэй өрх байна. Нийт өрхийн дотор ам бүлээрээ буюу нөхөр, эхнэр, хүүхдийнхээ хамт амьдарч байгаа өрх дийлэнх хувийг эзэлж байна. Мөн нийлмэл буюу эцэг эх, ах, дүүс, садан төрлөөрөө хамт амьдарч байгаа өрх ч олон юм. Энэ нь өрхийн ам бүлийн бүтцийн түгээмэл хэлбэрүүд бөгөөд үр хүүхэд, хамаатан садантайгаа хамт амьдрах нь эцэг эх, ахмад настнаа хүндлэн асардаг манай уламжлалт заншилтай холбоотой. Өмнөх тооллогын дүнтэй харьцуулбал ганц бие өрхийн тоо 34.9 хувиар нэмэгдсэн нь анхаарч үзэх асуудал юм.

ХҮСНЭГТ 7.2. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2020 ОН

Байршил	Өрхийн тоо бүгд	Ганц бие өрх		Ам бүлээрээ өрх		Нийлмэл ам бүлтэй өрх		Холимог ам бүлтэй өрх	
		Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь	Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь	Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь	Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>29 004</b>	<b>3 885</b>	<b>13.4</b>	<b>17 403</b>	<b>60.0</b>	<b>7 327</b>	<b>25.3</b>	<b>389</b>	<b>1.3</b>
Хот	9 858	1 196	12.1	5 571	56.5	2 898	29.4	193	2.0
Хөдөө	19 146	2 689	14.0	11 832	61.9	4 429	23.1	196	1.0

Өрхийн бүтцийг хот хөдөөгөөр авч үзэхэд ам бүлээрээ амьдарч байгаа өрх болон нийлмэл өрх дийлэнх хувийг эзэлж байна. Хот, хөдөөд ганц бие өрхийн тоо өмнөх тооллогын дүнгээс 34.9 хувиар өсөж, нийлмэл ам бүлтэй өрхийн эзлэх хувь 6.4-7.4 пунктээр буурчээ. Ганц бие өрхийн тоо өссөнийг шилжих хөдөлгөөнтэй холбон тайлбарлаж болно.

ХҮСНЭГТ 7.3. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2020 ОН

Байршил	Бүгд		Үүнээс: ам бүлийн тоогоор											
	Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь	1-2			3-4			5-6			7+		
			Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь	Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь	Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь	Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь	Өрхийн тоо	Бүгдэд эзлэх хувь		
<b>БҮГД</b>	<b>29 004</b>	<b>100.0</b>	<b>8 606</b>	<b>29.7</b>	<b>10 869</b>	<b>37.5</b>	<b>7 392</b>	<b>25.5</b>	<b>2 137</b>	<b>7.3</b>				
Хот	9 858	100.0	2 761	28.0	3 751	38.1	2 508	25.4	838	8.5				
Хөдөө	19 146	100.0	5 845	30.5	7 118	37.2	4 884	25.5	1 299	6.8				

Аймгийн хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 2010 онд 3.5 байсан бол 2020 онд 3.7 болж өсөв. Өрхийн ам бүлийн бүтэц, өмнөх тооллогоос ялгаатай байгаа бөгөөд хотод 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь 0.5 пунктээр буурч, хөдөөд 2.4 пунктээр өссөн байна. Харин 3-4 ам бүлтэй өрхийн эзлэх хувь нь 11.3 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 7.4. ӨРХИЙН ТОО, СУМ, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2020 ОН

Сумын нэр	Бүгд	Ам бүлийн тоогоор				Өрхийн ам бүлийн дундаж тоо
		1-2	3-4	5-6	7+	
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>29.7</b>	<b>37.5</b>	<b>25.5</b>	<b>7.3</b>	<b>3.7</b>
Сүхбаатар	100.0	26.0	39.0	25.5	9.5	3.8
Алтанбулаг	100.0	28.8	34.8	27.3	9.1	3.8
Баруунбүрэн	100.0	31.8	35.5	24.8	7.9	3.7
Баянгол	100.0	35.4	37.1	22.6	4.9	3.5
Ерөө	100.0	28.9	37.6	27.4	6.1	3.7
Жавхлант	100.0	37.0	34.2	23.3	5.5	3.5
Зүүнбүрэн	100.0	32.5	36.5	25.0	6.0	3.5
Мандал	100.0	26.7	39.0	26.3	8.0	3.9
Орхон	100.0	40.1	31.2	24.8	3.9	3.3
Орхонтуул	100.0	32.5	36.3	25.1	6.1	3.6
Сайхан	100.0	33.4	37.3	23.4	5.9	3.4
Сант	100.0	40.8	36.1	18.3	4.8	3.3
Түшиг	100.0	36.2	34.7	23.9	5.2	3.4
Хүдэр	100.0	24.5	34.4	32.0	9.1	4.0
Хушаат	100.0	30.5	35.8	29.2	4.5	3.7
Цагааннуур	100.0	27.4	38.0	26.7	7.9	3.8
Шаамар	100.0	32.0	36.4	25.1	6.5	3.5

Аймгийн хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо улсын түвшнээс 0.1 пунктээр их, аймаг дотроо сумдаар авч үзвэл Хүдэр суманд хамгийн өндөр байгаа нь улсын дунджаас 0.4 пунктээр илүү байна.

Өрхийн тэргүүлэгчийг хүйс, байршлаар ангилахад 4 өрх тутмын нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй, тэдгээрийн 40.0 орчим хувь нь хотод, бусад нь хөдөөд амьдарч байна.

ХҮСНЭГТ 7.5. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Өрхийн тэргүүлэгч	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>29 004</b>	<b>100.0</b>	<b>9 858</b>	<b>100.0</b>	<b>19 146</b>	<b>100.0</b>
Эрэгтэй тэргүүлэгчтэй	21 681	74.8	7 106	72.1	14 575	76.1
Эмэгтэй тэргүүлэгчтэй	7 323	25.2	2 752	27.9	4 571	23.9

Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс 5.2 пункт, байршлын хувьд хотод 6.0 пункт, хөдөөд 5.8 пунктээр тус тус нэмэгджээ. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо нэмэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

### ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн амын гэр бүл болох үндсэн чиг хандлага тооллого хоорондын жилүүдэд эрс өөрчлөгдөөгүй боловч нарийвчлан авч үзвэл ялгаа бий болсон нь ажиглагдана. Тухайлбал, огт гэр бүл болоогүй хүмүүсийн эзлэх хувь 2010 онд 25.8 хувь байсан бол 2020 онд 31.5 болж, 5.7 пунктээр өсжээ.

ХҮСНЭГТ 7.6. АРВАН ТАВ ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Гэр бүлийн байдал	2010		2020	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>67 803</b>	<b>100.0</b>	<b>74 792</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл болоогүй	17 485	25.8	23 552	31.5
Гэр бүлтэй <sup>1</sup>	44 316	65.3	44 936	60.1
Цуцалсан <sup>2</sup>	2 160	3.2	2 179	2.9
Бэлэвсэн	3 842	5.7	4 125	5.5

1-батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан  
 2-тусгаарласан хүмүүсийг оруулсан

Сүүлчийн 20 жилд гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүмүүсийн эзлэх хувь ойролцоо байхад бэлэвсэн хүмүүсийн эзлэх хувь буурчээ.

Ерөнхийдөө огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс олон байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа нөхөрт гардгийг харуулна. Эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж насыг эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад бага байдаг. Огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өмнөх тооллогын үеийнхээс 5.4 пунктээр өсжээ. Харин бэлэвсэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 4.6 дахин их байгаа нь эрэгтэйчүүдийн нас баралт их байдагтай холбоотой.

**ХҮСНЭГТ 7.7. АРВАН ТАВ ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН**

Гэр бүлийн байдал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>БҮГД</b>	<b>74 792</b>	<b>100.0</b>	<b>37 829</b>	<b>100.0</b>	<b>36 963</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл болоогүй	23 552	31.5	13 701	36.2	9 851	26.7
Гэр бүлтэй <sup>1</sup>	44 936	60.1	22 369	59.1	22 567	61.1
Тусгаарласан	1 133	1.5	561	1.5	572	1.5
Цуцалсан <sup>2</sup>	1 046	1.4	458	1.2	588	1.6
Бэлэвсэн	4 125	5.5	740	2.0	3 385	9.1

1-батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан  
 2-тусгаарласан хүмүүсийг оруулсан

Нийгэм, эдийн засаг хөгжиж, залуу үеийнхний боловсролын түвшин дээшлэх тутам анхны гэрлэлтийн дундаж нас хойшилж байдаг зүй тогтолтой. Орчин үеийн хүний нийгмийн амьдралын баталгаа болсон чанартай боловсрол эзэмшихэд ихээхэн цаг хугацаа шаардагдаж, энэ хирээр боловсролын өртөг нэмэгдсээр байна.

**ЗУРАГ 7.3. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС, 2000, 2010, 2020 ОН**



Анхны гэрлэлтийн дундаж нас 27.8 болсон бөгөөд 2010 онтой харьцуулахад 0.7 насаар хойшилсон байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа ойролцоогоор нэг насны зөрүүтэй байгаа нь сүүлийн 10 жилд гэрлэлт оройтож байгааг харуулж байна.

Хүн амын гэр бүлийн байдлыг насны бүлэг болон хүйсээр авч үзэхэд илүү тодорхой үзэгдлүүд харагдана. Тухайлбал, огт гэрлээгүй эрэгтэй, нөхөрт гараагүй эмэгтэйчүүдийн хувь насны бүлгээр онцын ялгаагүй байхад (Хүснэгт 7.8) гэр бүлтэй эмэгтэйчүүд 15-34 насанд илүү, түүнээс хойших насанд эрэгтэйчүүд нь олон байна. Энэ нь эмэгтэйчүүд илүү эрт нөхөрт гардгийг дахин харуулж байна. Эмэгтэйчүүд илүү эрт нөхөрт гардагтай холбоотойгоор тухайн насанд гэр бүл цуцлалт ч бас өндөр байгаа юм.


**ХҮСНЭГТ 7.8. АРВАН ТАВ ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР 2020 ОН**

Насны бүлэг	Эрэгтэй					Эмэгтэй				
	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй	Цуцалсан	Бэлэвсэн	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй	Цуцалсан	Бэлэвсэн
<b>2010 он</b>										
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
15-24	26.2	70.2	7.0	3.3	0.0	22.7	76.2	10.1	5.8	0.5
25-34	24.9	20.6	27.9	21.1	2.7	23.8	14.6	29.4	25.2	2.5
35-44	21.2	6.1	28.1	37.6	8.6	22.4	5.7	28.6	36.0	10.5
45-54	16.3	2.1	22.4	26.1	22.8	17.5	2.5	20.9	25.8	24.4
55-64	7.0	0.7	9.6	8.1	20.3	7.7	0.6	7.5	5.4	25.2
65+	4.4	0.3	5.0	3.8	45.6	5.9	0.4	3.5	1.8	36.9
<b>2020 он</b>										
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
15-24	21.7	56.8	1.8	0.0	0.0	20.8	68.8	4.0	0.3	0.0
25-34	23.9	29.7	21.7	9.0	1.1	20.9	21.5	24.1	12.2	1.1
35-44	20.7	8.3	28.6	27.3	6.9	19.3	4.8	27.4	27.9	4.6
45-54	17.1	3.9	24.2	39.3	17.6	18.4	3.2	24.5	33.2	17.0
55-64	11.4	1.0	16.7	20.1	28.9	13.2	1.3	15.3	22.1	31.5
65+	5.2	0.3	7.0	4.4	45.5	7.4	0.4	4.8	4.3	45.8

Нөгөө талаар 15-34 насанд нөхөрт гарсан эмэгтэйчүүд, 35-аас дээш насанд гэрлэсэн эрэгтэйчүүд олон байхад аль ч насанд бэлэвсэн эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс мэдэгдэхүйц их байна (Хүснэгт 7.8). Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү урт насалдагтай холбоотойгоор тэд эрэгтэйчүүдээс эрт бэлэвсэрч байгааг илтгэнэ. Ялангуяа, 65 ба түүнээс дээш насанд бэлэвсэн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс 4.6 дахин их байна.

Гэр бүлээ цуцалсан хүний тоог хүйсээр ангилж үзэхэд 25-54 насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү, ялангуяа, 25-34 насанд хамгийн их зөрүүтэй (4.1 пункт), харин 35-аас дээш насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү байна.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ



**НЭГДСЭН ДҮН****ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ**

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын асуулгын хуудсанд хөгжлийн бэрхшээлийн талаар асуулга оруулж, судалсан болно.

Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд орох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэнэ.


Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 4416 хүн тоологдож аймгийн хүн амын 4.1 хувийг эзэлж байгаа нь (улсын хэмжээнд 3.3 хувь) улсын дунджаас 0.8 пунктээр бага байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 55.6 хувь нь эрэгтэйчүүд, 44.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

**ХҮСНЭГТ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН**

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>4 416</b>	<b>100.0</b>	<b>2 457</b>	<b>100.0</b>	<b>1 959</b>	<b>100.0</b>
0-4	41	0.9	22	0.9	19	1.0
5-9	87	2.0	47	1.9	40	2.0
10-14	105	2.4	65	2.6	40	2.0
15-19	139	3.1	71	2.9	68	3.5
20-24	211	4.9	124	5.0	87	4.4
25-29	262	5.9	160	6.5	102	5.2
30-34	333	7.5	192	7.8	141	7.2
35-39	417	9.4	237	9.6	180	9.2
40-44	455	10.3	257	10.5	198	10.1
45-49	585	13.2	308	12.5	277	14.1
50-54	718	16.3	340	13.8	378	19.4
55-59	618	14.0	349	14.2	269	13.8
60-64	268	6.1	189	7.7	79	4.0
65-69	83	1.9	55	2.2	28	1.4
70+	94	2.1	41	1.8	53	2.7

Насны бүлгээр авч үзвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2.9 хувь нь бага насны хүүхдүүд буюу 0-9 насныхан, 23.8 хувь нь өсвөр үе, залуучууд буюу 10-34 насныхан, 49.3 хувь нь 35-54 насныхан, үлдсэн 24.0 хувь нь 55, түүнээс дээш насны хүн ам байна. Насны бүлгээр харьцуулбал 20-иос дээш насанд хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүд их байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь 35-54 насанд хамгийн их байгаа нь тэдний дийлэнх нь үйлдвэрлэл болон ахуйн ослоос хамаарч хөгжлийн олдмол бэрхшээлтэй болсон байх талтай.

ЗУРАГ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ТООГООР, 2020 ОН



Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 26.6 хувь нь Сүхбаатар хотод, 20.6 хувь нь Мандал суманд ногдож байна. Үүний дараа Алтанбулаг, Ерөө, Сайхан, Цагааннуур сум оржээ. Бүх сумдад хүйсийн харьцаа өндөр, өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс 1.1-2.0 дахин өндөр, тухайлбал Сант суманд 2 дахин, Жавхлант, Түшиг сумдад 1.5 дахин их байна.

ХҮСНЭГТ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, СУМ, ХҮЙС, ХУВИАР 2020 ОН

Сумын нэр	Эрэгтэй		Эмэгтэй		Хүйсийн харьцаа
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	
<b>БҮГД</b>	<b>4 416</b>	<b>100.0</b>	<b>2 457</b>	<b>100.0</b>	<b>125.4</b>
Сүхбаатар	1 173	26.6	640	26.0	120.1
Алтанбулаг	306	6.9	173	7.0	130.1
Баруунбүрэн	98	2.2	54	2.2	122.7
Баянгол	177	4.0	93	3.8	110.7
Ерөө	290	6.6	167	6.8	135.8
Жавхлант	74	1.7	45	1.8	155.2
Зүүнбүрэн	182	4.1	98	4.0	116.7
Мандал	908	20.6	494	20.1	119.3
Орхон	89	2.0	49	2.0	122.5
Орхонтуул	117	2.6	69	2.8	143.8
Сайхан	263	6.0	146	5.9	124.7
Сант	92	2.1	61	2.5	196.8
Түшиг	86	1.9	52	2.1	152.9
Хүдэр	89	2.0	49	2.0	122.5
Хушаат	55	1.2	28	1.1	103.7
Цагааннуур	257	5.8	148	6.0	135.8
Шаамар	160	3.6	91	3.7	131.9

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР**

Аймгийн хэмжээнд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 3 хүн тутмын нэг нь төрөлхийн, хоёр нь олдмол бэрхшээлтэй байна. Энэ байдал хүйсийн хувьд ч ижил хандлагатай байгаа нь үйлдвэрлэлийн болон осол, хоол хүнсний зохисгүй хэрэглээ, амьдралын буруу зуршил зэргээс хамаарч хөгжлийн бэрхшээлтэй болдогийг нотолж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 22.8 хувь нь сэтгэцийн, 22.2 хувь нь хөдөлгөөний, 33.0 хувь нь бусад хэлбэрийн, үлдсэн хувь нь харааны, ярианы сонсголын хөгжлийн бэрхшээлтэй байна.


**ХҮСНЭГТ 8.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ТӨРӨЛ, ХЭЛБЭРЭЭР, ХУВИАР 2020 ОН**

Төрөл	Бүгд		Хөгжлийн бэрхшээлтэй төрөл			
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Төрөлхийн	Дүнд эзлэх хувь	Олдмол	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>4 416</b>	<b>100.0</b>	<b>2 039</b>	<b>100.0</b>	<b>2 377</b>	<b>100.0</b>
Хүйс						
Эрэгтэй	2 457	55.6	1 113	54.6	1 344	56.5
Эмэгтэй	1 959	44.4	926	45.4	1 033	43.5
Хөгжлийн бэрхшээлтэй хэлбэр						
Харааны	512	11.6	298	14.6	214	9.0
Ярианы	179	4.1	153	7.5	26	1.1
Сонсголын	279	6.3	172	8.4	107	4.5
Хөдөлгөөний	979	22.2	399	19.6	580	24.4
Сэтгэцийн	1 007	22.8	724	35.5	283	11.9
Бусад*	1 460	33.0	293	14.4	1 167	49.1


\*Хавсарсан болон бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийг энд оруулав

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дотор хөдөлгөөний, харааны болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь, харин олдмол бэрхшээлтэй иргэдийн дотор бусад хэлбэрийн бэрхшээл, хөдөлгөөний, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь их байгаа нь дээрх дүгнэлтийг давхар нотолно. Дараагийн анхаарал татаж байгаа асуудал нь бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүн амын хувь олдмол бэрхшээлтэй хүнийхээс 2.2 дахин их байгаа явдал юм.

**ЗУРАГ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМ, ТӨРӨЛ, ХЭЛБЭРЭЭР, ХУВИАР, 2020 ОН**



## ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИД



### ГАР УТАС, ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧДИЙН ТОО, БҮТЭЦ

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн энэ цаг үед гар утас, интернэт нь хүн амын өдөр тутмын өргөн хэрэглээ болоод байна.


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолмол аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн 6, түүнээс дээш насны хүн амаас гар утас, интернэт хэрэглээний талаарх мэдээллийг авсан. Тиймээс 2020 оны тооллогын гар утас, интернэт хэрэглээний талаарх тоо мэдээллийг 2010 оны тооллогын дүнтэй хувийн жингээр харьцуулан танилцуулж байна.

### ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ

Сэлэнгэ аймгийн 6, түүнээс дээш насны хүн амын 87.5 хувь нь гар утас хэрэглэдэг болж өмнөх тооллогоос 13.9 пунктээр өсжээ.


Манай аймаг 6, түүнээс дээш настай хүн амд гар утас хэрэглэгчдийн эзлэх хувиар Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Өмнөговь аймгуудын дараа орж байна (Зураг 9.1).

ЗУРАГ 9.1. ЗУРГАА БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ СУУРИН ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010, 2020 ОН



Хөдөлмөрийн нас болох 15-59 насны хүн амын 83.5 хувь нь гар утас хэрэглэж байгаагаас 20-29 насныхан хамгийн их ажээ.

ЗУРАГ 9.2. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СУМААР 2020 ОН




Сумдаар авч үзвэл зургаа, түүнээс дээш насны хүн амд эзлэх гар утас хэрэглэгчийн хувийн жин Хүдэр суманд хамгийн өндөр 92.6 хувь, түүний дараа Алтанбулаг, Сант, Сүхбаатар сум орж байгаа бөгөөд аймгийн дунджаас 1.9-5.1 пунктээр илүү байна.

### ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ

Суурин эсвэл хөдөлгөөнт сүлжээгээр интернэтэд холбогдохыг интернэт ашигласан гэж тодорхойлон интернэт хэрэглэгчдийг байнга болон шаардлагатай үед хэрэглэдэг гэж 2 хувааж үзсэн. 6, түүнээс дээш настай хүн амын 62.8 хувь нь интернэт хэрэглэдэг болж өмнөх тооллогоос 45.1 пунктээр өсжээ. Интернэт хэрэглэдэг хүн амын 46.8 хувь нь эрэгтэйчүүд, 53.2 хувь нь эмэгтэйчүүд байна.


Сэлэнгэ аймгийн 6, түүнээс дээш настай хүн амын интернэт хэрэглээг улсын дундажтай харьцуулахад 1.9 пунктээр доогуур гарчээ.

ЗУРАГ 9.3. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН




Интернэт хэрэглэгчдийг байршлаар нь авч үзэхэд хотод амьдарч буй хүн амын 63.7 хувь нь, хөдөөд амьдарч буй хүн амын 62.4 хувь нь интернэт хэрэглэдэг болжээ. Аймгийн дундажтай харьцуулбал хөдөөгийн хүн амын интернэтийн хэрэглээ 0.1 пунктээр бага байгаа бол хотын хүн амын интернэтийн хэрэглээ 0.9 пунктээр их байна.

ЗУРАГ 9.4. ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН СУВРАГА, ТООГООР, 2010, 2020 ОН



ЗУРАГ 9.5. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СУМААР, 2020 ОН



Интернэтийн хэрэглээг сумдаар авч үзэхэд аймгийн дунджаас Сайхан, Хүдэр, Сүхбаатар, Баянгол суманд 1.5-14.1 пунктээр илүү байгаа нь хүн ам их төвлөрсөн, аж үйлдвэр (цемент үйлдвэр, спиртийн үйлдвэр гэх мэт) харьцангуй хөгжсөн газар интернэтийн шугам, сүлжээ их тавигдсаныг харуулж байна. Харин хувийн жингээр хамгийн бага нь Хушаат, Орхонтуул, Баруунбүрэн сум оржээ.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



Хүн ам, орон сууцны тооллогоор хүн амын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг гаргах нь хэд хэдэн шалтгаантай байдаг. Хүн амын эдийн засгийн талаарх мэдээлэл нь тухайн улс орны эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн хэв маяг, зах зээлийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн цар хүрээ зэргийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Мөн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн гол үзүүлэлтүүдийг тооллогоор цуглуулан хувь хүний болон өрх, орон сууцны нөхцөлийн үзүүлэлтүүдтэй холбосноор нийгэм, эдийн засгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашдын чиг хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Хүн ам, орон сууцны тооллогын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг засаг захиргааны хамгийн бага нэгжийн түвшинд гаргах боломжтойгоороо бусад төрлийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаануудаас давуу талтай.

Хүн амын асуулгын эдийн засгийн үзүүлэлтүүдийн ойлголт тодорхойлолтыг боловсруулахдаа НҮБ-ын “Хүн ам, орон сууцны 2020 он орчмын тооллогод баримтлах зарчим, зөвлөмж- III”-ийг үндэслэсэн.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолсон аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн 15, түүнээс дээш насны хүн амаас хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуултуудыг асуусан.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын уламжлалт асуулгын эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүдийг Хөдөлмөрийн статистикчдын олон улсын 19-р бага хурлаар шинэчлэн баталсан аргачлалын дагуу тооцсон.

Уламжлалт тооллогын асуулгаар “Тооллогын товын үед ажил эрхэлж байгаа эсэх, товоос өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалин хөлстэй ажил эрхэлсэн болон тухайн хугацаанд ажил эрхлээгүй боловч ер нь ажилтай хүнийг “Ажил эрхэлдэг” гэж үзсэн. Харин бүртгэлд суурилсан мэдээлэл боловсруулалтад Хүн ам, өрхийн мэдээллийн санг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан болон Гадаадын иргэн харьяатын газрын мэдээллийн сантай уялдуулан хөдөлмөр эрхэлдэг хүнийг гаргасан.

ЗУРАГ 10.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН



## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

15, түүнээс дээш буюу хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

Ажиллах хүчинд ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүй иргэдийг хамрууллаа. Энэ нь цаашдаа улс орны нийгэм, эдийн засаг ялангуяа ажиллах хүчний бодлого боловсруулахад суурь мэдээлэл болдог.

Уламжлалт тооллогоор тухайн үед ажиллаж байгаа гэдэг ойлголтод байнгын болон улирлын чанартай ажилтай, тооллогын үед ажил эрхлэхгүй байгаа ч ер нь ажил эрхэлдэг хүн амыг болон бүртгэлд суурилсан тооллогоор нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан болон гадаадын болон харьяалалгүй иргэдийн мэдээллийн санд бүртгэлтэй ажил эрхэлдэг бүх хүн амыг ажил эрхэлдэг гэж үзсэн.

Харин эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлээгүй хүмүүсээс гадна тохирох ажил олдохгүй байгаагийн улмаас хөдөлмөр эрхлээгүй хүнийг оруулсан болно.

**ЗУРАГ 10.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН**



Хөдөлмөрийн насны буюу арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 53.9 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 3.8 пунктээр буурсан бол ажиллах хүчнээс гадуурх хүн ам (46.1%) 3.8 пунктээр өсжээ.

Ерөнхийд нь үзвэл ажиллах хүчний оролцооны түвшин өнгөрсөн тооллогын үеийнхээс буурсан, ялангуяа эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо өмнөх тооллогын үеийнхээс 4.1 пунктээр буурсан байна.


Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, эмэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байна. Байршлын хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд хотынхоос өндөр байна. Ялангуяа, хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 61.1 хувь байгаа нь хотынхоос 2.5 пунктээр илүү байна.

**ХҮСНЭГТ 10.1. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН**

Эдийн засгийн идэвх	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллах хүч	53.9	60.2	47.5	52.9	58.6	47.4	54.4	61.1	47.5
Ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь	46.1	39.8	52.5	47.1	41.4	52.6	45.6	38.9	52.5


Тус аймгийн ажиллах хүчний оролцооны түвшинг Төвийн бүсийн аймгуудтай харьцуулахад Говьсүмбэр аймгаас 6.4 пунктээр, Дундговь аймгаас 0.2 пунктээр бага, Төвийн бүсийн аймгуудаас бага байна.

ЗУРАГ 10.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, СУМДААР, 2020 ОН



Ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх тооллогын үеийнхээс буурсан нь 35, түүнээс дээших насны бүх бүлэгт ажиллах хүчний оролцооны түвшин, ялангуяа эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо буурсантай холбоотой юм.

ЗУРАГ 10.4. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Ажиллах хүчийг насны бүлгээр ангилахад мэдэгдэхүйц ялгаа ажиглагдана. Эрэгтэйчүүдийн эдийн засгийн идэвх бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Үүний дотор 20-34 насанд эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс 11.3-17.0 пунктээр их байгаа нь тухайн насны их, дээд сургуульд суралцагч эмэгтэйчүүд илүү байдагтай холбоотой байж болох юм.

ХҮСНЭГТ 10.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ХӨДӨЛМӨР  
 ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Ажиллах хүч						Ажиллах хүчнээс гадуурх хүн ам					
	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	Хувь*	Хүний тоо	Хувь*	Хүний тоо	Хувь*	Хүний тоо	Хувь*	Хүний тоо	Хувь*	Хүний тоо	Хувь*
<b>БҮГД</b>	<b>40 425</b>	<b>100.0</b>	<b>22 859</b>	<b>100.0</b>	<b>17 566</b>	<b>100.0</b>	<b>34 546</b>	<b>100.0</b>	<b>15 095</b>	<b>100.0</b>	<b>19 451</b>	<b>100.0</b>
15-19	538	1.3	398	1.7	140	0.8	7 377	21.4	3 626	24.0	3 751	19.3
20-24	3 275	8.1	2 056	9.0	1 219	6.9	4 719	13.7	2 133	14.1	2 586	13.3
25-34	12 069	29.9	7 012	30.6	5 057	28.8	4 753	13.8	2 062	13.7	2 691	13.8
35-44	11 171	27.6	6 162	27.0	5 045	28.7	3 816	11.0	1 734	11.5	2 082	10.7
45-54	9 400	23.3	4 716	20.6	4 684	26.7	3 922	11.3	1 785	11.8	2 137	11.0
55-59	2 661	6.6	1 676	7.3	985	5.6	2 846	8.2	961	6.4	1 885	9.7
60+	1 311	3.2	875	3.8	436	2.5	7 113	20.6	2 794	18.5	4 319	22.2


### АЖИЛЛАХ ХҮЧ

Тооллогын өмнөх 7 хоногт ядаж нэг цагаас илүү хугацаагаар цалин орлоготой ажил эрхэлсэн, ажил хайж байгаа хүнийг ажиллах хүчинд хамааруулсныг дээр тэмдэглэсэн. Бид ажил эрхлэлтийг богино хугацаагаар тодорхойлж байгаа болохоор НҮБ-ын зөвлөмжийг үндэслэн ажиллах хүч гэдэг ойлголтыг хэрэглэж байна.

Тооллогоор тухайн тоолуулагч аж ахуйн нэгж, байгууллагаасаа хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй бол хөдөлмөр эрхэлсэн гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, тухайн тоолуулагч тооллогын өмнөх долоо хоногт ажил эрхлээгүй байвал түүний ажил эрхлэлтийг үнэн зөв тодорхойлохын тулд ер нь ажилтай эсэхийг тодруулан асууж хөдөлмөр эрхлэлтийн шинэчилсэн аргачлалын дагуу тодорхойлсон.

Ажилгүй хүн гэдгийг тодорхойлоход хүн амын тооллогын асуулгын хөдөлмөр эрхлэхгүй байгаа үндсэн шалтгаан, мөн сүүлийн 30 хоногт цалин хөлстэй ажил хайх (бизнес эрхлэх) ямар нэгэн оролдлого хийсэн эсэхийг тодруулсан. Ажил хайж байгаа гэдэгт тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй бөгөөд хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэс бүртгэлтэй болон бүртгэлгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүнийг хамааруулж, ажилгүйчүүдийг тодорхойлов.

ЗУРАГ 10.5. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2020 ОН



Арван тав, түүнээс дээш насны хүн амд ажилгүй иргэдийн эзлэх хувь 2.8 болж, өнгөрсөн 10 жилийн хугацаанд 8.3 пунктээр буурчээ. Улсын дундажтай харьцуулахад ажилгүйчүүдийн хувь 3.1 пунктээр, хөдөлмөр эрхэлдэг хүн амынх 2.7 пунктээр бага, харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь 5.8 пунктээр их байна. Ажилгүйдлийн түвшин хэрхэн өөрчлөгдсөнийг дараагийн дэд бүлэгт оруулав.

### ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМ

Хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн эрхэлдэг ажил болон ажилладаг аж ахуй, нэгж байгууллагынх нь үндсэн үйл ажиллагааны чиглэл, ажил эрхлэлтийн байдал гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон.

ХҮСНЭГТ 10.3. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Хүйс	2010		2020		2020/2010%
	Хүний тоо	Хувь*	Хүний тоо	Хувь*	
<b>БҮГД</b>	<b>31 560</b>	<b>46.5</b>	<b>38 341</b>	<b>51.1</b>	<b>121.5</b>
Эрэгтэй	17 487	50.7	21 616	57.0	123.6
Эмэгтэй	14 073	42.3	16 725	45.2	118.8

\*15, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувь

Хөдөлмөр эрхэлдэг хүн амын тоо 2010 оноос хойш 21.5 хувиар өсжээ. Хүйсээр нь авч үзвэл эрэгтэйчүүдийн хувьд илүү өсөлттэй байна. Харин байршлаар нь ангилахад нэлээд ялгаатай байгааг дараах хүснэгтээс харж болно.

**НЭГДСЭН ДҮН****ХҮСНЭГТ 10.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН**

Хүйс	Бүгд		Хот		Хөдөө	
	Хүний тоо	Хувь*	Хүний тоо	Хувь*	Хүний тоо	Хувь*
2010 он						
<b>БҮГД</b>	<b>31 560</b>	<b>46.5</b>	<b>14 759</b>	<b>43.6</b>	<b>16 801</b>	<b>49.5</b>
Эрэгтэй	17 487	50.7	7 841	46.9	9 646	54.2
Эмэгтэй	14 073	42.3	6 918	40.3	7 155	44.4
2020 он						
<b>БҮГД</b>	<b>38 341</b>	<b>51.1</b>	<b>12 997</b>	<b>50.2</b>	<b>25 344</b>	<b>51.7</b>
Эрэгтэй	21 616	57.0	7 110	55.4	14 506	57.8
Эмэгтэй	16 725	45.2	5 887	45.0	10 838	45.3

\*15, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувь

Аймгийн хэмжээнд арван тав, түүнээс дээш насны хүн амын 51.1 хувь нь ажил эрхэлж байхад уг үзүүлэлт хөдөөд 51.7 хувь байгаа нь хотынхоос 1.5 пунктээр илүү байна. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт хотынхоос 2.4 пунктээр их бол эрэгтэйчүүдийнх 0.3 пунктээр илүү байна. Хэдийгээр энэ зөрүү 2010 оны тооллогын үеийнхээс буурсан ч хөдөлмөр эрхлэх зорилгоор хот суурин руу нүүж, амьжиргаагаа дээшлүүлэх гэсэн олон мянган хүн ажлын байраар тэр бүр хангагдаж чадахгүй байдал байсаар байна.

**ХҮСНЭГТ 10.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН**

Насны бүлэг	2010			2020			2020/2010%
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>БҮГД</b>	<b>31 560</b>	<b>17 487</b>	<b>14 073</b>	<b>38 341</b>	<b>21 616</b>	<b>16 725</b>	<b>121.5</b>
15-19	826	636	190	518	383	135	62.7
20-24	3 608	2 296	1 312	3 155	1 986	1 169	87.4
25-34	9 743	5 466	4 277	11 319	6 566	4 753	116.2
35-44	9 358	4 686	4 672	10 561	5 758	4 803	112.9
45-54	6 556	3 385	3 171	8 954	4 463	4 491	136.6
55-59	957	685	272	2 563	1 616	947	267.8
60+	512	333	179	1 271	844	427	248.2

Дээрх хүснэгтээс харахад 15-19 насны хөдөлмөр эрхэлдэг хүний тоо 2010 оныхоос буурч, харин 35-54 насны хүний тоо өссөн нь аж ахуйн нэгж, байгууллагууд ажлын чадвар дадлага туршлагатай, ажлын бүтээмж өндөртэй ажилтныг ажиллуулах сонирхол нэмэгдэж байгаагийн зэрэгцээгээр өнгөрсөн жилүүдэд ажиллаж байсан 34-44 насныхан нас дэвшсэнтэй холбоотой. Нөгөө талаар залуучуудын сургуульд хамрагдалт өмнөх тооллогын үеэс нэмэгдсэн нь энэхүү бууралтад нөлөөлжээ.

**НЭГДСЭН ДҮН**

ХҮСНЭГТ 10.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Ажил, мэргэжил	Хүний тоо			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>38 341</b>	<b>21 616</b>	<b>16 725</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Менежер	2 467	1 209	1 258	6.4	5.6	7.5
Мэргэжилтэн	5 708	1 806	3 902	14.9	8.4	23.3
Техникч болон туслах /дэд мэргэжилтэн/	1 659	842	817	4.3	3.9	4.9
Контор, үйлчилгээний ажилтан	1 360	427	933	3.5	2.0	5.6
Худалдаа үйлчилгээний ажилтан	4 704	1 701	3 003	12.3	7.9	18.0
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	9 370	5 833	3 537	24.4	27.0	21.1
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	3 272	2 516	756	8.5	11.6	4.5
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	5 017	4 420	597	13.1	20.4	3.6
Энгийн ажил мэргэжил	4 179	2 333	1 846	10.9	10.8	11.0
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	605	529	76	1.6	2.4	0.5

ХҮСНЭГТ 10.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Ажил, мэргэжил	Хүний тоо			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>38 341</b>	<b>21 616</b>	<b>16 725</b>	<b>100.0</b>	<b>56.4</b>	<b>43.6</b>
Менежер	2 467	1 209	1 258	100.0	49.0	51.0
Мэргэжилтэн	5 708	1 806	3 902	100.0	31.6	68.4
Техникч болон туслах /дэд мэргэжилтэн/	1 659	842	817	100.0	50.8	49.2
Контор, үйлчилгээний ажилтан	1 360	427	933	100.0	31.4	68.6
Худалдаа үйлчилгээний ажилтан	4 704	1 701	3 003	100.0	36.2	63.8
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	9 370	5 833	3 537	100.0	62.3	37.7
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	3 272	2 516	756	100.0	76.9	23.1
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	5 017	4 420	597	100.0	88.1	11.9
Энгийн ажил мэргэжил	4 179	2 333	1 846	100.0	55.8	44.2
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	605	529	76	100.0	87.4	12.6

Хүн амын эрхэлдэг ажил мэргэжлийн онцлогоос хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаа ангилал тус бүрд өөр өөр байгаа нь ажиглагдана. Эрхэлдэг ажил мэргэжил хүйсийн хувьд хамгийн бага зөрүүтэй байгаа нь менежер, техникч болон туслах /дэд мэргэжилтэн/ байна. Харин суурин төхөөрөг, машин

**НЭГДСЭН ДҮН**

механизмын операторч, угсрагч, зэвсэгт хүчний алба болон биеийн хүч шаардсан ажил мэргэжлийн 87.4-өөс дээш хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна.

Харин контор, үйлчилгээний ажилтан, мэргэжилтэн, худалдаа үйлчилгээний ажилтай 10 хүн тутмын 6-г нь эмэгтэйчүүд эзлэх боллоо. Хөдөлмөр эрхэлдэг хүн амын 99.2 хувь нь боловсролтой, үүнээс эрэгтэйчүүдийн 99.1, эмэгтэйчүүдийн 99.4 хувь нь тус тус ямар нэг түвшний боловсрол эзэмшжээ.

**ХҮСНЭГТ 10.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН**

Ажил мэргэжил	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	Хүний тоо			Хувь - А		
<b>БҮГД</b>	<b>38 341</b>	<b>21 616</b>	<b>16 725</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Хөдөө аж ахуй, ой, загас агнуур	10 538	6 745	3 793	27.5	31.2	22.7
Уул уурхай, олборлолт	1 811	1 576	235	4.7	7.3	1.4
Боловсруулах үйлдвэрлэл	4 338	2 648	1 690	11.3	12.3	10.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	423	317	106	1.1	1.5	0.6
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	374	223	151	1.0	1.0	0.9
Барилга	1 614	1 333	281	4.2	6.2	1.7
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	3 537	1 702	1 835	9.2	7.9	11.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2 476	1 890	586	6.5	8.7	3.5
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	745	195	550	1.9	0.9	3.3
Мэдээлэл, холбоо	330	162	168	0.9	0.7	1.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	758	238	520	2.0	1.1	3.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	38	25	13	0.1	0.1	0.1
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	557	312	245	1.5	1.4	1.5
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	591	419	172	1.5	1.9	1.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2 899	1 784	1 115	7.6	8.3	6.7
Боловсрол	3 950	885	3 065	10.3	4.1	18.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1 394	202	1 192	3.6	0.9	7.1
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	341	157	184	0.9	0.7	1.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1 575	781	794	4.1	3.6	4.7
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	30	15	15	0.1	0.1	0.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	22	7	15	0.1	0.0	0.1

**НЭГДСЭН ДҮН**

ХҮСНЭГТ 10.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Ажил мэргэжил	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	Хүний тоо				Хувь - Б	
<b>БҮГД</b>	<b>38 341</b>	<b>21 616</b>	<b>16 725</b>	<b>100.0</b>	<b>56.4</b>	<b>43.6</b>
Хөдөө аж ахуй, ой, загас агнуур	10 538	6 745	3 793	100.0	64.0	36.0
Уул уурхай, олборлолт	1 811	1 576	235	100.0	87.0	13.0
Боловсруулах үйлдвэрлэл	4 338	2 648	1 690	100.0	61.0	39.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	423	317	106	100.0	74.9	25.1
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	374	223	151	100.0	59.6	40.4
Барилга	1 614	1 333	281	100.0	82.6	17.4
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	3 537	1 702	1 835	100.0	48.1	51.9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2 476	1 890	586	100.0	76.3	23.7
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	745	195	550	100.0	26.2	73.8
Мэдээлэл, холбоо	330	162	168	100.0	49.1	50.9
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	758	238	520	100.0	31.4	68.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	38	25	13	100.0	65.8	34.2
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	557	312	245	100.0	56.0	44.0
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	591	419	172	100.0	70.9	29.1
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2 899	1 784	1 115	100.0	61.5	38.5
Боловсрол	3 950	885	3 065	100.0	22.4	77.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1 394	202	1 192	100.0	14.5	85.5
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	341	157	184	100.0	46.0	54.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1 575	781	794	100.0	49.6	50.4
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	30	15	15	100.0	50.0	50.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	22	7	15	100.0	31.8	68.2

Хөдөлмөр эрхэлж буй хүн амын 27.5 хувь нь ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас агнуурын салбарт ажиллаж байгаа нь бусад салбараас хамгийн өндөр нь

юм. Энэ нь улсын төдийгүй аймгийн онцлог бөгөөд тус аймагт газар тариалангийн салбар бусад салбараас илүү хөгжсөнтэй холбоотой.

Хөдөлмөр эрхэлдэг хүн амыг хүйсээр ангилж үзэхэд эдийн засгийн үйл ажиллагааны салбарын онцлогоос хамаарч нэлээд ялгаатай байна. Тухайлбал, уул уурхай, олборлолт, цахилгаан хий, уур агааржуулалтын хангамж, барилга, тээвэр агуулахын аж ахуйн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын 74.9, түүнээс илүү хувь нь эрэгтэйчүүд байхад байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын 73.8, түүнээс дээш хувь нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 10.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Хот		Хөдөө	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>12 997</b>	<b>100.0</b>	<b>25 344</b>	<b>100.0</b>
Хөдөө аж ахуй, ой, загас агнуур	1 973	15.2	8 565	33.8
Уул уурхай, олборлолт	544	4.2	1 267	5.0
Боловсруулах үйлдвэрлэл	1 140	8.8	3 198	12.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	235	1.8	188	0.7
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	166	1.3	208	0.8
Барилга	642	4.9	972	3.8
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 361	10.5	2 176	8.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1 215	9.3	1 261	5.0
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	246	1.9	499	2.0
Мэдээлэл, холбоо	161	1.2	169	0.7
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	326	2.5	432	1.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	17	0.1	21	0.1
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	248	1.9	309	1.2
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	233	1.8	358	1.4
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1 315	10.1	1 584	6.3
Боловсрол	1 416	10.9	2 534	10.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	632	4.9	762	3.0
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	155	1.2	186	0.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	952	7.3	623	2.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	10	0.1	20	0.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	10	0.1	12	0.0

**НЭГДСЭН ДҮН**

**ЗУРАГ 10.6. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУУЧИН БОЛОН ШИНЭ СТАТУСЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**



**НЭГДСЭН ДҮН**

ХҮСНЭГТ 10.11. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2010, 2020 ОН

	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Цалин хөлстэй ажиллагч	57.7	57.1	58.3	66.3	63.9	69.4
Ажил олгогч	1.6	1.9	1.2	0.5	0.5	0.3
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	26.8	35.7	15.9	30.5	34.2	25.7
Нөхөрлөл, хоршооллын гишүүн	0.2	0.3	0.1	0.3	0.3	0.3
Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	13.2	4.3	24.2	2.5	1.1	4.3
Бусад	0.5	0.7	0.3	0.0	0.0	0.0

Хүн амын ажил эрхлэлтийн байдал сүүлийн 10 жилийн хугацаанд багагүй өөрчлөгджээ. 2010 онд өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч, нийт ажиллагсдын 13.2 хувийг эзэлж байсан бол 2020 онд 2.5 хувь болтол буурсан байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хувийн жин 3.7 пунктээр, цалин хөлстэй ажиллагч 8.6 пунктээр тус тус нэмэгдсэн байхад ажил олгогчийн хувийн жин 1.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна

**АЖИЛГҮЙЧҮҮД**


Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 онд 2010 оныхоос 14.1 пунктээр буурсны дотор хотод 14.5 пунктээр, хөдөөд 13.8 пунктээр тус тус буурсан байна. Ажил эрхэлдэггүй эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс их байгаатай холбоотойгоор ажилгүйдлийн түвшин ч мөн адил эрэгтэйчүүдийнх өндөр гарчээ.

ХҮСНЭГТ 10.12. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

Хүйс	Бүгд		Хот		Хөдөө	
	Хүний тоо	Ажилгүйдлийн түвшин	Хүний тоо	Ажилгүйдлийн түвшин	Хүний тоо	Ажилгүйдлийн түвшин
<b>БҮГД</b>	<b>2 084</b>	<b>5.2</b>	<b>720</b>	<b>5.2</b>	<b>1 364</b>	<b>5.1</b>
Эрэгтэй	1 243	5.4	415	5.5	828	5.4
Эмэгтэй	841	4.8	305	4.9	536	4.7

Нийт ажилгүй иргэдийн дотор 25-49 насны 1.6 мянган (ажилгүй иргэдийн 77.3 хувь) хүн байгаа нь ид ажиллах насны хүмүүс ажилгүй байгаа нь ажлын байрны олдоц муу, цалин хөлсний хэмжээ доогуур байгаатай холбоотойгоор тайлбарлаж болох юм. Харин 15-24 насныхны хувьд нийт ажилгүйчүүдийн 6.7 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 10.7. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2020 ОН



Ажилгүйдлийн түвшин 15-24 насанд өндөр байгаа нь мэргэжилгүй залуучуудад ажлын байр ховор олддогтой, нөгөө талаар, тэд энэ насанд ажиллахаас суралцахыг илүүд үзэж байгаатай холбоотой. Энэ нь эмэгтэйчүүдийн хувьд бүр илүү ажиглагдана. Харин 45-54 насны хувьд ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн хувьд адил 5.1-5.6 байгаа нь 40-өөс дээш насныхныг ажилд авдаггүйтэй холбоотойгоор ажилгүйдэлд өртөж байна.

### АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ

Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй хүн амаас ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг асуусан. тухайлбал, сургуульд сурдаг хүн амд 15-аас дээш настай бүх шатны сургуульд суралцагчдыг, хөдөлмөрлөх чадваргүй хүн амд хөдөлмөрийн насны боловч хөдөлмөрлөх чадвараа байнга буюу удаан хугацаагаар бүтэн болон хэсэгчлэн алдсан бөгөөд сэргээгдэх боломжгүй хүнийг, гэрийн ажилтайд хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг, гэр бүлийн бусад хүний ажлын онцлог зэргээс хамааран ажиллаж чадахгүй байгаа хүнийг тус тус хамааруулав. тохирох ажил олдохгүй байгаа гэдэг ойлголтод “ажил хийхийг хүсэж байгаа, ажил хийхэд бэлэн, урьд нь ажил идэвхтэй хайж байгаад тохирох ажил олдохгүй итгэл алдарсны улмаас тооллогын товын өмнөх 7 хоногт ажил идэвхтэй хайгаагүй эсвэл тохирох ажил хаанаас хайхаа мэдэхгүй байгаа хүмүүсийг” оруулав.

**НЭГДСЭН ДҮН**

ХҮСНЭГТ 10.13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, 2020 ОН

Ажил эрхлээгүй шалтгаан	2010			2020			2020 2010
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>БҮГД</b>	<b>28 702</b>	<b>12 598</b>	<b>16 104</b>	<b>34 546</b>	<b>15 095</b>	<b>19 451</b>	<b>120.4</b>
Сургуульд сурдаг	7 318	3 593	3 725	11 411	5 299	6 112	155.9
Тэтгэвэрт	7 383	2 607	4 776	8 902	3 025	5 877	120.6
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	2 436	1 371	1 065	1 918	1 075	843	78.7
Гэрийн ажилтай	4 227	663	3 564	3 840	540	3 300	90.8
Ажиллах сонирхолгүй	86	64	22	162	123	39	188.4
Тохирох ажил олдохгүй байгаа	5 564	3 311	2 253	4 828	2 976	1 852	86.8
Бусад	1 688	989	699	3 485	2057	1 428	206.5

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 10 хүн тутмын 4 нь эрэгтэйчүүд, 6 нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд эдийн засгийн идэвхгүй хүн ам нийтдээ 34546 байгаа нь 2010 оныхоос 20.4 хувиар, үүний дотор сургуульд суралцагчид 55.9 хувь, бусад шалтгаан 2 дахин өсжээ. Сургуульд суралцагчдын эзлэх хувь өссөн нь зүй ёсны асуудал бол бусад гэсэн шалтгааны хувьд цаашид нарийвчлан судлах шаардлагатай.

Сургуульд суралцагчдын эзлэх хувь өссөн нь зүй ёсны асуудал бол хөдөлмөр эрхлэх чадваргүй, тохирох ажил олдохгүй байгаа гэсэн шалтгаан нэмэгдсэнийг цаашид нарийвчлан судлах шаардлагатай. Ялангуяа, хөдөлмөрийн насны хүн амд хөдөлмөр эрхлэх чадваргүй хүний тоо хамгийн их өссөн нь үйлдвэрлэлийн болон ахуйн осол гэмтэл, энгийн болон мэргэжлээс шалтгаалах өвчлөл нэмэгдсэн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хувь хүн сахиж ажиллахгүй байгаа зэрэг олон шалтгаантай байж болох юм. Тохирох ажил олдохгүй, гэрийн ажилтай гэсэн шалтгааны хувьд хүн амын эзэмшсэн мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй хэр нийцэж байгаатай холбоотой юм.

ХҮСНЭГТ 10.14. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Сур-гуульд сурдаг	Тэтгэ-вэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Ажиллах сонир-холгүй	Тохирох ажил олдох-гүй байгаа	Бу-сад
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
15-19	21.4	62.2	0.0	1.4	1.3	1.9	1.3	4.1
20-24	13.7	30.6	0.0	4.5	8.6	9.3	9.2	10.1
25-34	13.8	6.7	0.0	16.0	33.5	28.4	28.0	28.6
35-44	11.0	0.5	0.3	22.8	28.9	17.3	26.9	24.7
45-54	11.4	0.1	4.6	34.2	19.6	29.6	25.5	23.5
55-59	8.2	0.0	19.2	15.5	5.8	11.7	7.4	6.9
60+	20.6	0.0	75.9	5.5	2.2	1.9	1.7	2.1

Ажил хийх сонирхолгүй 162 хүн байгаагийн 122 хүн буюу 75.3 хувь нь ажил эрхлэх ид нас болох 25-54 насны хүмүүс байгаа нь цаашид анхааран судлах асуудлын нэг юм.

Тохирох ажил олдохгүй байгаа хүний 98.3 хувь боловсролтой, үүний дотор 9 хувь нь дээд, 3.7 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн байна. Энэ нь боловсролын хэрэгцээ, нийлүүлэлт тохирохгүй байгааг харуулна. Гэрийн ажилтай хүмүүсийн 98.8 хувь боловсролтой байгаагийн дотор 12.6 хувь нь дээд боловсролтой, 3.3 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой ажээ. Харин ажиллах сонирхолгүй бүх хүний 96.3 хувь боловсролтой, үүний дотор 6.2 хувь нь дээд, 3.1 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүмүүс байна.

Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 46.1 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн ам юм. Үүн дээр ажилгүй иргэдийг нэмбэл дээрх насны нийт хүн амын 48.8 хувь буюу 2 хүн тутмын нэг нь ажил эрхлэхгүй байна гэсэн дүгнэлт хийж болно. Үүнээс гадна тохирох ажил олдохгүй байгаа, гэрийн ажилтай, ажиллах сонирхолгүйн улмаас хөдөлмөрийн зах зээлд оролцохгүй байгаа хүмүүсийн 6.2-12.6 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байгаагийн шалтгаан нөхцөлийг гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй.

# ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД



## **ГАДААДАД 6, ТҮҮНЭЭС ДЭЭШ САРЫН ХУГАЦААГААР ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО**

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр хүн амын гадаад улс орнууд руу хийх шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн. “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэсэн Үндсэн хуулийн заалт нь иргэдийг гадаадад зорчих, сурах, ажиллах, эх орондоо дуртай цагтаа эргэн ирэх эрх зүйн үндэс болдог.

Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуульд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж, ажиллаж амьдарч, сурч байгаа иргэдийнхээ талаар бодитой тоо мэдээллийг тодорхойлох асуудлыг хуульчилсан байдаг.

Сурч боловсрох, хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх, бизнес эрхлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, гэр бүл болох зэрэг олон шалтгааны улмаас манай улсын иргэд гадаадын улс орнуудад зорчих хөдөлгөөн улам бүр нэмэгдэж байна. Энэ талаарх бүртгэл, албан ёсны тоо мэдээлэл өнөө хэр байхгүй байсныг шийдвэрлэх үүднээс Гадаад харилцааны яам, Үндэсний Статистикийн Хороо хамтран гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэдийг бүртгэх маягтыг боловсруулж, маягтын дагуу [www.citizen.gov.mn](http://www.citizen.gov.mn) гэсэн цахим систем хөгжүүлэн 2018 оны 3 дугаар улирлаас эхлэн нэвтрүүлсэн. Гэвч иргэдэд мэдээлэл хүргэх, бүртгэлийг идэвхжүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааг тогтмолжуулах зэрэг нөхцөл байдлаас үүдэн энэ удаагийн гадаадад суугаа Монгол Улсын иргэдийн тооллогын дүнг Хил, хамгаалах ерөнхий газар (ХХЕГ), Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-ын мэдээллийн сангууд болон хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн санг уялдуулан, өрхөөс асуусан тооллогын асуулгын мэдээллийг нэгтгэн гаргалаа. Тооллогын мэдээлэл цуглуулалт Монголд байх гэр бүлээс асуух, нөгөө талаас гадаадад оршин суугаа иргэд өөрсдөө интернэтээр ([www.citizen.gov.mn](http://www.citizen.gov.mn)) тоолуулахаар зохион байгуулсан юм.

## **ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ**


Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 2553 иргэн тоологдож, 2010 оноос 30.3 хувиар өсжээ. Гадаадад оршин суугаа иргэдийн насны бүтцийг харвал 0-14 насны хүн ам 9.7 хувь, 15-44 насныхан 75.5 хувь, 45-64 насныхан 14.3 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 0.5 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, гадаадад удаан хугацаагаар суугаа хүн амын 10 хүн тутмын 9 нь хөдөлмөрийн насны хүн ам байна (Хүснэгт 11.1).

**ХҮСНЭГТ 11.1 ГАДААДАД ОРШИН СУУГАА СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2020 ОН**

Насны бүлэг	Хүний тоо			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>2 553</b>	<b>1 285</b>	<b>1 268</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
0-4	68	39	29	2.7	3.0	2.3
5-9	88	52	36	3.4	4.0	2.8
10-14	92	49	43	3.6	3.8	3.4
15-19	148	74	74	5.8	5.8	5.8
20-24	376	194	182	14.7	15.1	14.4
25-29	488	276	212	19.1	21.5	16.7
30-34	401	216	185	15.7	16.8	14.6
35-39	301	143	158	11.8	11.1	12.5
40-44	213	93	120	8.3	7.2	9.5
45-49	179	65	114	7.0	5.1	9.0
50-54	106	47	59	4.2	3.7	4.7
55-59	63	27	36	2.5	2.1	2.8
60-64	17	4	13	0.7	0.3	1.0
65-69	11	6	5	0.4	0.5	0.4
70+	2	0	2	0.1	0.0	0.2

Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн нас, хүйсийн бүтцийг суваргаар харвал гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн ихэнх хувийг хөдөлмөр эрхлэх насныхан эзэлж байгаа нь харагдаж байна (Зураг 11.1).

**ЗУРАГ 11.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН НАСНЫ БҮТЭЦ, ХҮЙСЭЭР, 2020 ОН**



Зуун эмэгтэйд ногдох эрэгтэй хүн ам буюу хүйсийн харьцаа 101.3 байгаа (50.3 хувь эрэгтэй, 49.7 хувь эмэгтэйчүүд) нь гадаадад оршин суугаа эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдээсээ олон байгааг илтгэх бөгөөд Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам буурч, 35 наснаас эхлэн огцом буурчээ. 0-29 насныхны хувьд дийлэнх нь эрэгтэйчүүд байхад хөдөлмөрийн насны болон ахмад настнуудын хувьд эмэгтэйчүүд илүү байна.

Гадаадад оршин суугаа иргэдийн тоог Сэлэнгэд байнга амьдарч байсан сумаар харвал 34.2 хувь нь Сүхбаатар сумаас, 25.9 хувь нь Мандал сумаас, 9.6 хувь нь Сайхан сумаас, 6.2 хувь нь Алтанбулаг сумаас, 24.1 хувь нь бусад сумдаас гадаад улсад оршин суухаар явжээ.

**ХҮСНЭГТ 11.2 ГАДААДАД ОРШИН СУУГАА СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭД, БАЙНГА СУУЖ БАЙСАН СУМААР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН**

Сумын нэр	Хүний тоо			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>2 553</b>	<b>1 285</b>	<b>1 268</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Сүхбаатар	874	435	439	34.2	33.9	34.6
Алтанбулаг	159	80	79	6.2	6.2	6.2
Баруунбүрэн	38	15	23	1.5	1.2	1.8
Баянгол	92	46	46	3.6	3.6	3.6
Ерөө	100	43	57	3.9	3.3	4.5
Жавхлант	31	15	16	1.2	1.2	1.3
Зүүнбүрэн	44	20	24	1.7	1.6	1.9
Мандал	660	352	308	25.9	27.4	24.3
Орхон	26	15	11	1.0	1.2	0.9
Орхонтуул	32	19	13	1.3	1.5	1.0
Сайхан	246	122	124	9.6	9.5	9.8
Сант	40	20	20	1.6	1.6	1.6
Түшиг	29	14	15	1.1	1.1	1.2
Хүдэр	22	10	12	0.9	0.8	0.9
Хушаат	24	10	14	0.9	0.8	1.1
Цагааннуур	61	32	29	2.5	2.4	2.3
Шаамар	75	37	38	2.9	2.7	3.0

Гадаадад тоологдсон иргэдийн 65.3 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт, 28.6 хувь нь Европ тивд суугаагаар тоологдсон байна.

Сэлэнгэ аймгийн иргэдийн оршин сууж байгаа улсыг авч үзвэл БНСУ (1186), Орос (185), Чех (161), Австрали (162), АНУ (145) улсуудад хамгийн ихээр сууж байна (Хүснэгт 11.3).

**ХҮСНЭГТ 11.3 ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛС,  
 ОРШИН СУУГАА ХУГАЦАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН**

Оршин суугаа улс	Тоо	Бүгд	Дүнд эзлэх хувь			
			0-1 жил	2-5 жил	6-10 жил	11-ээс дээш жил
<b>БҮГД</b>	<b>2 553</b>	<b>100.0</b>	<b>33.3</b>	<b>44.1</b>	<b>14.8</b>	<b>7.8</b>
Солонгос /Өмнөд/	1 186	100.0	38.1	44.2	11.6	6.1
Америк	145	100.0	18.6	50.3	20.7	10.3
Япон	115	100.0	38.3	45.2	12.2	4.3
Казахстан	23	100.0	13.0	56.5	26.1	4.3
Чех	161	100.0	21.1	53.4	15.5	9.9
Австрали	162	100.0	37.0	48.8	10.5	3.7
Хятад	76	100.0	40.8	34.2	10.5	14.5
Герман	63	100.0	9.5	31.7	42.9	15.9
Швед	133	100.0	20.3	41.4	24.1	14.3
Франц	43	100.0	4.7	41.9	34.9	18.6
Орос	185	100.0	47.0	34.6	10.8	7.6
Турк	89	100.0	46.1	43.8	6.7	3.4
Австри	44	100.0	13.6	59.1	22.7	4.5
Швейцар	28	100.0	7.1	46.4	25.0	21.4
Их Британи	22	100.0	18.2	27.3	45.5	9.1
Унгар	11	100.0	27.3	45.5	18.2	9.1
Канад	2	100.0	100.0	0.0	0.0	0.0
Энэтхэг	8	100.0	50.0	37.5	12.5	0.0
Польш	5	100.0	20.0	80.0	0.0	0.0
Ирланд	11	100.0	18.2	54.5	27.3	0.0
Бусад	41	100.0	29.3	34.1	17.1	19.5


Энэ удаагийн тооллогын дүнгээр нийт иргэдийн 22.8 хувь нь сурах, 49.1 хувь нь хөдөлмөр эрхлэх (үүнээс 37.7 хувь нь хувиараа, 11.0 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр, 0.4 хувь нь албан томилолтоор ажиллах), 9.9 хувь нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух, 5.3 хувь нь суурьших, үлдсэн 12.8 хувь нь бусад зорилгоор эх орноосоо явжээ. (Хүснэгт 11.4).

Явсан зорилгыг оршин суугаа улсаар авч үзвэл Энэтхэг, ОХУ, БНХАУ, Япон, Австрали, Герман, Ирланд руу хамгийн олон хүн суралцахаар (нийт сурахаар явагчдын 35.1 хувь), Казахстан, Польш, Их Британи, Америк руу хамгийн олон хүн суурьшихаар (нийт суурьшихаар явагчдын 54.8 хувь), БНСУ, БНЧУ, Унгар луу хамгийн их хүн хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар (нийт хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явагчдын 71.3 хувь), БНСУ, БНЧУ, Швед, Турк, Швейцар, Польш руу хамгийн их хүн хувиараа хөдөлмөрлөхөөр (нийт хувиараа хөдөлмөрлөхөөр явагчдын 62.2 хувь) явсан байна (Хүснэгт 11.4).

ХҮСНЭГТ 11.4. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ОРШИН СУУГАА УЛС, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Оршин суугаа улс	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Суралцах	Суурьших	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Албан томилолтоор ажиллах	Хувиараа ажиллах	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Бусад
<b>БҮГД</b>	<b>2 553</b>	<b>100.0</b>	<b>22.8</b>	<b>5.3</b>	<b>11.0</b>	<b>0.4</b>	<b>37.7</b>	<b>9.9</b>	<b>12.8</b>
Солонгос/Өмнөд/	1 186	100.0	17.5	1.9	13.4	0.1	51.9	5.1	10.3
Америк	145	100.0	35.2	11.0	6.9	0.0	22.8	6.2	17.9
Япон	115	100.0	37.4	5.2	15.7	0.0	22.6	13.9	5.2
Казахстан	23	100.0	4.3	69.6	0.0	0.0	17.4	8.7	0.0
Чех	161	100.0	10.6	8.1	23.0	0.0	30.4	11.8	16.1
Австрали	162	100.0	22.8	0.0	3.1	1.2	13.0	13.0	46.9
Хятад	76	100.0	51.3	7.9	6.6	1.3	17.1	7.9	7.9
Герман	63	100.0	27.0	20.6	6.3	0.0	12.7	14.3	19.0
Швед	133	100.0	7.5	9.8	7.5	0.0	36.8	21.8	16.5
Франц	43	100.0	9.3	11.6	4.7	0.0	44.2	20.9	9.3
Орос	185	100.0	47.0	3.2	2.7	0.0	25.4	17.3	4.3
Турк	89	100.0	21.3	3.4	11.2	0.0	39.3	18.0	6.7
Австри	44	100.0	29.5	11.4	18.2	0.0	9.1	31.8	0.0
Швейцар	28	100.0	14.3	3.6	0.0	0.0	57.1	17.9	7.1
Их Британи	22	100.0	18.2	9.1	9.1	0.0	36.4	9.1	18.2
Унгар	11	100.0	36.4	9.1	27.3	0.0	18.2	9.1	0.0
Канад	2	100.0	0.0	0.0	50.0	0.0	0.0	50.0	0.0
Энэтхэг	8	100.0	100.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Польш	5	100.0	100.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Ирланд	11	100.0	27.3	0.0	0.0	0.0	54.5	9.1	9.1
Бусад	41	100.0	24.4	19.5	7.3	14.6	17.1	4.9	12.2

ЗУРАГ 11.2. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН




Тооллогын үед гадаадад байнга суугаа зорилгыг 2010 оны тооллогын дүнтэй харьцуулбал хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн хувь 13.0 пунктээр, суралцах зорилгоор суугаа иргэдийн хувь 11.9 пунктээр, албан томилолтоор ажиллаж буй иргэдийн хувь 0.5 пунктээр тус тус буурсан байна (Зураг 11.2).

**ХҮСНЭГТ 11.5. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН**

Насны бүлэг	Бүгд	Суралцах	Суурьших	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Албан томилолтоор ажиллах	Хувиараа ажиллах	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Бусад
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
0-4	2.7	0.5	3.7	0.0	0.0	0.2	18.1	3.7
5-9	3.4	1.7	5.1	0.4	0.0	0.3	19.3	5.5
10-14	3.6	4.6	6.6	0.0	0.0	0.2	15.4	4.6
15-19	5.8	18.5	2.2	1.4	0.0	1.1	4.7	3.1
20-24	14.7	35.0	5.9	12.4	20.0	8.5	3.5	11.0
25-29	19.1	25.0	16.2	25.9	50.0	18.5	7.1	14.1
30-34	15.7	9.3	11.0	27.0	10.0	19.2	8.7	14.7
35-39	11.8	3.4	16.9	12.8	10.0	17.5	5.5	12.0
40-44	8.3	1.0	15.4	8.2	10.0	12.9	5.5	7.4
45-49	7.0	0.6	8.2	6.7	0.0	11.1	4.7	8.3
50-54	4.2	0.4	5.1	2.8	0.0	6.4	2.4	6.4
55-59	2.5	0.0	2.9	1.8	0.0	2.9	3.1	5.5
60-64	0.7	0.0	0.8	0.6	0.0	0.6	0.8	1.8
65-69	0.4	0.0	0.0	0.0	0.0	0.4	1.2	1.5
70+	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.2	0.0	0.4

Гадаадад оршин суугаа иргэдийн тооллогын үед сууж байгаа зорилгыг насны бүлгийн хувьд харвал суралцах зорилгоор оршин суугаа хүмүүсийн 87.8 хувь нь 15-34 насныхан байна. Хувиараа хөдөлмөрлөх зорилгоор суугаа хүмүүсийн 79.2 хувийг 25-49 насныхан эзэлж байна.

## ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ



Монгол Улс хүн ам, орон сууцны тооллогоор орон сууц, тэдгээрийн дэд бүтцийн хангамжийн байдлыг нэлээд олон ялгаатай аргачлалаар тоолж ирсэн. Улс, хоршооллын байгууллагын орон сууцны сан хөмрөгийн тооллогыг 1969 онд анх удаа зохион байгуулж байжээ. Харин хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллогуудад орон сууцны сан хөмрөгийн тооллого явуулаагүй, хүн амын амьдарч буй орон сууцны төрөл, өмчлөл болон эзэмшлийн хэлбэр, дэд бүтцийн хангамжийг хүн амын тооллоготой хамтатган явуулж байсан.

Энэ удаа хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор хүн амын амьдарч буй орон сууцны төрөл, түүний нөхцөлийн талаарх үзүүлэлтүүдийг цуглуулахаас гадна хүн амьдран суух зориулалттай бүх төрлийн орон сууц, түүний насжилт, хана болон дээврийн материал, дэд бүтцийн талаарх мэдээллийг цуглуулах зорилготой Байшин, орон сууцны тооллогыг 2019 онд улс орон даяар зохион байгуулж явуулсан.

Зуслангийн суурьшлын бүс харгалзахгүйгээр улирлын чанартай амьдардаг байшин, орон сууцыг урьдчилсан бүртгэлээр бүртгэж, харин хүн амьдран суух зориулалттай үндсэн сууцны мэдээллийг тооллогоор цуглуулсан ба дараах орон сууцыг хамруулсан. Үүнд:

1. Бүх төрлийн гэр
2. Сууцны тусдаа байшин
3. Бие даасан тохилог сууц
4. Нийтийн зориулалттай орон сууцны байшин
5. Нийтийн байр

Мөн Байшин, орон сууцны тооллогод хамрагдсан бүх орон сууцнаас хүн байнга амьдардаг эсэхийг тодруулж, хүн байнга амьдардаг орон сууцны насжилт, хана, шал, дээврийн материал, дэд бүтэц зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж тоолсон.

Харин хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор тоологдсон өрхийн амьдарч буй сууцны нөхцөлийн мэдээллийг хүн ам, өрхийн мэдээллийн сан болон уламжлалт тооллогоор өрхийн орон сууцны нөхцөлийн талаарх мэдээллийг цуглуулсан. Ингэхдээ эхлээд өрх ямар төрлийн сууцанд амьдарч байгааг асууж, дараа нь сууцны ахуйн нөхцөлийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Тоолох үед өрхийн амьдарч буй сууцыг ерөнхийдөө хүн амьдрах зориулалтаар нь гэр, байшин, бусад сууц (зориулалтын бус) гэж ангилсан.

Байшин, орон сууцны болон Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийг хослуулан ашиглахад онцлон тэмдэглэх нэг асуудал бол нэг сууцанд нэгээс олон өрх амьдрах боломжтой учир өрхийн тоо сууцны тооноос өндөр гарах боломжтой, мөн орон сууцны байшингийн мэдээллийг Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар, Сууц өмчлөгчдийн холбооноос цуглуулсан учир доторх сууцны тоо буюу хэдэн айлын орон сууц гэдгийг асууж тодруулахдаа үйлчилгээ эрхэлж байгаа, түрээслэх болон өөр шалтгаанаар эзгүй байгаа хаалгыг ялгаж тодорхойлоогүй.

Иймд орон сууцны байшингийн доторх сууцны тоо орон сууцны байшинд амьдардаг өрхийн тоо хоорондоо зөрөх боломжтой юм.

### СУУЦНЫ ТӨРӨЛ

Сэлэнгэ аймагт Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийт 29004 өрх, 23313 сууцанд амьдарч байна. Амьдарч буй өрхийн тоо, хүн байнга амьдардаг сууцны тооны харьцаа хотод ойролцоо байхад, хөдөөд өрхийн тоо нь илүү байна. Энэ нь хөдөөд нэг сууцанд олон өрхүүд хамт амьдарч байгааг харуулж байна.

Орон сууцны тооллогын дүнгээр аймгийн нийт өрхийн 22.7 хувь нь уламжлалт сууц гэрт, 75.9 хувь нь байшинд, 1.3 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс 1.9 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 1.3 пунктээр нэмэгджээ.


ЗУРАГ 12.1 ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН



Тооллогоор хүн байнга амьдардаг сууцнаас сууцны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан.

Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр авч үзвэл 23.9 хувь нь гэр сууц, 72.6 хувь нь сууцны тусдаа байшин, 1.6 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин, 1.7 хувь нь бие даасан тохилог сууц, 0.2 хувь нь нийтийн байр тоологдсон байна. Нийтийн зориулалттай 280 орон сууцны байшинд 5920 сууц тоологдсон байна

ЗУРАГ 12.2 ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН



ХҮСНЭГТ 12.1. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Сууцны төрөл	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>29 004</b>	<b>100.0</b>	<b>9 858</b>	<b>100.0</b>	<b>19 146</b>	<b>100.0</b>
Гэр	6 580	22.7	1 176	11.9	5 404	28.2
Байшин	22 034	76.0	8 556	86.8	13 478	70.4
Бусад	390	1.3	126	1.3	264	1.4

Хотод нийт өрхийн 86.8 хувь нь байшинд, 11.9 хувь нь гэрт амьдарч байгааг өмнөх тооллогын үетэй харьцуулахад хотын байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь 0.3 пунктээр нэмэгдэж, гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь 0.8 буурчээ. Энэ нь гол төлөв аймгийн төвд хөдөөгөөс шилжин ирэгчид ихэнх тохиолдолд эхлээд гэр хороололд суурьшдагтай холбоотой. Хөдөөгийн өрхийн 28.2 хувь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 8.1 пунктээр буурчээ.

Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 20.2 хувийг эзэлж, 2010 оныхоос 2.4 пунктээр нэмэгджээ. Харин сууцны тусдаа байшинд суудаг өрхийн хувийн жин 2010 оныхоос 1.6 пунктээр буурчээ. Нийт өрхийн 2.4 хувь нь бие даасан тохилог сууцанд амьдарч байгаа бол 2010 оныхоос 1.4 пунктээр өсжээ.

ХҮСНЭГТ 12.2. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР 2010, 2020 ОН

Сууцны төрөл	2010		2020	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>26 889</b>	<b>100.0</b>	<b>29 004</b>	<b>100.0</b>
Гэр	6 603	24.6	6 580	22.7
Зориулалтын бус сууц	222	0.8	-	-
Бусад	1	0.0	390	1.3
Байшин	20 063	74.6	22 034	76.0
Орон сууцны байшин	3 564	17.8	4 456	20.2
Бие даасан тохилог сууц	194	1.0	523	2.4
Сууцны тусдаа байшин	15 600	77.7	16 779	76.1
Нийтийн байр	705	3.5	276	1.3

**СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР**

Өрхийн амьдарч байгаа сууцны өмчийн хэлбэрийг иргэний, хувийн аж ахуйн нэгж байгууллагын, төрийн өмчийн гэж 3 ангилж үзсэн.

ХҮСНЭГТ 12.3. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2020 ОН

Сууцны төрөл	Бүгд		Төрийн өмчийн		Хувийн өмчийн			
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Аж ахуйн нэгж, байгууллагын		Иргэний	
					Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>29 004</b>	<b>100.0</b>	<b>171</b>	<b>100.0</b>	<b>351</b>	<b>100.0</b>	<b>28 482</b>	<b>100.0</b>
Гэр	6 580	22.7	2	1.2	105	29.9	6 473	22.7
Байшин	22 034	76.0	164	95.9	232	66.1	21 638	76.0
Бусад	390	1.3	5	2.9	14	4.0	371	1.3

Нийт өрхийн 99.4 хувь нь хувийн (98.2 хувь нь иргэний, 1.2 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) өмчийн сууцанд амьдарч байгаа нь 2010 оныхоос 0.7 пунктээр нэмэгджээ. Төрийн өмчийн сууц 2000 оныхоос багассан үзүүлэлттэй байгаа. Энэ нь улсаас төрийн мэдлийн орон сууцыг хувьчилж, иргэдээ өмчтэй болгох бодлого хэрэгжүүлсний үр дүн юм.

ХҮСНЭГТ 12.4 ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Сууцны төрөл	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>29 004</b>	<b>100.0</b>	<b>9 858</b>	<b>100.0</b>	<b>19 146</b>	<b>100.0</b>
Төрийн өмчийн	171	0.6	64	0.6	107	0.5
Хувийн ААНБ-ын	351	1.2	107	1.1	244	1.3
Иргэний	28 482	98.2	9 687	98.3	18 795	98.2

Өрхийн сууцны өмчийн хэлбэрийг хот, хөдөөгөөр ангилж үзэхэд төрийн өмчийн сууцанд амьдарч байгаа өрх хөдөөгийн өрхийн 0.5 хувийг эзэлж байгаа нь хотын өрхөөс 0.1 пунктээр бага байна. Нийт өрхөөс иргэний өмчийн сууцанд амьдардаг өрх хөдөөд 98.2 хувь, хотод 98.3 хувь байна.

ХҮСНЭГТ 12.5 ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Сууцны төрөл	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>29 004</b>	<b>100.0</b>	<b>9 858</b>	<b>100.0</b>	<b>19 146</b>	<b>100.0</b>
Өөрийн эзэмшлийн	26 192	90.3	8 706	88.3	17 486	91.3
Бусдын сууцанд түрээстэй суудаг	905	3.1	393	4.0	512	2.7
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	1 856	6.4	730	7.4	1 126	5.9
Бусад	51	0.2	29	0.3	22	0.1

Аймгийн хэмжээнд нийт өрхийн 9.7 хувь буюу 2812 өрх өөрийн сууцгүй байна. Үүнээс хотод 1152 өрх, хөдөөд 1660 өрх байна

### ӨРХИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг 2010 оныхоос нэлээд дэлгэрүүлж авсан. Энэ нь сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, жижиг оврын цахилгаан үүсгүүр өргөн ашиглах болсонтой холбоотой.

### ХҮСНЭГТ 12.6. ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Цахилганы эх үүсвэр	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>29 004</b>	<b>100.0</b>	<b>9 858</b>	<b>100.0</b>	<b>19 146</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	24 601	84.8	9 204	93.4	15 397	80.4
Дизель станц	9	0.0	3	0.0	6	0.0
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	4 038	14.0	602	6.1	3 436	18.0
Бага оврын цахилгаан үүсгүүр	235	0.8	39	0.4	196	1.0
Цахилгааны эх үүсвэргүй	121	0.4	10	0.1	111	0.6
<b>ГЭР</b>	<b>6 580</b>	<b>100.0</b>	<b>1 176</b>	<b>100.0</b>	<b>5 404</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	2 716	41.3	625	53.1	2 091	38.7
Дизель станц	5	0.1	1	0.1	4	0.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	3 565	54.2	516	43.9	3 049	56.4
Бага оврын цахилгаан үүсгүүр	176	2.6	25	2.1	151	2.8
Цахилгааны эх үүсвэргүй	118	1.8	9	0.8	109	2.0
<b>БАЙШИН</b>	<b>22 034</b>	<b>100.0</b>	<b>8 556</b>	<b>100.0</b>	<b>13 478</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	21 507	97.6	8 456	98.8	13 051	96.8
Дизель станц	3	0.0	2	0.0	1	0.0
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	465	2.1	84	1.0	381	2.8
Бага оврын цахилгаан үүсгүүр	59	0.3	14	0.2	45	0.4
<b>БУСАД СУУЦ</b>	<b>390</b>	<b>100.0</b>	<b>126</b>	<b>100.0</b>	<b>264</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	378	96.9	123	97.6	255	96.6
Дизель станц	1	0.3	0	0.0	1	0.4
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	8	2.0	2	1.6	6	2.3
Цахилгааны эх үүсвэргүй	3	0.8	1	0.8	2	0.7

Аймгийн хэмжээнд 121 цахилгаангүй өрх байгаа нь нийт өрхийн 0.4 хувийг эзэлж байна. Гэрт амьдардаг нийт өрхийн 1.8 хувь, хөдөөд гэрт амьдардаг нийт өрхийн 2.0 хувийг эзэлж байна. Сэргээгдэх эрчим хүч ашигладаг өрхийн 85.1 хувь нь хөдөө орон нутагт байгаа нь цаашид ийм төхөөрөмжийн хэрэгцээ нэмэгдэх төлөвтэй байгааг харуулж байна.

### ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Үндэсний уламжлалт сууц болох гэрт Сэлэнгэ аймгийн нийт өрхийн 6580 буюу 22.7 хувь нь амьдарч байгааг өмнөх хэсэгт тэмдэглэсэн.

ХҮСНЭГТ 12.7. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ХУВИАР, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Гэрийн ханын тоо							
			5-аас цөөн		5		6		6-аас дээш	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>6 580</b>	<b>100.0</b>	<b>568</b>	<b>100.0</b>	<b>5 345</b>	<b>100.0</b>	<b>492</b>	<b>100.0</b>	<b>175</b>	<b>100.0</b>
1-2	2 249	34.2	263	46.3	1 812	33.9	130	26.5	44	25.1
3-4	2 192	33.3	158	27.8	1 809	33.8	165	33.5	60	34.3
5-6	1 662	25.3	115	20.2	1 335	25.0	155	31.5	57	32.5
7+	477	7.2	32	5.6	389	7.3	42	8.5	14	8.1

Гэрт амьдардаг өрхийн 81.2 хувь нь 5 ханатай гэрт амьдарч байгаа нь гэрт амьдардаг өрхийн түгээмэл хэлбэр байна.

ХҮСНЭГТ 12.8. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙН НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Ахуйн нөхцөл	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРӨЛ</b>	<b>6 580</b>	<b>100.0</b>	<b>1 176</b>	<b>100.0</b>	<b>5 404</b>	<b>100.0</b>
Сайжруулсан	33	0.5	11	0.9	22	0.4
Энгийн	6 042	91.8	1 130	96.1	4 912	90.9
Био жорлон	4	0.1	1	0.1	3	0.1
Задгай	501	7.6	34	2.9	467	8.6
<b>ХАТУУ ХОГ ХАЯГДЛАА ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР</b>	<b>6 580</b>	<b>100.0</b>	<b>1 176</b>	<b>100.0</b>	<b>5 404</b>	<b>100.0</b>
Үйлчилгээний байгууллагаар	1 063	16.2	196	16.7	867	16.0
Зөвшөөрөгдсөн цэгт	2 704	41.1	461	39.2	2 243	41.5
Шатаадаг	232	3.5	26	2.2	206	3.8
Булдаг	26	0.4	1	0.1	25	0.5
Тогтсон газар байхгүй	2 555	38.8	492	41.8	2 063	38.2
<b>БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР</b>	<b>6 580</b>	<b>100.0</b>	<b>1 176</b>	<b>100.0</b>	<b>5 404</b>	<b>100.0</b>
Цооногт асгадаг	2 484	37.8	447	38.0	2 037	37.7
Задгай асгадаг	4 096	62.0	729	62.0	3 367	62.3


Бие засах тодорхой цэггүй өрх нийт өрхийн 7.6 хувийг эзэлж байгаа нь улсын дунджаас 13.4 пунктээр бага гарчээ. Энэ үзүүлэлт хотод 2.9 хувь, хөдөөд 8.6 хувь байна.

Хатуу хог хаягдлаа хаях тогтсон цэггүй өрх нийт өрхийн 38.8 хувь, бохир усаа задгай асгадаг өрх 62.2 хувийг эзэлж байна. Хотод хатуу хог хаягдлаа зайлуулах тогтсон цэггүй өрх 41.8 хувь, бохир усаа задгай асгадаг өрх 62.0 хувийг эзэлж байгаа нь суурин газар оршин суугчдын орчны эрүүл ахуйн нөхцөлд сөргөөр нөлөөлөхийг анхаарч, цаашид холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гэрт амьдардаг өрхийн 97.7 хувь нь баталгаатай эх үүсвэрээр ундны усаа авч байгаа нь улсын дундажтай харьцуулахад 32.1 пунктээр их байна. Харин 2.3 хувь нь баталгаагүй ундны ус хэрэглэж байгаагаас 0.7 хувь гол мөрөн, нуур, шанд, 0.2 хувь нь зөөврийн ус хэрэглэж байгаа нь гэрт амьдардаг өрхийн олонх нь хөдөө байдагтай холбоотой.

Ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг, шанд, цэвэршүүлэн савласан усыг оруулдаг бол хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, зөөврийн ус, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугийн усыг сайжруулсан ундны усны эх үүсвэрт оруулдаггүй.

ЗУРАГ 12.3. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖ, ХУВИАР, 2020 ОН



### БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ, СУУЦНЫ БАГТААМЖ

Байшинд амьдардаг өрхийн сууцны талбайн хэмжээ, өрөөний тоог тооллогын асуулгад оруулсан нь сууцны зай талбай оршин суугчдын эрүүл ахуйн шаардлагыг хэр зэрэг хангаж байгааг харуулах зорилготой.

ХҮСНЭГТ 12.9. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ХУВИАР, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Сууцны талбай / квадрат метр /					
			20 хүртэл		21-40		40-өөс дээш	
	Өрхийн тоо	Хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>22 034</b>	<b>100.0</b>	<b>1 309</b>	<b>100.0</b>	<b>6 207</b>	<b>100.0</b>	<b>14 518</b>	<b>100.0</b>
1-2	6 226	28.3	455	34.8	1 865	30.1	3 906	26.9
3-4	8 540	38.7	459	35.1	2 389	38.5	5 692	39.2
5-6	5 636	25.6	303	23.1	1 492	24.0	3 841	26.5
7+	1 632	7.4	92	7.0	461	7.4	1 079	7.4

Байшинд амьдардаг өрхийн 28.2 хувь нь 21-40 метр квадрат талбайтай сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогынхоос 12.1 пунктээр буурчээ. Гэтэл 40-өөс дээш метр квадрат талбайтай байшинд суудаг өрхийн эзлэх хувь 65.9 болж өмнөх тооллогынхоос 21.8 пунктээр нэмэгдсэн байна. Харин 7, түүнээс ам бүлтэй өрхийн 7.4 хувь нь 40-өөс дээш метр квадрат талбайтай байранд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 40.7 пунктээр буурчээ.

ХҮСНЭГТ 12.10. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ӨРӨӨНИЙ ТОО, ХУВИАР, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд-Хувь	Өрөөний тоо					
		1	2	3	4	5-7	8+
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>40.4</b>	<b>40.0</b>	<b>15.4</b>	<b>3.1</b>	<b>1.1</b>	<b>0.1</b>
1-2	100.0	44.8	39.8	12.0	1.7	1.6	0.2
3-4	100.0	39.3	41.6	15.4	3.0	0.8	0.0
5-6	100.0	40.1	38.3	16.5	3.9	1.0	0.1
7+	100.0	35.4	38.9	20.1	3.9	1.3	0.4

Байшинд амьдардаг өрхийн 80.4 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгааг улсын дундажтай харьцуулахад 8.3 пунктээр илүү байна. Тус аймгийн өрхийн ам бүлийн дундаж үзүүлэлт болох 3-4 ам бүлтэй өрхийн 80.9 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байна. Харин 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 74.3 хувь нь мөн 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байна.

## ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖ

Энэ удаагийн тооллогоор орон сууцны нөхцөлийн талаар нэлээд мэдээлэл цуглуулсан. Дараах хүснэгтэд байшинд суудаг өрхийн дэд бүтцийн хангамж болох халаалтын төрөл, усан хангамж, бие засах газар, онгоц, шүршүүрийн өрөөний талаарх үр дүнг танилцуулна.

Байшинд амьдардаг өрхийн 25.6 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон нь өмнөх тооллогынхоос 3.2 пунктээр өсөв. Энэ үзүүлэлт улсын дунджаас 24 пунктээр бага байна. Ердийн халаалт 6.5 пунктээр буурсан нь агаарын бохирдлыг багасгаж байна.

### ХҮСНЭГТ 12.11. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Халаалтын төрөл	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн	22.4	29.6	12.5	25.6	32.4	21.3
Төвлөрсөн бус	2.4	2.0	3.0			
Нам даралтын зуух	1.9	1.7	2.2	5.1	4.2	5.7
Цахилгаан халаагуур	0.5	0.3	0.8	0.5	0.4	0.6
Ердийн галлагаа	72.8	68.4	84.5	68.7	62.9	72.4

Халуун, хүйтэн устай сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь 18.5 байгаа нь өмнөх тооллогоос 2.1 пунктээр өсжээ. Энэ үзүүлэлт хотод 19.5 хувь, хөдөөд 17.9 хувь байна. Байшинд амьдардаг өрхийн 70.8 хувь буюу 15 596 өрх зөөврийн ус хэрэглэж байгаа нь өмнөх тооллогоос 8.5 пунктээр буурсан байна.

### ХҮСНЭГТ 12.12. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, 2020 ОН

Усан хангамж	Бүгд	Хот	Хөдөө
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн усан хангамж Халуун, хүйтэн устай	18.5	19.5	17.9
Бие даасан систем Халуун, хүйтэн устай	0.9	0.3	1.2
Зөөврийн	70.8	66.2	73.7
Төвлөрсөн усан хангамж хүйтэн устай	6.0	11.6	2.5
Бие даасан систем хүйтэн устай	3.8	2.3	4.7

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үндсэн үзүүлэлтийн нэг нь онгоц, шүршүүр юм. Сууцны дотроо бие засах газартай, төвлөрсөн системд холбогдсон өрхийн эзлэх хувь аймгийн хэмжээнд 21.5 хувь болжээ. Сууцны дотроо бие засах газартай өрхийн эзлэх хувь улсын дунджаас 28.2 пунктээр бага байна.


Байшинд амьдардаг өрхийн онгоц, шүршүүрийг энэ удаагийн тооллогод өрх дангаараа эзэмшдэг болон нийтээрээ ашигладаг, онгоц шүршүүргүй гэсэн ангиллаар тусгасан. Өмнөх тооллогод уг үзүүлэлтийг онгоц, шүршүүрийн өрөөтэй, өрөөгүй гэж ангилан, өрөөтэй гэснийг тусдаа болон нийтийн хэмээн салгаж тодорхойлсон. Үүнийг энэ бүлэгт 2 тооллогын үр дүнг харьцуулах үүднээс, тусдаа, нийтийн гэсэн дэд ангиллыг салгаж оруулсангүй (хүснэгт 11.13).

**ХҮСНЭГТ 12.13. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН**

	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
<b>БИЕ ЗАСАХ ГАЗАР</b>	-	-	-	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн системд холбогдсон	-	-	-	21.5	25.0	19.2
Цооногт урсгадаг ус татуургын бие засах газар	-	-	-	2.2	2.5	2.1
Нүхэн жорлонд урсгадаг татуургын бие засах газар	-	-	-	1.1	0.2	1.8
Сайжруулсан нүхэн жорлон	-	-	-	0.3	0.3	0.4
Энгийн нүхэн жорлон	-	-	-	74.3	71.8	75.9
Био жорлон	-	-	-	0.0	0.1	0.0
Тогтсон газар байхгүй	-	-	-	0.5	0.2	0.7
<b>БИЕ ЗАСАХ ГАЗАР</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Бусадтай хамтран ашигладаг	2.3	2.6	1.8	11.6	11.7	11.5
Бусадтай хамтран ашигладаггүй	17.5	23.3	9.7	87.9	88.1	87.8
Тогтсон газар байхгүй	1.5	0.9	2.3	0.5	0.2	0.7
<b>ОНГОЦ ШҮРШҮҮРИЙН ӨРӨӨ</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Өрөөтэй	19.6	24.9	12.3	18.7	22.8	16.3
Байнгын суурилуулсан	18.7	24.1	11.4	18.0	21.9	15.6
Угсардаг /зөөврийн/	0.9	0.8	0.9	0.7	0.8	0.6
Нийтээр ашигладаг	0.4	0.4	0.5	1.5	1.1	1.8
Өрөөгүй	80.0	74.7	87.2	79.8	76.1	82.0


Байшинд амьдардаг нийт өрхийн 18.7 хувь нь онгоц, шүршүүртэй байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 0.9 пунктээр буурчээ. Харин онгоц, шүршүүргүй өрхийн хувь аймгийн хэмжээнд 79.8 хувь байхад хөдөөгийн 82.0 хувь нь ийм сууцанд амьдарч байн

ЗУРАГ 12.4. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ  
ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ХУВИАР, 2020 ОН



Байшинд амьдардаг өрхийн 16.1 хувь нь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байна. 2010 онд байшинд амьдардаг өрхийн 14.4 хувь нь хог хаягдлаа зайлуулах тодорхой цэггүй байсан бол 2020 онд 0.4 хувь болж буурчээ.

ЗУРАГ 12.5. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТЫН  
ХЭЛБЭР, ХУВИАР, 2020 ОН



Байшинд амьдардаг өрхийн 25.6 хувь нь төвлөрсөн системээр, 3.1 хувь нь бие даасан системээр шингэн хог хаягдлаа зайлуулж, 68 хувь нь цооногт, үлдсэн 3.3 хувь нь задгай асгаж байна. Цооногт асгадаг өрхийн эзлэх хувь өндөр байгаа нь сууцны тусдаа байшинд амьдардаг өрх байшинд амьдардаг өрхийн дийлэнхийг бүрдүүлж байгаатай холбоотой.

## ХАВСРАЛТ А

### ХҮН АМЫН ТООЛЛОГЫН ТҮҮХЭЭС

Дэлхийн улс орон орчин үед явагдаж байгаа хүн амын тооллогыг 200-гаад жилийн тэртээгээс тодорхой давтамжтайгаар, нэгдсэн хөтөлбөрөөр явуулж, үр дүнг нь албан ёсоор нэгтгэн гаргаж иржээ. Монгол Улсад хүн амын тооллого ХХ зууныг хүртэл тогтмол явагдаж байгаагүй бөгөөд ХХ зууны анхны тооллогыг 1918 онд явагдсан байна. Дараа нь 1935, 1944, 1956, 1963, 1969, 1979, 1989, 2000, 2010, 2020 онуудад ээлжит тооллогыг явуулав. Үүний зэрэгцээгээр 1947, 1950 онуудад тооллогын нэлээд асуудлыг тусгасан нэг удаагийн бүртгэл хийсэн байдаг.

Монгол Улсад статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны бие даасан байгууллага 1960 онд байгуулагдаж, 1963 оны тооллогоос эхлэн тус байгууллага хүн ам, орон сууцны тооллогыг эрхлэн явуулж ирэв. Статистикийн байгууллага тооллогыг эрхлэн явуулж эхэлснээр тооллогын асуулга, хөтөлбөр, заавар, аргачлалыг олон улсын нийтлэг жишиг аргачлалтай нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх, тооллогын дүнг нэгтгэн боловсруулахад орчин үеийн техник, технологи ашиглах болсон байна. Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн аргачлалын дагуу 1969, 1979, 1989 оны тооллогыг явуулсан. Энэхүү аргачлал нь НҮБ-ын зөвлөмжтэй нийцэж байв. Монгол Улс 1969 оноос хүн ам, орон сууцны тооллогыг 10 жилийн давтамжтайгаар, улс хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллогыг 1960 онд тусад нь 1969, 1979, 1989 онуудад хүн амын тооллоготой хамт явуулж байлаа.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого нь өмнөх тооллогоос ихээхэн онцлогтой байв. Энэхүү тооллого нь Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байх үед явуулсан анхны тооллого болсон. Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг шинэчлэн өөрчлөх шаардлага гарсан. НҮБ-аас удаа дараа гаргасан “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж”-ийг 2000 оны тооллогод анх удаа, уг зөвлөмжийн 2008 онд өргөжүүлэн шинэчилсэн хоёр дахь хувилбарыг 2020 оны тооллогод тус тус удирдлага болгосон нь олон улсын стандартад нийцсэн, орчин үеийн аргачлалтай тооллого болсон юм.

## ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ТООЛЛОГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС, ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### *Тооллого явуулах хууль, эрх зүйн бусад үндсийг бүрдүүлсэн нь*

Хүн амын тооллого явуулах хууль, эрх зүйн бусад үндсийг бүрдүүлэх нь тооллого явуулах үндсэн баталгаа юм. Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оноос өмнөх бүх тооллогыг “Хүн амын тооллого явуулах тухай” Засгийн Газрын шийдвэрээр зохицуулж ирсэн юм.

Үндэсний статистикийн хорооноос “Хүн ам, орон сууцны тооллогын тухай” тусгай хуультай болох саналыг оруулснаар 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” Монгол Улсын хуулийг баталсан. Энэ бол түүхэн чухал шийдвэр байлаа. Энэхүү хуулиар тооллого явуулах эрх зүйн болоод эдийн засгийн баталгааг хангаж, тооллого явуулах хугацаа, арга, зохион байгуулах байгууллага, институт, төрийн байгууллага, Засаг захиргааны нэгжийн удирдлага болон хувь хүний тооллогод оролцох үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан юм.

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай Монгол Улсын хууль, “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон “Улсын комисс байгуулах тухай”, “Тооллогын тов тогтоох тухай”, “Тооллогын тов өөрчлөн тогтоох тухай”, УИХ-ын тогтоолууд нь тооллого явуулах эрх зүйн гол үндэс болсон. Мөн түүнчлэн Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын улсын комиссын тогтоолууд, Үндэсний статистикийн хорооны даргын тооллоготой холбогдсон тушаалуудыг үндэслэн Сэлэнгэ аймагт тооллогыг зохион байгуулж явуулсан.

### **ТООЛЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ**

Тооллогыг амжилттай явуулах чухал урьдчилсан нөхцөл нь үйл ажиллагаа бүрийг бүрэн хамарч, оновчтой төлөвлөх асуудал байдаг. Тооллогын үйл ажиллагааг үе шатаар нь урьдчилан сайтар бодож, гүйцэтгэх, хугацаа, зардал, гарах үр дүнг үндэслэлтэй тооцсон төлөвлөгөө шаардлагатай болдог. Ялангуяа тооллогын бэлтгэл ажлын зохион байгуулалт, сургалт, тоолох ажиллагаа, мэдээлэл боловсруулалт, дүн шинжилгээ, тооллогын үнэлгээ болон тооллогын үр дүнг хэрэглэгчдэд хүргэх зэрэг бүхий л үе шатны ажлыг төлөвлөгөөнд тусгах учиртай.

Улсын комиссоос баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргаар батлуулсан төлөвлөгөөг үндэслэн тооллогын бэлтгэл ажлын зохион байгуулалт, сургалт, тоолох ажиллагаа, дүнг өдөр тутам нэгтгэн гаргаж мэдээлэх, тооллогын үр дүнг хэрэглэгчдэд хүргэх зэрэг бүхий л үе шатыг төлөвлөгөөнд тусган оруулсан. Аймгийн комиссын төлөвлөгөөг үндэслэн сум, багийн тооллогын түр товчооны төлөвлөгөөг гаргасан.

Тооллогын бэлтгэл хангах 32 арга хэмжээг (зохион байгуулалт, үйл ажиллагааг эрчимжүүлэх, бүртгэл мэдээллийг цэгцэлж сайжруулах, сургалт

зохион байгуулах, тооллогын материал хүлээн авах, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, тоолох үйл ажиллагаа, сумдаас тооллогын материалыг шалгаж хүлээн авах, ҮСХ-нд тооллогын материалыг шалгуулж хүлээлгэн өгөх) тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн комиссын 2020 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн анхдугаар хуралдаанаар хэлэлцэн баталж, сумдад хүргүүлэн мөрдөж хэрэгжүүлсэн.

### ТООЛЛОГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/50 тоот захирамжаар аймгийн хүн ам, орон сууцны тооллогын түр товчооны бүрэлдэхүүн, сумын тооллогын комиссыг байгуулсан бөгөөд ҮСХ-ны зүгээс зөвлөсний дагуу тус хэлтэс мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган ажилласан.

2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр хүн ам, орон сууцны ээлжит тооллогын аймгийн комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдлаа. Хуралдаанд Хүн ам, орон сууцны 2020 оны улсын комиссын ээлжит тооллогын нарийн бичгийн дарга, ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга А.Амарбал “Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого, байшин орон сууцны 2019 оны тооллогын хууль эрх, зүйн үндэслэл, зорилго, мэдээлэл цуглуулалт” сэдвээр дэлгэрэнгүй мэдээлэл өгөв. Хурлаар хүн ам, орон сууцны тооллогын аймгийн комиссын үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын аймгийн комисс 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ээлжит хуралдаанаа хийсэн. Уг хуралдааныг аймгийн тооллогын комиссын орлогч дарга, Засаг даргын орлогч Ж.Сайнцог ахлан аймгийн комиссын гишүүдэд тооллогын ажилд идэвхтэй оролцож "Шалгая, баталгаажуулъя" аянд нэгдэж өөрийн мэдээллээ шалгаж баталгаажуулах мөн байгууллагынхаа албан хаагчдыг аянд бүрэн хамруулахыг үүрэг болгон өгч ажилласан.

Комиссын дарга:

Ш.Оргил - Аймгийн Засаг дарга

Комиссын орлогч дарга:

Ж.Сайнцог - Аймгийн Хөгжлийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч

Д.Гүндэгмаа – Аймгийн Статистикийн хэлтсийн дарга

Комиссын гишүүд:

Э.Оюунболд – Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга

Ө.Сувдаа - Аймгийн Тамгын газрын дарга

О.Мөнхбаяр – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

- Б.Энхбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- А.Эрдэнэгэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Б.Энхболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
- Ж.Батцогт – Аймгийн Авто тээврийн үндэсний төвийн дарга
- Ч.Жаргалсайхан - Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
- Б.Саруултөгс - Аймгийн ГХБХБГазрын дарга
- Г.Баатар – Аймгийн Онцгой байдлын газрын дарга
- Б.Саранчимэг - Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
- Л.Зоригтбаатар – Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга
- А.Энхбат - Аймгийн Цагдаагийн газрын дарга
- З.Түвшинтөгс – Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Ж.Од – Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- М.Даминхорол – Аймгийн Гаалийн газрын дарга
- Б.Мөнхбат – Гадаадын иргэн, харъяатын газрын хойд бүс дэх газрын дарга
- Б.Мөнхзул - Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга
- У.Батмөнх – Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга
- М.Рэгзэдмаа – Аймгийн Ус цаг, уур орчны шинжилгээний төвийн дарга
- Ж.Отгонжаргал – Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
- Т.Гантулга – Сүхбаатар сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

Ч.Цэнд-Аюуш - Аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Тооллогын комисс, түр товчоод нь аймаг, сум, багийн хэмжээнд тооллогыг удирдан зохион байгуулж шаардагдах хөрөнгө, хүн хүч, байр, унаа шатахуунаар хангах, тооллогын ажилтныг сургах, бэлтгэх бүрэн хамралттай явуулах, дүнг нэгтгэн тушаах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Тооллогын аймгийн комиссыг байгуулахын зэрэгцээ сумдад тооллого зохион байгуулах чиг үүрэг бүхий комиссыг сумдын Засаг дарга нараар ахлуулан байгуулсан.

Аймаг, сумдын тооллогын комисс тухайн шатны түр товчоо, болон багийн түр товчоодыг байгуулж ажиллуулсан. тооллогын бүх шатны комисс нь хариуцсан Засаг захиргааны нэгжийн хэмжээнд тооллогыг удирдан зохион байгуулж,

**НЭГДСЭН ДҮН**

шаардагдах хөрөнгө, хүн, хүч, байр, унаа, шатахуунаар хангах, тооллогын ажилтныг сургаж бэлтгэх, бүрэн хамралттай явуулах, дүнг нэгтгэн тушаах үндсэн үүрэгтэйгээр ажиллав

Аймгийн тооллогын түр товчоог аймгийн статистикийн хэлтсийн дарга, сумдын түр товчоог сумын Засаг даргын орлогч, багийн түр товчоог багийн Засаг даргаар ахлуулж, статистикийн хэлтсийн болон аймаг, сумын Тамгын газар, багийн гүйцэтгэх ажилтны голлох бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсан.

Тооллогын түр товчоод нь тооллогын комиссын удирдлагын дор тооллогын бэлтгэл ажлыг хангах, сургалт зохион байгуулах, тооллогын явцын мэдээг гаргах, хяналтын тооллого явуулах, тооллогын баримт бичиг, урьдчилсан дүнг шалгаж хүлээн авах, түүнийг тухайн төвшинд нэгтгэн дүгнэж, дээд шатны тооллогын комисст хүлээлгэн өгөх зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэв.

**ТООЛЛОГОД ЗОРИУЛСАН ӨРХ, ХҮН АМЫН БҮРТГЭЛ**

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн хоёрт заасныг үндэслэн тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэлийг сум багт тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга нар зохион байгуулж явуулсан. Тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэлийг хийснээр тоолох үед тухайн өрх, орон сууцанд яг хэчнээн хүн тоологдохыг тодорхойлж, төлөвлөлт, зохион байгуулалт, төсөв хөрөнгийг эцэслэн шийдвэрлэхэд оршдог.


Бүртгэлд өрх бүрийг, тухайн өрхөд байнга болон түр хугацаагаар сууж байсан хүн бүрийг хамруулсан бөгөөд орон сууцны төрөл, өрхийн хаяг, өрхийн гишүүдийн овог нэр, суурьшил зэрэг үзүүлэлтийг оруулсан.

**Нийтлэг зүйл**

- Бие даасан хуулийн хүрээнд явагдана
  - Мэдээлэл цуглуулалт хосолмол аргаар явагдана
  - Гадаадад оршин суугаа иргэдийг интернетээр тоолно
- Байшин орон сууцны тооллогын мэдээлэлтэй уялдуулна

Хүн ам орон сууцны тооллогын аймгийн комиссыг 2018 оны 10 дугаар сарын 04 –ний өдрийн А/371 тоот захирамжаар 24 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж ажиллалаа. Сум, багийн тооллогын комисс, түр товчоодыг 3-21 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, түр товчоодын байрыг гэнэтийн гал усны аюул, хувь хүний нууцыг хадгалах зарчмыг ханган ажилласан.

Хүн, ам өрхийн мэдээллийн сангийн мэдээллийг сайжруулах, баяжилт, шинэчлэлт хийх ажлыг эрчимжүүлэх багийн Засаг дарга нарын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/283 дугаар захирамжийн дагуу “Хүн, ам өрхийн мэдээллийн сангийн баяжилт, шинэчлэлт – 2019” 1 сарын аян 17 сум, 56 багийн Засаг дарга нарын дунд зохион байгуулж ажиллалаа



## ТООЛЛОГЫН АЖИЛТНЫ СУРГАЛТ

“Хүн ам, орон сууцны тооллого -2020”-ыг зохион байгуулж явуулах, мэдээлэл цуглуулах сургалтыг 3 үе шаттайгаар явууллаа.

- Тооллого явуулах тооллогын ажилтныг сургах сургагч багшийн сургалтад хэлтсийн дарга Д.Гүндэгмаа, хүн ам хариуцсан мэргэжилтэн Б.Хулан, гэрээт ажилтан Н.Оюунаа нар Үндэсний статистикийн хороонд 3 хоног хамрагдсан.



- 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс 12 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл хэлтсийн дарга Д.Гүндэгмаа, мэргэжилтэн Б.Хулан, гэрээт ажилтан Н.Оюунаа нар сумдын ХАОСТ-ын комисс болон түр товчооны гишүүдэд зориулсан сургалтыг 17 сумыг 5 бүсэд бүсчилэн зохион байгууллаа. Сургалтанд нийт 17 сумын ХАОСТ-ын комисс дарга нар болон түр товчооны гишүүд бүхий 80 албан хаагч хамрагдсан байна.



- 2020 оны 01 дүгээр сарын 04-ны өдрөөс 01 дүгээр сарын 06-ны өдрүүдэд ХАОСТ-д ажиллах тоологч, шалгагч нарт зориулсан сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд 68 тоологч, 19 шалгагч нийт 87 хүн хамрагдалаа.

**СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ**

Тооллого явуулахад иргэдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор :



Сэлэнгэ аймгийн 2018 оны нийгэм, эдийн засгийн гол гол үзүүлэлтийг харуулсан инфографик, 2019 оны сумдаас авах албан ёсны статистик мэдээний хуваарийг тусгасан календарийг бэлтгэж хэвлүүлэн 17 суманд тархаасан. Энэхүү календарийн сүүлийн хуудсанд Хүн ам, орон сууцны тооллогын уриа бүхий зурагт хуудсыг хавсаргасан.

Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын аймгийн комиссын хуралдааны талаарх мэдээллийг Сэлэнгэ аймгийн албан ёсны вэб сайт болон аймгийн Засаг даргын Тамгын газраас бэлтгэн гаргадаг “ӨРГӨН СЭЛЭНГЭ” сэтгүүлийн 2019 оны №08 дугаар, “СЭЛЭНГИЙН МЭДЭЭ” сонин, аймгийн фэйсбүүк хуудас, хэлтсийн фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд мэдээллэн тархаан ажиллалаа

Хүн ам, орон сууцны тооллогын талаарх 4x9 метр хулдаасан хэвлэл бэлтгэн Сүхбаатар сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэр дээр байрлах мэдээллийн самбарт байрлуулан ажиллаж байна. Хүн ам, орон сууцны тооллогын баннер бэлтгэн аймгийн Засаг даргын Тамгын газрын үүдэнд, хэвлэмэл хуудсыг хэлтсийн мэдээллийн самбарт байрлуулан хэрэглэгчдэд тархаан ажиллаж байна.

Иргэдийг “Байшин, орон сууцны тооллого”-доо идэвхтэй хамрагдахыг уриалсан уриалга болон наадаг зургийг бэлтгэн хэрэглэгчдэд тархаахдаа Хүн ам, орон сууцны тооллого”-ын бэлтгэл ажлын хүрээнд хийгдэж байгаа өрхийн бүртгэлээ шинэчлэх уриалгыг давхар хүргэлээ.



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**ИРГЭН ТА БАЙШИН ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГОДОО ИДЭВХТЭЙ ХАМРАГДАНА УУ!**

Тооллогын хугацаа: 2019 оны 09 дүгээр сарын 24-нөөс  
2019 оны 10 дугаар сарын 12-ны хооронд

Тооллогын зорилго:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа бүх байшин, орон сууцны сан хэмрэнг бүрэн тодорхойлох
2. Орон сууцны фонд, хийц, ашигдал, хүчин чадал, дэд бүтцийн хүргэмжийн талвар дэлгэрэнгүй мэдээллийн сантай болох
3. Монгол Улсын сууцны суурь мэдээллийг Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн хамгийн бага нэгжийн түвшинд гаргах
4. Төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрийн төлөвлөлт болоод олон улсад гаргах буй хөгжлийн үзүүлэлтүүдийн суурь мэдээллийг бий болгох

**ИРГЭН ТА ӨРХИЙН ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛДЭЭ ИДЭВХТЭЙ ХАМРАГДАНА УУ!**

Бүртгэлийн хугацаа: 2019 оны 09 дүгээр сарын 02-ноос эхлэн явагдаж байна  
Бүртгэх газар: Өөрийн оршин суугаа багийн Засаг даргын байранд

**Иргэн таны оролцоо хамгийн чухал**

"Хүн ам, орон сууцны тооллого - 2020"-ын бэлтгэл ажлын хүрээнд ҮСХ-ноос иргэн бүр Хүн ам, өрхийн мэдээллийн сан дахь өөрийн мэдээллийг шалган, баталгаажуулах боломжтой [registration.nso.mn](http://registration.nso.mn) веб сайтыг нээн ажиллуулсан. Энэхүү ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтсээс **"ШАЛГАЯ, БАТАЛГААЖУУЛЪЯ"** сарын аян аймгийн 17 сум, 57 баг, 6 тосгон, бүх төр,

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГО  
**НЭГДСЭН ДҮН**

төсвийн байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад зарлаж энэхүү аяныхаа хүрээнд фэйсбүүкийн профайл зургийн хүрээ, уриалга бүхий зурагт хуудас, мөн уг хүрээг жааз хэлбэрээр хэвлэн ашиглалаа.



Мөн энэхүү аянаа эрчимжүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдээр дамжуулан эцэг эхийг нь [registration.nso.mn](http://registration.nso.mn) веб сайтад хандан өрхийн мэдээллээ баталгаажуулахыг уриалсан 6000 гаруй ил захидлыг бэлтгэн тараалаа.





ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГО  
**НЭГДСЭН ДҮН**

Иргэдэд “Хүн ам, орон сууцны ээлжит тооллого-2020”-доо идэвхтэй хамрагдахыг уриалсан видео шторк хийж тархаан ажилласан.



Хүн ам, орон сууцны талаарх цаг үеийн мэдээллийг тухай бүрд “Таны Сэлэнгэ”, “Монголын үндэсний олон нийтийн телевиз” болон хэлтсийн фэйсбүүк болон вэб хуудсанд мэдээллэн ажиллалаа.



Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын талаарх мэдээллийг 17 сумын тооллогын комисс болон түр товчооны гишүүд сумдын мэдээллийн самбар болон фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд тархаан ажиллалаа.



**Сүхбаатар Сум Сэлэнгэ Аймаг Д. Гүндэгмаа болон өөр 3 хүнтэй хамт байна.**  
 Нэгдүгээр сарын 8-нд 23:33 цагт

Арван жил тутамд зохион байгуулагдаг хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого Сүхбаатар суманд түүрийн аргаар сонгогдсон өрхүүдийн хамгийн өндөр настай өрх болох Хонгорморьтын 1 дүгээр багийн иргэн Н.Доржсүрэн түүний гэргий С.Норжмаа наараар эхэлж, Сүхбаатар сумын хүн ам, орон сууцны тооллого агсан өсвөр эхэллээ. Сэлэнгэ аймгийн Эсэст даргын орлогч Б.Нарантуяа, Сүхбаатар сумын Эсэст дарга Т.Гантулга, орлогч дарга Б.Стонзаяа, аймгийн статистикийн хэлтсийн дарга Д.Гүндэгмаа нар хүндэтгэл үзүүлж хоёр буурайд урт насалж, удаан жаргахын өлзийтэй өрөлийг хүсэн ерөөлөө.



## ТООЛОХ АЖИЛЛАГАА

Тооллогын тов эхлэх үеийг хэлтэс бүрэн бүрэлдэхүүнээр угтаж, тооллогын товыг албан ёсоор эхлүүлээ



Тооллогын үед тооллогын явцын мэдээ, тооллогын үед гарах хүндрэл бэрхшээлийг тухай бүрд нь шийдэх зорилгоор шуурхай жижүүрийн хуваарь гарган ажиллаж, гарсан асуудал бүрийг тухай бүр шийдэж ажиллалаа.

Сум бүр тооллогыг түүвэрт сонгогдсон өрхүүдээс хамгийн ахмад настай хүнтэй өрхөөс эхэлж, аймаг, сумын тооллогын түр товчооны дарга гишүүд хүндэтгэл үзүүлж эхэллээ.



## ХЯНАЛТЫН ТООЛЛОГО

Мэдээлэл цуглуулалтын хяналтын ажлыг дөрвөн үе шаттайгаар явуулж ажилласан. Үүнд:

- Сумдын шалгагч нар тооллого эхэлсэн эхний 2 дахь өдрөөс эхлэн тооллогод хамрагдсан өрхөөр орж хяналт хийн, гарсан алдаа дутагдлыг тухай бүр засан ажиллаж ирсэн.



- Аймгийн тооллогын комиссын гишүүд болон хэлтсийн ажилтнууд 4 чиглэл 15 суманд ажиллаж сум тус бүрийн сонгогдсон өрхийн 5 хувьд хяналтыг хийлээ.



- Үндэсний статистикийн хорооноос Дэмбэрэл ахлагчтай баг Сүхбаатар суманд ажиллан 12 тоологч, 2 шалгагчийн материалыг үзэж зөвлөгөө өгөн, 3 өрхөөр орж цуглуулсан мэдээлэлд хяналт хийсэн. Тус хяналтын багаас тооллогын ажил сайн явагдсан гэсэн үнэлгээг авсан.



- Улсын тооллогын комиссоос сонгон ирүүлсэн 307 өрхөд хяналтын тооллогыг явууллаа.



Хүн, ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын уламжлалт буюу цаасаар мэдээлэл цуглуулах ажлыг хуулийн хугацаанд 2020 оны 01 дүгээр сарын 09-15 ны өдрүүдэд зохион байгуулж аймгийн нийт өрхийн 10 хувь буюу нийт 3106 өрх тоолсноос үндсэн өрх 3042, хамт суудаг өрх 64, 11 541 хүн тоолсноос байнга оршин суугаа 11 252, түр эзгүй 257, түр суугаа 32 хүнийг мэдээллийг цуглуулсан байна. Мөн гадаадад оршин суугаа 181 хүнийг бүртгэсэн байна.

#### ТООЛЛОГЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ, ТУШААХ ҮЕИЙН АЖИЛ

Хүн ам орон сууцны тооллогын материалыг хүлээн авах хуваарийн дагуу хэлтсийн бүх ажилтан 1 дүгээр сарын 20-25-ны өдрүүдэд ажиллав. Хүлээн авсан материалаа архивын хавтаст нэгж бүрээр нь хийж, зохих хаяг тэмдэглэгээг хийн 2-р сарын 3-нд улсын комисст амжилттай хүлээлгэн өгсөн.



## АЖИЛСАГ ИРГЭД, БҮТЭЭЛЧ АЙЛ ӨРХИЙН ӨЛГИЙ ӨӨДӨӨ ЗАЯАТ СЭЛЭНГЭ НУТАГ

Ерөө, Орхон, Хараа, Сэлэнгэ гол мөрнийхөө усаар ундаалж, Таван хан, Ноён, Сонгоол уулс, түмний их шүтээн “Ээж” модондоо сүслэн залбирч, Монгол Улсынхаа умард дархан хилийг сахин хамгаалж, улс орноо эрүүл, аюулгүй, эх нутгийнхаа хөрсөнд ургасан буудай, төмс, хүнсний ногоогоор эх орон, эгэл түмнээ хангах ариун үүргээ нэр төртэй биелүүлж яваа ажилсаг иргэд, бүтээлч айл өрхүүдтэй өөдөө заяат Сэлэнгэ нутаг нь 41,1 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутагтай, нийт нутгийн 50,6 хувь нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 43,6 хувь нь ойн сан, 8,2 хувь нь улсын тусгай хэрэгцээний, 0,5 хувь нь усан сан бүхий бүс нутаг.

Ази Европыг холбосон олон улсын төмөр зам, хатуу хучилттай авто зам аймгийн нутаг дэвсгэрийн төв хэсгээр дайран өнгөрдөг, холбоо мэдээллийн дэвшилтэт технологи нэвтэрсэн, дэд бүтцийн давуу хөгжилтэй, цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон, байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт газрууд олонтой учир жилийн 4 улиралд Сэлэнгэ аймгийг зорих дотоод, гадаадын аялагч, амрагчид, ажил хэрэгч хүмүүсийн цуваа тасралтгүй үргэлжилж жил ирэх тусам өсөн нэмэгдсээр байна.

Эрт үеэс үржил шимтэй Орхон Сэлэнгийн сав энэ нутагт хүн төрөлхтний амьдралын анхдагч гал голомт байсны нэгэн илрэл болох эртний хүний араг яс 1974 онд Шаамар сумын нутгаас олдсон байдаг. Энэ олдвороор Төв Азид түүний дотор Сэлэнгэ нутагт хүний амьдрал наад зах нь 400-500 мянган жилийн өмнөөс эхэлсэн гэсэн дүгнэлтийг олон улсын хүн судлаач, түүхчид гаргасан байдаг. Дэлхийн хүн судлалын түүхэнд “Шаамарын хүн” гэж алдаршсан тэр нэн ховор олдвор одоо ОХУ-ын Санкт-Петербург хотын музейд хадгалагдаж байна.

Сэлэнгэ аймаг бол Монголын анхны төрт ёсны улс Хүннү гүрний гол төвлөрөл, хожим аравдугаар зууны үеэс хүчирхэгжин мандаж байсан “Гурван мэргэд”-ийн нутаг билээ. Манай аймгийн нутаг Орхон Сэлэнгийн бэлчир, Буур хээрийн талд 1179 онд Чингис хаан Жамух, Тоорил хаантай хамтарч “Гурван мэргэд” аймгийг бут цохисон нь Их Монгол Улсыг байгуулах аугаа их үйл хэргийн эхлэл болсон түүхтэй.

Манай эриний XIY-XVIII зууны үеэс Хиагт, Хүдэр, Зэлтэрээр олон улсын худалдаа явагдаж дэлхийн капитал Монгол оронд нэвтрэн орох үүд хаалга нь болж байсан байдаг.

Эх түүхийн өлгий, Сэлэнгэ аймаг 1931 онд “Газар тариалангийн аймаг” нэртэйгээр байгуулагдаж, 1934 онд олны хүсэлтээр “Сэлэнгэ аймаг” хэмээх өнөөгийн нэршлээ олсон юм.

Сэлэнгэ аймаг нь Монгол орны умард хэсэг Сэлэнгэ мөрөн, Ерөө, Орхон, Хараа голын үзэсгэлэнт ай сав бүхий ойт хээрийн бүсэд оршдог. Хойд талаараа

Оросын Холбооны Улс, баруун талаараа Булган, Орхон, өмнө талаараа Төв, зүүн талаараа Хэнтий аймгуудтай хил залгадаг. Нутаг дэвсгэрийн төв хэсэгтээ Дархан-Уул аймгийг багтааж байдаг. Улсын нийслэл Улаанбаатар хот, төвийн бүсийн аймгуудтай олон улсын төмөр зам, хатуу хучилттай авто замаар холбогдсон, гол мөрний усан замын тээвэр ашиглах уламжлалт бололцоотой, дэд бүтэц давуу хөгжсөн аймаг. Монгол Улсын бүх газар нутгийн 2.6, ойн нөөцийн 20 гаруй хувийг тус аймаг эзэлдэг. Монгол орны урсгал усны 55 хувь Сэлэнгэ аймгийн нутгаар урсан өнгөрдөг.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох аймгийн ИТХ нь 37 төлөөлөгчтэй, 4 жилийн хугацаагаар сонгогддог, 11 тэргүүлэгч, 4 бодлогын хороотойгоор аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх бодлогын шийдвэр гарган хэрэгжилтэнд хяналт тавих үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хөгжлийн тэргүүлэх салбар нь хөдөө аж ахуй, уул уурхай. Аймгийн нийт өрхийн 70 орчим хувь нь өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг. Сүүлийн жилүүдэд зөгий, гахай, тахиа, галуу, цацагт хяруул, хүнсний ногоо, эсгий, ноолуур, шүрэн эдлэл зэрэг өрхийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байна. Сэлэнгэ аймаг нь эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутаг болох хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Нарийн ноост “Хангай”, нарийвтар ноост “Орхон”, “Ерөө” хонь “Сэлэнгэ” үүлдрийн үхэр зэрэг өндөр ашиг шимт мал сүрэгтэй. Мах, сүүний өндөр ашиг шимт “Казакийн цагаан толгойт”, “Сэлэнгэ”, “Халимаг”, “Симменталь”, “Лимузин”, “Ангус”, “Грефорт” үүлдрийн үхэр, нарийн, нарийвтар ноост “Хангай”, “Орхон”, “Ерөө” үүлдрийн хонийг эрчимжсэн фермерийн чиглэлээр өсгөн үржүүлж малын тоо толгой биш чанарт анхаарах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж байна.

Сэлэнгэ нутгийн авьяас билигт уяачид Ардын хувьсгалын ой, Үндэсний их баяр наадамдаа одтой сайхан наадаж хүлэг морьдоо айраг түрүүнд уралдуулж сайхан нааддаг уламжлалтай. Өнөөгийн залуучууд Англи, Араб, Будаон зэрэг гадны үүлдрийн адуугаар цус сэлбэх, үржүүлэг хийх зэргээр хурдны чиглэлийн адуу өсгөн үржүүлж байна.

Аймгийн аж үйлдвэрийн салбарт улсад төдийгүй гадаад зах зээлд үйлдвэрлэл технологи, бүтээгдэхүүнээрээ танигдсан Зүүнхараагийн “Спирт бал бурам”, “Хөтлийн цемент шохой”, Ерөөгийн “Болдтөмөр-Ерөө” төмрийн хүдрийн үйлдвэр, Зүүнбүрэн, Баянгол сумдын ургамлын тосны үйлдвэр, Сүхбаатар сумын гурилын “Сэлэнгэ Алтан Тариа” зэрэг үйлдвэрүүдтэй. Сэлэнгэ аймаг Ази Европыг Монгол улстай холбож, ОХУ-тай хил залгаа оршдог, эх орны хойд хилийн үүд хаалга болсон аймаг.

Аймгийн удирдлагын баг гадаад харилцааг эдийн засагжуулах бодлого барьж уламжлалт хамтын ажиллагаатай хөрш зэргэлдээ ОХУ-ын зарим аймаг, хот, муж, район, БНХАУ-ын ӨМӨЗО, Япон, Турк, Солонгос, Герман, АНУ, Энэтхэг, Кувейт зэрэг улсуудтай эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллаж байна. Сүхбаатар, Мандал, Баянгол сумдад ахмад настан, хөгжлийн

бэрхшээлтэй болон суурь өвчтэй иргэдийн эмийн бус эмчилгээний сувиллууд ажиллаж байна.

Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио”, “Мөнгөн хараа” чуулга, нийтийн номын сан, Нэгдсэн музей, сумдын соёлын төв зэрэг аймгийн хэмжээний соёл урлагийн байгууллагууд урлаг, соёлын үйлчилгээг ард иргэддээ үзүүлж байна. “Бид Сэлэнгийн үр сад” хүүхдийн урлагийн их наадам, хил залгаа ОХУ-ын Буриад Улстай хамтран “Эв мод”, “Алтаргана” наадам зэрэг томоохон урлаг, соёлын арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж хэвшсэн. “Ээж мод”, “Амарбаясгалант” хийд зэрэг гадна дотны жуулчдын очих дуртай унаган байгалийн төгс үзэсгэлэнд орших сүсэг бишрэлийн газруудтай.

Аймгийн нутаг дэвсгэрээр Алтанбулаг-Сүхбаатар-Дархан-Улаанбаатарыг холбосон 345 км олон улсын авто зам, Дархан-Орхон чиглэлийн 180 км хатуу хучилттай орон нутгийн зам тус тус дамжин өнгөрдөг. ОХУ болон БНХАУ-ыг холбосон олон улсын төмөр зам нь Сүхбаатар, Мандал, Баянгол зэрэг томоохон сум суурин газруудаар дайран өнгөрч байна. Аймгийн төв Сүхбаатар болон Мандал, Цагааннуур зэрэг томоохон сум, суурин газруудад авто зам шинээр тавигдаж ашиглалтад орсон.

Олон улсын болон дотоодын бүх цэгт холбогдсон орчин үеийн холбооны сүлжээтэй. Мобиком, Скайтел, Юнител, Ж-Мобайлын үүрэн телефон хэрэглэгчдийн тоо жил ирэх тусам өсөж бүх сумд, төв суурин газрууд холбогдсон. Төмөр замын дагуух суурин газруудад шилэн кабелийн сүлжээ бүрэн нэвтэрсэн. Аймгийн хэмжээнд зочид буудал 34, үсчин, гоо сайханч, зурагчин, цаг, телевизор, дугуй засвар, хими цэвэрлэгээ зэрэг нийтийн ахуйн үйлчилгээний 323, худалдаа нийтийн хоолны 622 гаруй цэг ажиллаж байна.

Сэлэнгэ аймаг нь чулуун нүүрс, төмрийн хүдэр, алт, мөнгө, мөнгөн ус, гялтгана, хар тугалга, шохойн болон гантиг чулуу зэрэг олон төрлийн ашигт малтмалтай. Төмрийн хүдэр, шохойн чулууг үйлдвэрийн аргаар ашигладаг. Бүрэнхан, Товхонхан, Дэлгэрхан, Баянхан, Дулаанхан, Сонгоол, Ноён уул, Түнхийн хөх нуруу, Бүтээлийн нуруу зэрэг уул нуруудтай. Хамгийн өндөр Сонгоол уул далайн түвшнээс дээш 2226 м өргөгдсөн байдаг. Байгалийн үзэсгэлэн бүрдсэн Сэлэнгэ нутаг нэрс, гүзээлзгэнэ, улаалзгана, үхрийн нүд, мойл зэрэг жимс, самар мөөг элбэгтэй. Сэлэнгэ мөрний дагуу чацаргана ихээр ургахаас гадна олон төрлийн эмийн ургамлын арвин их нөөцтэй. Гол мөрөн нууруудад 8 овгийн 18 зүйл загас байдаг бөгөөд агнахыг хуулиар хориглосон хилэм загас ч бий. 130-аад зүйл усны шувууд жилийн жилд хуран чуулдгийн дотор “Улаан ном”-д орсон нэн ховор хун, хар тогоруу, тоодог зэрэг гоёмсог шувууд ч байна. Баавгай, буга, хандгай, гахай, хүдэр, чоно, шилүүс, дорго, булга, заарт харх зэрэг нэн ховор ан амьтадтай.

Сэлэнгэ аймгийн үнэмлэхүй хүйтэн 34-42, үнэмлэхүй халуун 30-36 хэм хүрдэг. Монгол орны жилд 300-400 мм тунадас унадаг бүсэд хамаардаг.

Сэлэнгэ аймаг нь байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт газар олонтой, аялал жуулчлал хөгжих таатай нөхцөл бүрдсэн бүс нутаг. Жилийн 4 улиралд байнгын үйл ажиллагаа явуулдаг амралт жуулчны баазуудтай. Сэлэнгэ нутгийг сонирхсон аялагчид усан аялал, шувуу ажиглах-судалгаа шинжилгээний аялал, түүх, соёлын дурсгалт газруудын аялал, олон ястны зан заншил-амьдрал ахуйтай танилцах аялал, нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн аялал, шашин мөргөлийн аялал, эргэн дурсахуй буюу атрын 1, 2-р аяны түүхэн замнал аялал, морин болон явган аялал, малчин айл, нүүдлийн ахуй-зан заншил амьдралтай танилцах зэрэг аялалуудаас сонгож аялах боломжтой.

Сэлэнгэ аймаг нь эдийн Засаг, нийгмийн суурь үзүүлэлтээрээ улсдаа тэргүүлдэг бөгөөд энэхүү амжилтаа бататгаж Монгол Улсынхаа 8 удаагийн тэргүүний аймгаар шалгарсан амжилттай нутаг билээ.

Түүхийн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрууд

- Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх тэмцэл Шаамар, Сүхбаатар сумын нутаг Ханын Хөндий, Шар тохой, Тужийн нарс зэрэг газруудаар өрнөж, 1921 оны Ардын хувьсгалын анхны ялалт Алтанбулаг суманд болсон түүхтэй.
- Баруунбүрэн суманд байрлах: 17-р зууны үеийн Монголын эртний түүх, соёл урлагийн хосгүй бүтээл, бурхан номын ариун дагшин газар Амарбаясгалант хийд.
- Цагааннуур суманд орших: Чингис хааны гэрийн буйрын туурь.
- Мандал суманд орших: МЭӨ нэгдүгээр зууны үеэс хүчирхэгжиж Төв Азид ноёрхож байсан Монголын анхны төрт ёсны улс Хүннү гүрний гол төвлөрөл байсныг гэрчлэх Ноён уул дахь Хүннүгийн үеийн булш, хөшөө дурсгал, археологийн олдвор.
- Алтанбулаг сумын нутагт орших: 1179 онд Чингис хаан “Гурван мэргэд” аймагтай байлдаж ялсан “Буур хээрийн хөндий”
- Мандал сумын Түнхэл тосгонд байх: Алунгоо эхийн буудалласан газар.
- Шаамар суманд орших: 1921 онд Их жанжин Д.Сүхбаатараар удирдуулсан журамт цэрэг Ардын хувьсгалын анхны тулаанаа гамин цэрэгтэй хийж ялалт байгуулсан Шар тохой хэмээх газар
- Мандал суманд байх: Унаган байгалийн төгс сайхан бүрдсэн үзэсгэлэнт “Хонин нуга”
- Түшиг суманд орших: Ардын журамт цэрэг цагаан цэргийн хүчийг бут цохисон “Зэлтэрийн гацаа”
- Алтанбулаг, Сүхбаатар сумдад байрлах: Элсэнцэр хөрсөнд ургасан нарсан ойн өвөрмөц тогтоц бүхий домогт “Тужийн нарс” улсын тусгай хамгаалалттай газар нутаг зэрэг түүхэн үйл явдлын гэрч газар нутгуудыг нүдээр үзэх боломжтой.

Сэлэнгэ нутгийн бахархал Сэлэнгэ түмэн:

- Сүхбаатар сумын харьяат Олимп, дэлхийн хүрэл медальт МУГТ Дугарсүрэнгийн Оюунболд
- Мандал сумын харьяат 21-р зууны үндэсний бөхийн 21 дэх аварга Гунаажавын Эрхэмбаяр
- Сүхбаатар сумын харьяат үндэсний сурын ууган “Гавъяат тамирчин”, үндэсний их баяр наадамд 6 удаа түрүүлсэн Монгол Улсын “Дархан мэргэн” Ч.Мөнхцэцэг -Мандал сумын харьяат Д.Ганбаатарын 20-р зууны манлай хүлэг “Дархан түмэн эх” хүрэн халзан зэрэг алдартнуудаараа,

Мах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимт “Казакийн цагаан толгойт”, “Сэлэнгэ” үүлдрийн үхрийг өсгөн үржүүлж фермерийн аж ахуйн хэлбэрт шилжүүлж байгаа, Нарийн нарийвтар ноост “Хангай”, “Орхон”, “Ерөө” үүлдрийн хонийг өсгөн үржүүлж байгаа. Газар тариалангийн салбарт улсын хэрэгцээт үр тарианы 50.6, төмсний 25.7, хүнсний ногооны 34.6, байгалийн хадлангийн 13.3 хувийг үйлдвэрлэж, үр тариа, хадлангаар улсад тэргүүлдэг. Аж үйлдвэрийн салбарт улсын хэмжээний спиртийн 37.2, шохойн 89.9 цементийн 86.4 орчим хувийг дангаараа үйлдвэрлэдэг зэрэг амжилтуудаараа бахархдаг билээ.

Сэлэнгэ аймаг хөдөө аж ахуйн хөгжлийн ирээдүйн чиг хандлагаа эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутаг хэмээн тодорхойлж эрчимжсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх эхлэл суурийг амжилттай бий болголоо. Монгол Улсын өмнөө барьдаг мал аж ахуйн эрдэмтдийн баг махны чиглэлийн Казакийн цагаан толгойт үхрийн цөм сүргийг Хушаат суманд бий болгохоор ажиллаж байна.

Сүүлийн арван жилийн хугацаанд Сэлэнгэ нутагт маань бүтээн байгуулалтын олон ажил хийгдсэн ба заримаас нь дурдвал:

- Аймгийн ард иргэдийн амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүүхэд залуучуудыг хүрээлэн буй байгаль орчинтойгоо танилцах, мэдлэгээ дээшлүүлэх болон аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Гэрэлт цогцолбор барьж, байгалийн үзэсгэлэн газар Сайханы хөтлийг тохижуулсан.



- Аугаа их эх орны дайны Ялалтын 74 жилийн түүхэн ойг тохиолдуулан Алтанбулаг суманд Зөвлөлтийн дайчдын хөшөөг шинээр барилаа. Монголчууд бид түүхэнд тодоор тэмдэглэгдэн үлдсэн энэхүү дайны ялалтыг авчрахад Оросын ард түмэнтэй дайны эхний өдрөөс эцсийн мөч хүртэл сэтгэл нэг байж "Хувьсгалт монгол" танкны цуваа, "Монгол ард" нисэх онгоцны эскадриль болон монгол морьд, сэтгэл санаа шингэсэн эд материалыг фронтод илгээж үнэтэй хувь нэмэр оруулж байсан түүхтэй билээ.



- Сүхбаатар суманд Монгол Улсын Баатар Ж.Нэхийтийн нэрэмжит дэд хурандаа В.Намхайнямбуу захирагчтай Хилийн 0101 дүгээр ангийн хамт олон "Хилчдийн нийгмийн хамгаалал 2024" хөтөлбөрийн хүрээнд аймгийн удирдлагуудын дэмжлэгтэйгээр албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, орон сууцны фондыг нэмэгдүүлэх зорилгоор 14 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан.



- 2014 онд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ЕБС-ийн 12 жилийн 960 хүүхдийн 3-р сургуулийг барьж ашиглалтад орууллаа. 960 хүүхдийн суудалтай сургуулийн байрыг хүлээн авч анхныхаа хонхыг дуугаргаж, шинэ хичээлийн жилээ эхлүүлж байгаа баярт мөч. Энэ нь 2014-2015 оны хичээлийн жилд улс орон даяар хүүхэд бүрийг хөгжүүлэх, боловсролын чанарын хөгжлийн баталгаа болсон явдал болжээ.



- Сэлэнгэ аймаг 2014 оныг “Ээлтэй орчин-Их бүтээн байгуулалт”-ын жил болгон зарлаж аймаг сум, баг, айл хотлоороо ихийг бүтээхийг зорин хөдөлмөрлөж, бүтээсэн бүхнийхээ үр дүнг хүлээн авч байгаагийн нэг нь “Цагаан эрэг” цогцолбор юм. Залуу гэр бүл, хүүхэд, багачуудад зориулан бий болгосон Сүхбаатар өртөөний хойно байрлах “Цагаан эрэг” цогцолборын нээлтийн ажиллагаа 08-р сарын 22-ны үдэш боллоо.



- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум дахь худалдааны чөлөөт бүс албан ёсоор 2014 онд нээлтээ хийсэн. Энэ үеэр “Алтанбулаг экспо-2014” Олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдсан. “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс нь Ази, Европыг холбосон Монгол, Орос, Хятад гурван улсын үндэстэн дамнасан бараа санхүүгийн урсгалын дунд олон улсын худалдаа бизнесийн таатай орчинг бүрдүүлж байгаагаараа онцлог бөгөөд давуу талтай. Худалдааны наймаачин хотын хуурай замын боомт газрыг түшиглэн байгуулагдаж байгаа “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн гол зорилго нь Монгол, Хятад болон азийн орнуудын бараа бүтээгдэхүүнийг ОХУ төдийгүй европын зах зээлд ойртуулан худалдах, түүхий эдийг үйлдвэрлэн дэлхийн зах зээлд гаргах. Тус чөлөөт бүсэд үндэстэн дамнасан бараа санхүүгийн урсгал, Ложистик, хангамж-үйлдвэрлэл, худалдаа, Аялал жуулчлал-Бизнес хамтын ажиллагаа гэсэн үндсэн гурван чиглэл үйлчлэх юм.



- 20-р зууны сүүлийн үеийн их бүтээн байгуулалт Хөтөлийн "Цемент-шохой" ХК-ийн нойтон аргын үйлдвэр, 21-р зууны босгон дээр үйлдвэрийнхээ 30 дахь жилийн түүхэнд дэлхийн тэргүүлэх технологи хуурай аргын шинэ үйлдвэрийг Үндэснийхээ хөрөнгө оруулагчтай хамтран ашиглалтад орууллаа.



- Сэлэнгэ аймагт Биеийн тамир спортын байгууллага үүсэн байгуулагдсаны 70 жилийн ойн арга хэмжээний үеэр аймгийн БТСГ-ын харьяа “Усан спорт сургалтын төв”-ийг ашиглалтад орууллаа. Энэхүү “Усан спорт сургалтын төв” нь улсын төсвийн 5,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр ашиглалтад орсон. Нийт 1000 м<sup>3</sup> талбайтай, 300 хүний суудалтай, үсрэлтийн 3 тавцантай /3м, 5м, 7м/. Насанд хүрэгчид, хүүхдийн бассейн гэсэн 2 хэсэгтэй, анхан шатныхан хичээллэх нэг сургалтын замтай, 4 уралдаан тэмцээн сургалт явуулах замтай. Тус бассейны насанд хүрэгчдийн хэсгийн урт нь 25 метр, өргөн нь 13 метр талбайтай. Анхан шатны сургалтын зам нь гүн талдаа 1,20, нам талдаа 70 см. Уралдаан тэмцээн явуулах сургалтын зам нь гүн талдаа 4.80, нам талдаа 2.20 см гүнтэй. Хүүхдийн бассейны урт нь 10 метр, өргөн нь 5 метр, 1,20 см гүнтэй.



- Хушаат сумын Орхон гол дээгүүр 246 м урт төмөр бетон гүүрийг барьж ашиглалтад оруулснаар аймгийн дэд бүтцийг хөгжүүлсэн томоохон ажил болсон бөгөөд малчид тариаланчдад цаг хугацаа, бензин тос хэмнэсэн ажил болов. Хүдэр, Ерөө, Орхон, Сант, Жавхлант сумдууд аймгийн төвтэйгээ засмал замаар холбогдлоо.



- 2018 онд Тужийн нарсны тусгай хамгаалалтын ойд хүний гараар бүтсэн нарсан ойг харж байгаль экологитой танилцахад зориулагдсан шинэхэн цамхаг ашиглалтад орсон ба тус цамхаг нь 10 м өндөр, 6 м урт, 5 м өргөн, нийт 144м<sup>2</sup> талбайтай. Тужийн нарс нь аймгийн Алтанбулаг, Сүхбаатар, Шаамар сумдын нутаг дамнан оршдог экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах ач холбогдолтой байгалийн өвөрмөц тогтоц бүхий түүхэн дурсгалт газар юм. Энэхүү цамхаг нь хүүхэд багачуудад таримал ой, түүний арчилгааг таниулах, экологийн боловсрол олгох, цаашлаад жуулчдын очих дуртай газар болгоход ач холбогдлоо өгөх учиртай.



- 2016 онд Сэлэнгэ аймгийн ард түмэнд “Сэлэнгэ Олон Улсын Худалдааны төв” анх нээгдсэн. Тус ОУХТ нь олон улсын буюу Улаанбаатар хүртэлх босоо тэнхлэгийн зам дагуу байрласанаараа өндөр ач холбогдолтой юм. Нөгөө талаас Сэлэнгэ аймагт 300 гаруй ажлын байр бий болгосон. Мөн иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах зорилгоор Сүхбаатар сумандаа 40 гаруй чиглэлд үйлчилгээ үзүүлдэг нэг цонхны үйлчилгээг нээн ажиллуулж байна.



- 2010-2019 онуудад 7 давхар, 10 давхар орон сууцууд, Төмөр замын ажилчдын 9 давхар орон сууц зэрэг нийт 226 айлын орон сууц ашиглалтад орсон ба одоо төрийн албан хаагчдын 120 айлын орон сууц баригдаж байгаа бөгөөд эхний 60 айлын орон сууцыг 2020 оны 6 сард ашиглалтад өгөхөөр ажиллаж байна.





- 2019 онд 180 хүүхдийн цэцэрлэгийн барилга ашиглалтад орж, төмөр замын ажилчдын хүүхэд багачууд хүмүүжиж байна.



- 2018 онд Сэлэнгэ аймгийн бэлгэ тэмдэг болсон “Алтан буудай”-н хөшөөг барьж босголоо.



Ажилсаг хөдөлмөрч иргэдтэй, үйлдвэрлэгч бүтээгч өрхүүдтэй өөдөө заяат Сэлэнгэ нутаг минь өөдлөн дэвжиж бүхний түүчээд явах болтугай.

**ХАВСРАЛТ Б**

**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН  
 ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ**

№	Ойлголт	Тодорхойлолт
<b>ТООЛЛОГО</b>		
1	Хүн ам, орон сууцны тооллого	Товлонтогтоосон хугацаанд тухайн улс оронд (буюу түүний нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг) оршин суугаа нийт хүн амыг хамарч, тэдний амьдарч буй сууцны талаарх суурь мэдээллийг цуглуулах, боловсруулах, хүн ам зүйн, эдийн засаг, нийгмийн дүн шинжилгээ хийх, үнэлэх, хэвлэн нийтлэх, нийтэд тархах цогц үйл ажиллагаа;
2	Тооллогын тов	Тооллого явуулах хугацааны эхний өдөрт шилжих шөнийн 00 цагийг; 2020 оны 1 дүгээр сарын 08-наас 09-нд шилжих шөнийн "00" /тэг тэг/ цаг;
3	Тоолох үе	2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 08 цагаас 1 дүгээр сарын 15-ны өдрийн 22 цаг хүртэлх хугацаа;
4	Тооллогын нэгж	Хувь хүн, түүний амьдарч байгаа байр, орон сууц;
<b>ӨРХ, ХҮН АМ</b>		
5	Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.
6	Үндсэн өрх	Сууцны төрөл, хэлбэрээс үл хамааран тухайн сууцыг өмчлөгч өрх, сууц эзэмших эрхийн бичиг (ордер), орон сууц хөлслөх гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа өрх, өмчлөгч нь өөр этгээд боловч уг сууцанд хамгийн удаан хугацаагаар амьдарч байгаа өрхийг хэлнэ.
7	Хамт суудаг өрх	Тухайн өрхийн өөрийн сууц биш, тухайн сууц эзэмшигчтэй хамт суудаг өрхийг хамруулна.
8	Өрхийн тэргүүлэгч	Ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16, түүнээс дээш настай, хөдөлмөр эрхэлдэг буюу өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн юм.
9	Өрхийн ам бүлийн гишүүд	Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Тоолох үед тухайн өрхөд гишүүдээс нь гадна өрхийн ам бүлд хамаарахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно.
10	Ам бүлээрээ байгаа өрх	Ам бүлээрээ байгаа өрх дангаараа амьдрахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эхнэр, нөхөр, хүүхдийн (хүүхдүүдийн) хамт, мөн эцэг эсвэл эх нь хүүхдийн (хүүхдүүдийн) хамт өрх үүсгэн амьдрахыг хэлнэ.
11	Нийлмэл ам бүлтэй өрх	Нийлмэл өрхөд дараах бүтэцтэй өрх хамрагдана. Үүнд: а. Нэг ам бүл бусад хамаатан садантайгаа хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх б. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгаа в. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгэнтэй нь хамааралтай хүнтэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа г. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай боловч ам бүлийн биш хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа зэрэг өрх орно.

№	Ойлголт	Тодорхойлолт
12	Холимог ерх	Холимог ерхэд дараах бүтэцтэй ерх хамаарна. Үүнд: а. Нэг ам бүл бусад хамаатан садан хамааралгүй хүмүүстэй хамт ерх үүсгэн амьдарч байгаа ерх б. Нэг ам бүл, хамааралгүй хүмүүстэй хамт ерх үүсгэн амьдарч байгаа ерх в. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгнийх нь хамаатан садан, хамааралгүй хүмүүстэй хамт ерх үүсгэн амьдарч байгаа г. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл эдгээр ам бүлийн алинд ч хамааралгүй хүмүүстэй хамт ерх үүсгэн амьдарч байгаа д. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралгүй ам бүл бусад хүмүүстэй амьдарч байгаа е. Хоорондоо хамааралтай боловч ам бүлийн биш хоёр, түүнээс олон хүмүүс бусад хамааралгүй хүмүүстэй ерх үүсгэн амьдарч байгаа ё. Хоорондоо хамааралгүй хүмүүс ерх үүсгэн амьдарч байгаа ерх орно.
13	Оршин суугаа хүн ам	Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга (183 хоног буюу 8 сараас дээш хугацаагаар) оршин суугаа Монгол Улсын харьяат иргэд, гадаадын харьяат болон харьяалалгүй иргэдийг хэлнэ.
14	Бэлэн хүн ам	Тооллого явуулж буй үед тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа нийт хүн амыг (байнга болон түр хугацаагаар амьдарч байгаагаас үл хамаарч) хэлнэ.
<b>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ</b>		
15	Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг ойлгоно.
16	Төрөлхийн	Удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
17	Олдмол	Ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
18	Харааны	Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "харах" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
19	Ярианы	Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний "ярих" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
20	Сонсголын	Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "сонсох" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
21	Хөдөлгөөний	Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
22	Сэтгэцийн	Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлөвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан.
23	Хавсарсан	Хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд тооцно.
24	Бусад	Дээрхээс бусад ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан буюу хязгаарлагдсан.
<b>ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛ, ТҮҮНИЙ ХЭЛБЭР</b>		
25	Хүндрэлгүй	Аливаа үйлдэл хийхдээ ямар ч асуудалгүй, мэдрэхүйн эрхтнүүдэд ямар ч хүндрэл тулгардаггүй.
26	Бага зэрэг хүндрэлтэй	Аливаа үйлдэл хийхдээ бусдын дэмжлэг эсвэл туслах хэрэгсэл хэрэглэж өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдог.

№	Ойлголт	Тодорхойлолт
27	Их хүндрэлтэй	Аливаа үйлдлийг хийх процессын 80-90 хувьд нь туслах хэрэгслийн болон бусдын тусламжийг авдаг. (алхаж явахдаа байнга хэн нэгнийг түшиж, тулж явдаг, аливаа зүйлийг ойлгохдоо бусдаар нэмэлт тайлбар хийлгэдэг, ахуйн энгийн үйлдлүүдийг бусдын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлдэг)
28	Огт чаддаггүй	Аливаа үйлдлийг хийхэд эрүүл мэндийн асуудал нь тухайн хүний үйлдлийн чадварт 100% сөргөөр нөлөөлж ямар ч үйлдлийг өөрөө бие даан хийх боломжгүй.
29	Харааны хүндрэл	Харааны бэрхшээлтэй буюу харааны шил эсвэл контакт линз зүүсэн эсвэл зүүдэггүй хүмүүсийн хувьд харахад хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой юм. Тухайн хүн харааны шил зүүдэг тохиолдолд Та харааны шил зүүсэн ч юм харахад хүндрэлтэй байдаг уу? гэж асуух байдлаар оруулсан.
30	Сонсголын хүндрэл	Сонсголын бэрхшээлтэй, сонсголын аппарат зүүсэн эсвэл зүүдэггүй хүмүүсийн хувьд сонсоход хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. Сонсголын хүндрэлд чимээ ихтэй орчин эсвэл нам гүм орчинд янз бүрийн дуу чимээг ялгаж сонсоход нэг эсвэл 2 чихээрээ сонсоход хүндрэл тулгарч байгааг ойлгоно. Тухайн хүн сонсголын аппарат зүүдэг бол Та сонсголын аппарат зүүсэн ч юм сонсоход хүндрэлтэй байдаг уу? гэж асуух байдлаар оруулсан.
31	Алхах болон шатаар өгөж/ дээшээ авирах хүндрэл	Алхахдаа ямар нэгэн хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. Ямар нэгэн дэмжлэг болох төхөөрөмж (тэргэнцэр, таяг, алхуулагч гэх мэт) эсвэл хэн нэгний туслалцаагүйгээр алхаж чадаж байвал алхаж чаддаг гэж үзнэ. Алхахад хүндрэлтэй гэдэгт алхсанаас эсвэл шатаар дээш, доош алхсанаас шалтгаалж бие сулрах, тэнцвэр алдах, эсвэл бусад тулгуур эрхтэн тогтолцооны бус хүндрэл тохиолдож байгааг оруулна.
32	Аливаа зүйлийг санах, анхаарлаа төвлөрүүлэх хүндрэл	Эргэн санах гэж нь өнгөрсөн үйл явдлыг эргэж санахыг ойлгоно. Зам харгүй олох, аливаа асуудалд анхаарлаа хандуулж чадахгүй байх, хаана байгаагаа эсвэл он сараа мартаж зэргийг бэрхшээлтэй гэж үзнэ. Мөн хэн нэгний хэлсэн ярьсныг санахгүй байх, будилах, ихэнх зүйлсээс айх зэргийг хүндрэлтэйд тооцно. Ажлын ачаалал, стресс бухимдал, эмийн нөлөөний улмаас үүссэн санах, анхаарлаа төвлөрүүлэхтэй холбоотой хүндрэлийг хүндрэлтэй гэж үзэжгүй.
33	Бие даан усанд орох, хувцсаа өмсөх зэргээр өөрийгөө арчлах хүндрэл	Энэ асуулт нь бие даан өөрийгөө халамжлах, анхаарахад хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой.
34	Бусадтай ярилцах хүндрэл	Энэ хэсэг нь ярих, сонсох, бусдыг ойлгох, бусдад өөрийгөө ойлгуулахад ямар нэг хүндрэлтэй байдаг хүмүүсийг илрүүлэх зорилготой. Мэдээлэл солилцохдоо дохио зангаа хэрэглэдэг (дохионы хэл орно), бичгээр эсвэл дуу авиа ашигладаг бол харилцааны бэрхшээлтэй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, бусдад өөрийгөө ойлгуулахдаа эсвэл бусдын яриаг ойлгохдоо харилцааны өөр арга хэрэглэж байгаа тохиолдлыг ойлгоно.
<b>СУУРЬШИЛ</b>		
35	Байнга оршин суугаа	Тооллогын товын байдлаар тухайн засаг захиргааны нэгжид 8 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүн
36	Түр эзгүй байгаа	Тооллогын товоос өмнө үндсэн засаг захиргааны нэгжээс гадагш 8 сар (183 хоног) хүрэхгүй хугацаагаар явсан хүн
37	Түр оршин суугаа	Өөр засаг захиргааны нэгжээс ирж, тооллогын товын өмнө тухайн засаг захиргааны нэгжид 8 сар (183 хоног)-аас доош хугацаагаар сууж байгаа хүн
<b>БОЛОВСРОЛ</b>		
38	Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгсөөгүй бол Боловсролгүй хүн гэнэ. Мөн 2020 онд ЕБС-ийн 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг Боловсролгүй гэж үзнэ.
39	Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн

№	Ойлголт	Тодорхойлолт
40	Бүрэн бус дунд (суурь) боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг 1975 он хүртэл, 8 дугаар ангийг 1975-2004 онуудад, 9 дүгээр ангийг 2005 оноос хойш өдөр, орой эцнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн
41	Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10 дугаар ангийг 2005 он хүртэл, 11 дүгээр ангийг 2006-2014 онуудад, 12 дугаар ангийг 2015 оноос хойш өдөр, орой эцнээгээр төгссөн, мөн албан
42	Техникийн болон мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн
43	Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн
44	Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эцнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизм оройн дээд сургууль Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.
45	Бичиг үсэг мэддэг	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг Бичиг үсэг мэддэг гэж үзнэ.
46	Бичиг үсэг мэддэггүй	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших бичиг чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг Бичиг үсэг мэддэггүй гэнэ.
<b>ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ</b>		
47	Огт гэрлээгүй	Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүн
48	Гэрлэсэн батлуулаагүй	Хадийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүн
49	Гэрлэсэн батлуулсан	Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүн
50	Тусгаарласан	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Тусгаарласан гэж үзнэ. Гэхдээ албан ажлын улмаас 2 тусдаа амьдарч байгаа хүнийг тусгаарласан гэж үзэхгүй.
51	Цуцалсан	Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Цуцалсан гэж үзнэ.
52	Бэлэвсэн	Эхнэр/нехрийн аль нэг нь нас барснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Бэлэвсэн гэж үзнэ.
<b>ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ</b>		
53	Ажил эрхэлдэг хүн	Сүүлийн 7 хоногт наад зах нь 1 цаг цалин хөлстэй хөдөлмөр эрхэлсэн болон ер нь цалинтай ажил/бизнесийн үйл ажиллагаа байгаа хүн ам;
54	Ажилгүй хүн	Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.

№	Ойлголт	Тодорхойлолт
55	Боломжит ажиллах хүч	Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм (заалт 40с, 51, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд: а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн; б. Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.
56	Хөдөлмөрийн насны хүн ам	15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.
57	Ажиллах хүч	Тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.
58	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно.
59	Цалин хөлстэй байнгын ажиллагч	Ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насны дээд хязгаар, тэтгэвэрт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүйгээр хөдөлмөр эрхэлдэг ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно. Мөн ажилд ороод удаагүй, туршилтын хугацаандаа ажиллаж байгаа боловч цаашид үргэлжлүүлээд байнгын хугацаагаар ажиллуулахаар хүлээгдэж байгаа ажиллагч орно.
60	Цалин хөлстэй түр ажиллагч	Хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3, түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно.
61	Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	Ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм
62	Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан	Цалин хөлстэйгөөр, ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй ажиллагч юм.
63	Гүйцэтгэх гэрээлэгч	Эдийн засгийн өөр нэг нэгжид, эсвэл уг нэгжээр дамжуулаад бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор арилжааны шинжтэй гэрээ (хөдөлмөрийн бус) байгуулан ажиллаж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагч нь тухайн эдийн засгийн нэгжийн цалин хөлстэй ажиллагч биш боловч ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэл, орлого болон зах зээлд гарах боломж зэрэг нь уг эдийн засгийн нэгжээс хамаардаг. Мөн эдгээр ажиллагч нь тэдний үйлдвэрлэлийн (бүтээмжтэй) үйл ажиллагаанд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлынх нь үр шимийг шууд хүртдэг эдийн засгийн өөр нэгжээс хараат, ашгийн төлөө ажиллагч юм.
64	Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч	Ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээшхүнийг тогтмол "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

№	Ойлголт	Тодорхойлолт
65	Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч	Ашиг олох зорилгоор аж ахуй нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуй нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулж байгаа ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.
66	Ажилтан ажиллуулдаггүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч	Ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл хувь эзэмшигч, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж, байгууллагын (хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо) үйл ажиллагааг эрхэлж буй ажилчид юм.
67	Ажилтан ажиллуулдаггүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	Ямар нэгэн цалин хөлстэй ажиллагч авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрхэлж явуулдаг ажилчид юм.
68	Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	Өрхийн гишүүд, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эрхэлж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажилд, эсвэл тэдгээрийн цалинтай ажил болон гүйцэтгэх гэрээлэгчээр ажиллаж буй ажилд нь тусалж байгаа ажиллагчийг хэлнэ. Тэд эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гаргадаггүй, үүрэг хүлээдэггүй бөгөөд цалин хөлсгүйгээр оролцож, үйл ажиллагаанаас олсон орлогоос өрх дотроо ашиг хүртдэг.
<b>МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ БА ТОДОРХОЙЛОЛТ</b>		
69	Менежер	Менежер нь Засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага, түүний дотоод нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах, үнэлэх, бодлого, журам боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтанг хамруулна. Тухайлбал, төрийн болон хувийн аж ахуй нэгж, төрийн бус байгууллагын бүх төвшний дарга, захирал, хууль тогтоогч, төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, бүх төвшний засаг дарга, захирагч, ТББ-ын удирдах албан тушаалтан, менежер гэх мэт.
70	Мэргэжилтэн	Мэргэжтэн нь мэдлэгийнхээ санг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, урлагийн онол, үзэл баримтлалыг ашиглах, тэдгээрийг системтэйгээр заах сургах буюу мэргэжлийн өндөр төвшин шаардсан ажил гүйцэтгэгч байна. Тухайлбал, шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн, эмч, сувилагч, багш, судлаач, бизнесийн болон захиргааны мэргэжилтэн, программ зохиогч, шашны мэргэжилтэн, уран бүтээлч, дуучин, жүжигчин гэх мэт.
71	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн нь шинжлэх ухаан, инженерийн чиглэлээр хийх судалгаа, практикт хэрэгжүүлэхэд холбогдох техник шинжтэй ажил гүйцэтгэнэ. Тэдуул уурхай, аж үйлдвэр, барилга болон бусад салбарын инженерийн үйл ажиллагаатай холбоотой техникийн болон үйлдлийн арга ажиллагааг хянах, удирдах, тоног төхөөрөмж ажиллуулна. Физик, инженерийн ухааны техникч, уурхай, үйлдвэр болон барилга угсралтын байцаагч, технологи процесс, чанар шалгагч, амьд ертөнц судлах ухааны техникч, холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн, усан онгоц, агаарын хөлгийн хянагч, техникч гэх мэт.
72	Контор, үйлчилгээний ажилтан	Тодорхой асуудалд хамаарах мэдээллийг тэмдэглэх, эмхлэх, хадгалах, тооцоолон бодох, сэргээн засварлах ба мөнгөний гүйлгээ хийх, аялал жуулчлал зохион байгуулах, мэдээлэл авах, хүсэлт тавих, уулзалт товлох зэрэг туслах шинжтэй олон төрлийн үүргийг гүйцэтгэнэ. Компьютерийн операторч, үйлчилгээний туслах ажилтан, тооцоолол, материал, тоо бүртгэлийн ажилтан, конторын бусад туслах ажилтан гэх мэт.

№	Ойлголт	Тодорхойлолт
73	Худалдаа, үйлчилгээний ажилтан	Үйлчилгээ, худалдааны ажилтан нь аялал жуулчлал, гэр ахуйн ажил эрхлэх, нийтийн хоолоор үйлчлэх, хувь хүн асрах юмуу хууль бус үйлдэл, гал түймрээс сэргийлэх, хамгаалах эсвэл бөөний ба жижиглэн худалдаа, бусад төстэй байгууллагад, тэрчлэн зах, мухлагаар бараа таваар дэлгэн үзүүлэх, худалдаж борлуулахад холбогдсон хувийн болон хамгаалалтын шинжтэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Хувийн үйлчилгээний ажилтан, худалдааны ажилтан, хувь хүн асрах ажилтан, хамгаалах үйлчилгээний ажилтан гэх мэт.
74	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан нь үр тариа, мод, бут, малын тэжээл ургуулах, зэрлэг жимс, ургамал түүх, ан амьтан үржүүлэх, харж хамгаалах, агнах, төрөл бүрийн амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах, гэр бүлийнхээ хоол хүнсэнд зориулан загас үржүүлэх буюу барих, усны бусад төрөл зүйлийг өсгөж, үржүүлнэ. Зах зээлийн баримжаатай хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан, зах зээлийн баримжаатай ой, загас агнуурын аж ахуйн мэргэшсэн ажилтан, өрхийн хэрэгцээний шинжтэй фермэрч, загасчин, анчин болон түүн цуглуулагч гэх мэт.
75	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан нь барилга барих, арчлах, металлд хэлбэр оруулах, металл бүтээцийг босгох, автомат багаж хэрэгслийг тохируулах, машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хийх, тавруулах, засварлах, хэвлэх ажлын бүтээгдэхүүн гаргах, хүнсний зүйл, нэхмэл эдлэл, модон, металл, бусад эд бараа, түүний дотор гар урлалын зүйл үйлдвэрлэх салбарт мэдлэг, ур чадвараа хэрэглэнэ. Металл, машин, механизм, түүнтэй холбогдох бусад мэргэжлийн ажилтан, гар урлал, хэвлэлийн ажилтан, цахилгаан болон цахим техникч, хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч гэх мэт.
76	Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	Хөдөө аж ахуйн машин, механизм, тоног төхөөрөмжийг биечлэн жолоодох эсвэл зайнаас буюу алсын удирдлагаар удирдаж ажиллуулах, хянах, галт тэрэг, хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт машин, механизм, тоног төхөөрөмжийг жолоодох, ажиллуулах, ад анги, хэсгүүдээс бүрдсэн бүтээгдэхүүнийг заввар, журам, стандарт, шаардлагын дагуу угсрах ажил эрхэлнэ. Төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч, жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч гэх мэт.
77	Энгийн ажил, мэргэжил	Энгийн ажил эрхлэгч нь өдөр тутмын, байнга давтагдах шинжтэй энгийн ажил, үүргийг гар багаж хэрэгсэл ашиглан гүйцэтгэх бөгөөд голчлон биеийн хүчний ажил эрхэлнэ. Цэвэрлэгч, туслагч, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил, уурхай, барилга угсралт, үйлдвэр, тээвэр, агуулахын ажил, хүнс бэлтгэлийн туслах ажил, гудамжин дахь худалдаа, үйлчилгээний ажил, бусад энгийн ажил гэх мэт.
78	Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	Зэвсэгт хүчний офицерийн цол бүхий Монгол Улсын Зэвсэгт хүчний зохих албан тушаалд цэргийн алба хаахыг офицерийн алба гэнэ. Зэвсэгт хүчний офицер нь төрөл бүрийн энгийн ажил, мэргэжилд байдаг ижил төстэй үүрэг гүйцэтгэж болно. Энэ бүлэгт Зэвсэгт хүчинд алба хааж байгаа дунд офицер, ахлах офицер, дээд офицерийн нийт бие бүрэлдэхүүн багтана.
<b>ЭДИЙН ЗАСГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛЫН ТОДОРХОЙЛОЛТ</b>		
79	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, анагнуур	Тухайн салбарт мал, амьтны болон ургамлын байгалийн нөөц ашиглалт хамаарна. Энэ салбарт хөдөө аж ахуйн ургамал ургуулах, мал, амьтан, үүний дотор үржлийн мал, амьтныг өсгөн үржүүлэх үйл ажиллагаа, мод бэлтгэл, фермд ч, байгаль орчинд ч бусад ургамал, мал, амьтан буюу мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний бэлтгэл орно.
80	Уул уурхай, олборлолт	Байгалийн хатуу (нүүрс, хүдэр), шингэн (нефть) эсвэл хий (байгалийн хий) зэрэг эрдэс баялгийг олборлох уул уурхайн үйл ажиллагаа багтана. Олборлох үйл ажиллагаа нь далд эсвэл ил уурхай, далайн ёроолын уурхай гэх мэт уурхайгаас төрөл бүрийн аргаар гаргаж авах үйл ажиллагаа байж болно.
81	Боловсруулах үйлдвэрлэл	Боловсруулах үйлдвэрлэл нь түүхий эд, материалыг физик болон химийн аргаар хувиргаж шинэ бүтээгдэхүүн үүсгэх үйл ажиллагаа юм. Боловсруулах үйлдвэрлэлийн завсрын бүтээгдэхүүн нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, уул уурхай, олборлолтын бүтээгдэхүүнүүд орно. Мөн бусад боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох түүхий эд материал, бодис эсвэл бүтээгдэхүүнийг хувиргахад орох түүхий эд байна. Барааг шинэчлэх, сэргээн босгох, өөрчлөх үйл ажиллагаа нь ихэвчлэн боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа байна.

№	Ойлголт	Тодорхойлолт
82	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Энэ салбарт дэд бүтцийн /сүлжээ/ шугам хоолойгоор дамжуулан цахилгаан эрчим хүч, хий, уур, халуун, хүйтэн усвар хангах үйл ажиллагаа хамрагдана. Түүнчлэн нэгдсэн сүлжээгүй орон нутгийн чанартай барилга байгууламжийн бие даасан эхүүсвэр бүхий цахилгаан, хий, уур, халуун, хүйтэн усвар хангах, түгээх ажиллагаа мөн багтана.
83	Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	Энэ салбарт өрхийн болон үйлдвэрийн хатуу эсвэл хатуу бус, бохирдсон талбай зэргийн хог, хаягдлыг цуглуулах, ариутгах, боловсруулахтай холбогдох үйл ажиллагаа багтана. Ус хангамжийн үйл ажиллагаа бүгд энэ салбарт орно. Өрх, үйлдвэрлэл, үйлчилгээний усан хангамжийн үйл ажиллагаа ихэнхдээ бохир усыг цэвэрлэх, боловсруулах үйл ажиллагаатай холбоотой байх бөгөөд аж ахуйн нэгжүүд эдгээр үйл ажиллагааг хамтруулан хийдэг байж болно. Хог хаягдлыг боловсруулах, бохир усыг цэвэршүүлэх үйл ажиллагааныг дүнд ариутгасан эсвэл, цэвэршүүлсэн шинэ бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагаа байж болно.
84	Барилга	Мэргэжлийн гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, инженерийн барилга байгууламжийн угсралтын ажил орно. Энд шинэ барилгын угсралтын ажил, өргөтгөл, шинэчлэлтийн ажил, барилгын засварын үйл ажиллагаа орно. Их барилгад орон сууц, контор, худалдаа, үйлчилгээ, хөдөө аж ахуйн барилга, авто зам, гудамж, талбай, гүүр, туннел, төмөр зам нисэх талбай, боомт зогсоол болон цахилгаан, дулаан, усан хангамжийн сүлжээ, дамжуулах хоолой, усалтын систем, үйлдвэрийн байгууламж болон биеийн тамирын талбайн ажил зэрэг иргэний инженерийн барилга байгууламжийн угсралтын ажил орно.
85	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	Бүх төрлийн бараа бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, тухайлбал, хувирган өөрчлөхгүй худалдаалах, барааг худалдан авах явцад гарах үйлчилгээ орно.
86	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	Хий дамжуулах хоолой, төмөр зам, авто зам, усан ба агаарын тээврийн тогтсон хуваарьтай, хуваарьгүй ачаа болон зорчигч тээвэр, агуулах, ачаа, тээшний үйлчилгээ, автомашины зогсоол, гарвааш зэрэг үйл ажиллагаа орно. Түүнчлэн тээврийн хэрэгслийг ажиллуулагч хүнтэй нь түрээслэх үйл ажиллагаа энэ салбарт багтана. Мөн шуудан, холбооны үйл ажиллагаа орно.
87	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	Жуулчид, бусад аялагчдыг богино хугацаагаар байр сууцаар хангах, шууд хэрэглэх зориулалттай хоол хүнс, ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа орно. Энэ салбарт хамраах нэмэлт үйлчилгээний хэмжээ, төрөл нь нэлээд өргөн хүрээтэй байж болно.
88	Мэдээлэл, холбоо	Энэ салбарт мэдээлэл, соёлын бүтээгдэхүүний үйлчилгээ, энэ төрлийн бүтээгдэхүүнийг дамжуулах, тараах үйл ажиллагаа, тухайлбал, холбоо, мэдээллийн технологийн үйл ажиллагаа, мэдээлэл боловсруулах болон мэдээллийн үйлчилгээтэй холбогдох бусад үйл ажиллагаа орно.
89	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Санхүүгийн үйлчилгээний үйл ажиллагаа, даатгал, давхар даатгал, тэтгэврийн санхүүжилтийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйлчилгээг дэмжих үйл ажиллагаа энэ салбарт орно. Холдинг компанийн үйл ажиллагаа, итгэлцлийн үйл ажиллагаа, сангууд болон бусад ижил төстэй санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа зэрэг хөрөнгө эзэмших үйл ажиллагаа мөн энэ салбарт багтана.
90	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Энд лизингийн үйлчилгээ үзүүлэгч, агент, брокерын үл хөдлөх хөрөнгө худалдах, үл хөдлөх хөрөнгө түрээслэх, үнэлгээ хийх зэрэг үйлчилгээ орно. Энэ салбарын үйл ажиллагаа нь төлбөр болон гэрээнд үндэслэн хийгддэг бөгөөд эзэмшигчийн эсвэл лизингээр авсан өмчийг ашиглах үйл ажиллагаа байж болно. Мөн эзэмшигчийн эсвэл лизингээр баригдаж байгаа барилга, байгууламжийг оруулна. Энэ салбарт үл хөдлөх хөрөнгөтэй холбогдох бүхий л үйл ажиллагаа багтана.
91	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Энэ салбарт мэргэшсэн мэргэжил, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа багтана. Эдгээр үйл ажиллагаа нь ахисан түвшний сургалт, мэргэшсэн мэдлэг олгох, хэрэглэгчдэд ур чадвар бий болгох зэрэг сургалтууд орно.
92	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Бизнесийн үндсэн үйл ажиллагааг дэмжих төрөл бүрийн үйл ажиллагааг энд хамруулна. Эдгээр үйл ажиллагааны анхдагч зорилго нь мэргэшсэн мэдлэгийг олгохгүй.

№	Ойлголт	Тодорхойлолт
93	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Энэ салбарт төрийн удирдлагын үйл ажиллагаа орно. Үүнд хуулийн тайлбар, тогтоол, тэдгээрт зохицуулалт, тэдгээр дээр суурилсан үйл ажиллагааны удирдлага, хууль тогтоох үйл ажиллагаа, татвар, улсын батлан хамгаалах, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаа, цагаачлалын үйлчилгээ, гадаад харилцааны үйл ажиллагаа Зэсгийн газрын хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа зэрэг орно. Мөн энэ салбарт албан журмын нийгмийн хамгааллын үйл ажиллагаа багтана.
94	Боловсрол	Энэ салбарт албан сургалтын өдөр, орой, эгнээ, экстернат хэлбэрээр болон албан бус боловсрол (бие даан суралцах, зайн, радио, телевизийн, онлайн, дүйцсэн, сургалт, хөтөлбөр гэх мэт)-оор дамжуулан хүүхэд, насанд хүрэгчдэд боловсрол эзэмшүүлэх, мэргэшлээ дээшлүүлэх сургалтын үйл ажиллагаа орно. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй өмчийн бүх хэлбэрийн байгууллагууд хамрагдана.
95	Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	Энэ салбарт хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа орно. Тухайлбал хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлэг, эмнэлгийн мэргэжилтнүүд, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлдэг нийгмийн ажилтны бусад үйл ажиллагаа хамаарна.
96	Урлаг, үзвэр, тоглоом наадам	Энэ салбарт өргөн хүрээг хамарсан төрөл бүрийн соёлын уулзалт, үзвэр болон олон нийтийг хамарсан сонирхолтой тоглоом наадам, урлагийн тоглолт, музейн үйлчилгээ, мөрийтэй тоглоом, чөлөөт цагийн үйл ажиллагааг хамруулна.
97	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Энэ салбарт гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаа, компьютер, өрхийн болон хувийн хэрэглээний барааны засвар, үйлчилгээ, өмнөх бүлэг, ангид ороогүй хувийн хэрэглээний төрөл бүрийн бусад үйлчилгээ орно.
98	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаанд гэрийн үйлчлэгч, тогооч, зөөгч, цэвэрлэгч, барлаг, шивэгчин, угвагч, цэцэрлэгч, манаач, малчин, ногоочин, байнгын харгалзагч, жолооч, хвалгач, гэрийн хүмүүжүүлэгч, хүүхэд асрагч, гэрийн багш, нарийн бичиг зэрэг ажил, үйлчилгээг айл, өрхөд цалин хөлстэйгөөр хийх үйл ажиллагаа орно. Өрхийн өөрийн хэрэглээнд зориулсан хэмжээ, нэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ энэ дэд салбарт орно.
99	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	Энэ ангид Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн төрөлжсөн байгууллагууд, бүс нутгийн төлөөлөгчид, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Дэлхийн гаалийн байгууллага, Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Нефть экспортлогч орнуудын байгууллага, Европын холбоо, Европын чөлөөт худалдааны нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагын үйл ажиллагаа орно.

**ОРОН СУУЦ**

100	Байшин	Байшин гэж нэг болон олон өрөөтэй, дээвэртэй, гадуураа ханатай, сууриас дээвэр хүртэл хангаар хуваагдсан талбай бүхий орон байрыг хэлнэ. Байшинд орон сууцны байшин, бие даасан тохилог сууц (хаус), сууцны тусдаа байшин (гэр хорооллын хашаанд барьсан тоосгон, шавар болон модон ханатай сууцны байшин), нийтийн болон нийтийн зориулалтын бусад байр орно.
101	Орон сууцны байшин	Бүхэлдээ букуу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг букуу хэд хэдэн өрөө тасалгаа, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. Орон сууцны байшин нь бүх төрлийн дэд бүтцээр хангагдсан, дараах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна. Үүнд: (а) Цэцэрлэг, дулааны шугам сүлжээ болон усан хангамжийн сүлжээтэй; (б) Сууцны дотор бие засах газартай; (в) Сууцны дотор байрлуулсан онгоц, шүршүүртэй; (г) Зориулалтын гал тогоо болон хоол хийх талбайтай байна.

№	Ойлголт	Тодорхойлолт
